

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ
2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ
/2018 оны жилийн эцсийн байдлаар/

2018 оны 12 дугаар сарын 05

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Хариуцах хэлтэс, албад	Хэрэгжилтийн хувь
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ						
1.1. Эдийн засгийн бааз суурийг бүрдүүлнэ.						
1	1.1.1. Улс нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, дүүргийн эдийн засгийн хөгжлийг сайжруулна.	Татварын болон татварын бус орлогын бааз суурийг нэмэгдүүлэх замаар дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх 2018 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 28.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 39.7 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 138.3 хувь, нийслэлийн төсөвт 36.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 34.3 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 95.0 хувь, дүүргийн төсөвт 9.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 13.4 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 138.1 хувь, нийт 74.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 87.4 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 117.3 хувиар биелүүлэхээр байна. Орон нутгийн төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл: Төлөвлөгөө 9.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 13.4 тэрбум төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 138.1 хувиар биелүүлэхээр байна. Үүнийг төрөл тус бүрээр үзүүлвэл:	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	СТСХ	100.0
		<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны орлогын албан татвар - 568.1 сая төгрөг төвлөрүүлэн ажиллахаас 1.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 286.0 хувь • Иргэний үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого - 1.15 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1.64 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 141.7 хувь • Иргэний хадгаламжийн хүүгийн орлого – 2.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 4.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 171.9 хувь • Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар – 1.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2.14 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 132.5 хувь. • Галт зэвсгийн албан татвар 49.9 сая төгрөг төвлөрүүлсэн байна. • Улсын тэмдэгтийн хураамжаар 649.9 сая төгрөг төвлөрүүлэхээс 708.2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 109.0 хувь • Ус, рашаан ашигласны төлбөрөөр 7.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 9.9 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 142.7 хувь • Хог хаягдлын хураамжаар 2.15 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2.152 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.1 хувь • Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөр 50.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 45.5 				

		<p>сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 90.9 хувь</p> <ul style="list-style-type: none"> • Хүү, торгуулийн орлого 700.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 911.9 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 130.3 хувь • Төсөвт байгууллагын өөрийн орлого 172.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 239.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 139.0 хувь • Ангилагдаагүй орлого 40.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 19.1 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 47.7 хувь биелүүлэн ажиллаж, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлсэн байна. 				
2	1.1.2. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн татвар төлөлтийн харъяаллыг шинэчлэн тогтоох асуудлыг судлах, шинээр аж ахуйн нэгж байгуулах асуудлыг дэмжин ажиллана.	<p>Татварын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, татварт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх шат дараалсан арга хэмжээ авах</p> <p>ТЕГ-ийн даргын 2017 оны А/06 дугаар “Татвар төлөгчийг бүртгэх журам, маягтын загвар батлах тухай” тушаалын дагуу Татвар төлөгчийг шинээр бүртгэж, хасалт, шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг хийсэн. Журмын 3 дугаар заалтыг үндэслэн тайлант хугацаанд нийт 825 хуулийн этгээд бүртгэж, холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөн ажилласан. Журмын 8 дугаар заалтыг үндэслэн нийт 1575 ААН-ийн 7875 бүртгэлийн өөрчлөлтийг хийсэн. Тайлант хугацаанд нийт 297 ААН, иргэн НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлснээс борлуулалтын орлогын босго давсан 178, сайн дураараа 119 ААН, иргэн бүртгэж татварын бааз суурийг нэмэгдүүлэн ажиллаж байна. 2018 оны байдлаар шилжсэн аж ахуйн нэгж байгууллага-13, иргэн-23, шилжиж ирсэн аж ахуйн нэгж-5, иргэн-299, шинээр бүртгэсэн иргэн-25086, аж ахуйн нэгж-1120 байна. Шинээр бүртгэсэн иргэд болон аж ахуй нэгж байгууллагуудад тогтмол хийгддэг танхимын 48, ажлын байран дээрх сургалт 52, онлайн сургалт 25 удаа, нийт 125 сургалтыг зохион байгуулж татварын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	СТСХ	100.0
3	1.1.3. Төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан Монгол Улсын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ил тод байдлыг дэмжинэ.	<p>Төсвийн хяналтад байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, шилэн данс болон цахим тайлангийн системийг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах</p> <p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлын хүрээнд дүүргийн харьяа төсвийн 105 байгууллага шилэн дансны мэдээллийг тогтмол хуулийн хугацаанд мэдээлж байна. Нийслэл дэх Төрийн аудитын газар, дүүргийн Дотоод Аудитын албатай хамтран мэдээллийн чанар байдалд хяналт тавин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2017 оны жилийн эцэс, 2018 оны 1, 2, 3 дугаар улирлын хувийн сургууль, цэцэрлэгүүд, өрхийн эмнэлгүүдийн санхүүжилтийн талаархи мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулан ажиллалаа. Дүүргийн харьяа төсвийн байгууллагууд өөрсдийн байгууллагын ажиллагсад болон олон нийтэд мэдээлэх зорилгоор санхүүгийн мэдээллийн самбарыг ажиллуулж хэвшсэн ба ажилтан албан хаагчиддаа тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлийг тайлагнаж, самбар дээрх мэдээллээ сар бүр шинэчлэн байршуулж байна. Төсөвт болон</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	СТСХ	100.0

		<p>орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудад Шилэн дансны тухай хуулийн дагуу Сангийн яамны Дотоод Хяналтын газраас мэдээлэл хийж, байгууллага бүрт дотоод хяналт хариуцсан ажилтан байх талаар болон энэ чиглэлээр ажиллах ажилтнуудад заавар зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн 2017 оны санхүүгийн нэгдсэн тайланг аудитын дүгнэлтийн хамт дүүргийн вэб сайт болон шилэн дансанд тус тус байршуулан ажиллалаа. Дүүргийн харьяа 11 орон нутгийн төсвийн байгууллага, тусгай шилжүүлгийн 97 байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шалган хүлээн авч, Сангийн яамны Э-тайлангийн тусламжтайгаар нэгтгэн гаргалаа. Дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан хүлээн авч баталгаажуулах ажлыг 2018 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж, нийтдээ 8792 тайлан хүлээн авснаас 92.1 хувь буюу 8099 тайланг баталгаажуулсан. Баталгаажаагүй 693 тайлан байгаа нь тоо зөрүүтэй, алдаатай эсвэл аудитаар тайлангаа баталгаажуулаагүй байгууллагууд юм. Тус дүүргийн харьяа тайлан тушаавал зохих 10859 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас 8792 нь санхүүгийн тайлангаа тушааж, тайлан тушаалт 80.9 хувь байна. 2018 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар 13.1 сая төгрөгийн торгуулийн орлого дүүргийн төсвийн дансанд оруулсан. Тайлант хугацаанд 97 байгууллага санхүүгийн тайлангаа залруулах хүсэлт гаргасныг хүлээн авч шийдвэрлэсэн. 2018 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 6980 байгууллага санхүүгийн тайлан ирүүлснээс 6572 тайлан бүрэн баталгаажуулсан ба тайлан хүлээн авалтын хэмжээ 94.1 хувь болж байна. Аж ахуйн нэгжийн тайланг 100.0 хувь цахимаар хүлээн авч, баталгаажуулж байна.</p>				
4		Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх	Цахим худалдан авалт, хувь	50	ХААА	100.0
		<p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1.48 тэрбум төгрөгийн төсөвтэй 41 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөрөнгөөр 540.0 сая төгрөгийн төсөвтэй 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. 2018 онд Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр 33.6 тэрбум төгрөгийн төсөвтэй 17 төсөл арга хэмжээ эрх шилжин ирснийг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Нийт 35.6 төгрөгийн төсөвтэй 64 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрээр www.tender.gov.mn сайтад байршуулан нээлттэй ил тод байдлаар зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.</p>				
5	1.1.4. Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл хяналт, зарцуулалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлнэ.	Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг хагас, бүтэн жилээр зохион байгуулж, бүртгэлгүй болон хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив тусламжийн үр дүнд бий болсон хөрөнгийг цаг тухайд нь бүртгэл, тайланд тусгах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	СТСХ, ТЗУХ	100.0
		<p>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журамд зааснаар жилд 2 удаа эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулан ажилласан. Нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор хяналтын тооллогын ажлын хэсэг байгуулан ажилласан. Тооллогоор Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлтэй нийтийн эзэмшлийн 1921 нэр төрлийн 41.7 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 672 нэр төрлийн 12.4 тэрбум</p>				

		<p>төгрөгийн хөрөнгө эвдэрсэн тул устгалд оруулах тухай албан бичиг нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлээд байна. 2018 онд улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 1.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн данс бүртгэлд бүртгэсэн. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэхь хэсэгт "Эд хөрөнгийг худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах тухай" заасантай холбогдуулан худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сертификаттай сургалтыг дүүргийн төсвийн байгууллагын 85 нягтлан бодогч нарт 2 удаа зохион байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх салбар комиссыг байгуулан ажилласан. Тус ажлын хүрээнд Монгол Улсын Сангийн яам, нийслэлийн Өмчийн харилцааны газартай хамтран дүүргийн төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагуудад 1 удаа, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт 1 удаа, нягтлан бодогч нарт 2 удаагийн сургалтыг зохион байгуулан ажиллав.</p>				
6	1.1.5. Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төрийн сангийн төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэн, төсвийн зарлага санхүүжилтэнд тавих хяналтыг сайжруулна.	Төрийн сангийн төлбөр тооцооны найдвартай байдлыг ханган, төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтын системийг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	СТСХ	100.0
<p>Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төсвийн байгууллагын дансыг нээх, хаах, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын үйл ажиллагааны, төрийн сангийн төлбөр тооцооны журмуудыг мөрдөн ажиллаж байна. Төрийн сангийн нийт 198 байгууллагын 244 дансаар төрийн сангийн үйлчилгээг үзүүлж, ямар нэгэн чирэгдэл гаргахгүй байхаар ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд өдөрт дунджаар 185 төлбөр тооцооны гүйлгээ хийгдэж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт гүйлгээний тоо 26608, хүлээгдэж буй гүйцэтгэлээр үнийн дүн 171.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Тус төрийн сан банкинд байршиж буй дүүргийн төсөвтэй харьцдаг улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын талаарх мэдээллийг хавсралтаар нийслэл дэх Төрийн Аудитын газарт хүргүүллээ. Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийн шинэчилсэн программаар төлбөр тооцоог гүйцэтгэж байна. Шинэчилсэн системд тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн, 1739 бэлтгэн нийлүүлэгчдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, арилжааны банкны дансыг бүртгэж оруулах ажлыг зохион байгууллаа. Төсвийн байгууллагаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийг холбогдох баримт, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу гаргасан эсэхийг хянаж, төлбөр тооцоог баталгаажуулж байна.</p>						

7	1.1.6. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг оновчтой төлөвлөн гүйцэтгэж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.	Иргэдийн саналд тулгуурлан дүүргийн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулж, иргэд олон нийтэд ил тод мэдээлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТГХШХ	70.0
<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 5/3 дугаар тогтоолоор дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 1044.8 сая төгрөгийн хөрөнгөөр 2018 онд гэрэлтүүлэг 7 хороонд, камержуулалт 13 хороонд, явган хүний гүүр, зам, шат шинээр хийх, засварлах ажил 7 хороонд, хүүхдийн тоглоомын талбай байгуулах, засварлах ажил 8 хороонд, чийрэгжүүлэлт, иргэний танхимын тоног төхөөрөмж, тохижилтын ажил 8 хороонд, автобусны буудлын тохижилт 3 хороонд, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт болон бусад 34 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр баталсаны дагуу дүүргийн Засаг даргын А/01 дугаар захирамжаар хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулах үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс албадад өгсөн. Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 21, А/35, А/55, дүүргийн ИТХ-ын хуралдааны 6/08 дугаар тогтоолоор 2018 онд дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх болон он дамжих ажлын жагсаалтад 4 удаа өөрчлөлт оруулан нийт 73 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 2018 онд дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын байршил, тоо хэмжээг газар дээр нь нягтлан үзэж Засаг дарга нараар баталгаажуулан авч, ажлын даалгавар, барааны техникийн тодорхойлолтыг холбогдох хэлтэс, албадтай хамтран боловсруулж батлуулсан. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/14 дүгээр захирамжаар зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо холбогдох хууль журмын дагуу тендерийн баримт бичиг боловсруулан зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан төсөв хийлгэсэн. Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу 2018 онд дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 103.4 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөг бүхий 7 ажлыг /1, 2, 14, 15, 20, 23 дугаар хороодод/ олон нийтийн оролцоотой хэрэгжүүлэхээр төлөвлөснийг дүүргийн Засаг даргын А/362 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны бүрэлдэхүүн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг гүйцэтгүүлсэн. Нийт 73 төсөл арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 65, тодорхой шалтгааны улмаас 8 ажил /Нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламж бүхий бичил тохижилтын ажил-10 дугаар хороо, Хорооны гадна тохижилтын ажил-30 дугаар хороо, Явган хүний гүүр шинээр хийх-22 дугаар хороо, Сагсан бөмбөгийн талбай байгуулах-20 дугаар хороо, Явган хүний гүүр шинээр хийх 9, 25 дугаар хороо, Явган хүний гүүр засварлах 10, 30 дугаар хороо/ 2019 онд дамжин хэрэгжихээр байна.</p>						
8	1.1.7. Дүүргийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл арга	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн хөрөнгө оруулалтад төсвийн бус эх үүсвэр нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТГХШХ	70.0

хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэл, олон улсын байгууллагатай хамтран ажиллах оновчтой хэлбэрт түшиглэн зохион байгуулна	<p>Азийн хөгжлийн банк, Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Good neighbors, HAATZ, Жайка, Швейцарийн хөгжлийн агентлаг, Тайваний хүүхэд гэр бүл дэмжих сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “Хөгжил дэх оролцооны төлөөх холбоо “Жи Си Эс” ТББ, МҮХАҮТ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын Хайлаар дүүрэг, Япон улсын Изүнокүни хот, нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, тус дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүд болон нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч нартай байнгын холбоотой ажиллан, хамтран ажиллах санамж бичиг байгуулан, тэдний дэмжлэгийг авч, хөрөнгө оруулалтын төсвийн бус эх үүсвэр татах ажлыг зохион байгуулав. Үүнд:</p> <p>-Австрийн засгийн газрын тусламжийн 7.0 сая еврогийн санхүүжилтээр хэрэгжих гэрэлтүүлгийн ажлын төсөл Засгийн газар хоорондын хэлэлцээрээр батлагдсан. Барилга хот байгуулалтын яамнаас зарлагдах “Гэрэлтүүлэг үйлдвэрлэн нийлүүлэгч” шалгаруулах тендерт шаардагдах материалыг боловсруулан, нэгтгэж тус яаманд хүргүүлсэн.</p> <p>-Азийн хөгжлийн банкны санхүүжилт 37.0 сая ам долларын өртөг бүхий дүүргийн “Жишиг эмнэлгийн” барилгын ажил үргэлжилж байна.</p> <p>-Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 4 сургууль, 7 цэцэрлэг баригдахаар батлагдсан.</p> <p>-БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 25, 26 дугаар хороонд сургуулийн барилгын эхэлсэн.</p> <p>-Япон улсын Өвсний үндэс төслийн хүрээнд 170.0 сая төгрөгийн өртгөөр 117 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>-90, 127 дугаар цэцэрлэгийн барилгын засвар шинэчлэлийн ажлыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран бүрэн дулаалгын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Төсөвт өртөг 658.7 сая төгрөг.</p> <p>-Азийн хөгжлийн банкны тусламжаар 2.8 сая ам.долларын “Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах нь МОН-9189 төсөл”-ийг дүүргийн 6, 7 дугаар хорооны 300 айлд хэрэгжүүлэхээр төлөвлөн, ажил явагдаж байна.</p> <p>-9 дүгээр сургуулийн ариун цэврийн өрөөний их засварын ажлыг Good neighbors ОУТББ-ын 150.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийсэн.</p> <p>-62 дугаар сургуульд компьютерийн лабораторид 20 ширхэг иж бүрэн компьютер, 1 принтерийн хөрөнгө оруулалтыг 120.0 төгрөгөөр Good neighbors ОУТББ санхүүжүүлсэн.</p>
--	---

1.2. Бизнес эрхлэгчдийг дэмжих замаар татварын орлогыг нэмэгдүүлнэ.

9	1.2.1. Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, дүүргийн бренд бүтээгдэхүүнийг бий болгож зах зээлд тэдний оролцоог бий болгоно.	Дүүргийн бренд бүтээгдэхүүн, шилдэг үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчийг шалгаруулах, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
		“Нийслэлийн Шилдэг инноваци” үзэсгэлэн худалдаанд дүүргийн “Хайнаг толгой хоршоо” өөрсдийн зохион бүтээсэн “Хүнсний бутлуур” тоног төхөөрөмжөөр оролцож, зохион байгуулах хорооны “Онцлох бүтээл” шагнал цом, өргөмжлөлөөр шагнагдлаа. Дүүргийн бренд бүтээгдэхүүн, шилдэг үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчийг шалгаруулах арга хэмжээний хүрээнд үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн, ажлын байртай танилцаж, сонгон шалгаруулалтыг явуулсан. Шалгаруулалтад хамрагдсан 26 иргэн, аж ахуйн				

	нэгжийн бүтээгдэхүүнээс “Байгальд ээлтэй бүтээгдэхүүн”-ээр “Одь тан” ХХК-ий “Халгайтай цай”, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”-ээр “Михачи” ХХК-ий “Өтгөрүүлсэн цэвэр зөгийн бал”, “Эрүүл мэндэд ээлтэй бүтээгдэхүүн”-ээр “Их Монгол урлаач” ХХК-ий “Байгалийн гаралтай бүтээгдэхүүний дэр”-ийг тус тус шалгаруулж, дүүргийн Засаг даргын батламж, мөнгөн шагналаар шагнасан.				
10	Дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих зорилгоор "Цагаан сар", "Алтан намар" үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	Үйлдвэрлэл эрхлэгчид, тоо	50	ХХҮХэлтэс, ХХҮХ	100.0
	Сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Засаг даргын 2018 оны А/21 дүгээр захирамжийн дагуу жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үндэсний бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, хэрэглэгчдэд сурталчлах, үйлдвэрийн үнээр хүргэх зорилгоор “Цагаан сар -2018” үзэсгэлэн худалдааг Е-Мартын Соло Молл худалдааны төвд зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 52 иргэн үндэсний дээл, оёмол сүлжмэл хувцас, алт мөнгөн эдлэл, модон болон гар урлал, сүү цагаан идээ, цай, хэвийн боов, хүнсний бусад бүтээгдэхүүнээр оролцож, 105.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үзэсгэлэн худалдааг TV5 телевизийн 3 суваг, Royal HD телевизээр давтамжтайгаар сурталчилсан. “Алтан намар” төмс, хүнсний ногооны үзэсгэлэн худалдаанд дүүргийн 14 иргэн, 2 аж ахуйн нэгж, нийт 16 тариаланчдыг оролцуулсан. Арга хэмжээний үеэр оролцогчид нийт 237.7тн төмс, хүнсний ногоог 500-4500 төгрөгөөр худалдан, 380.3 сая төгрөгийн борлуулалт хийж, давхардсан тоогоор 50000 орчим иргэдэд үйлчилсэн байна.				
11	Өрхийн болон бичил бизнес, жижиг дунд үйлдвэрлэл, эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид урт хугацаатай, бага хүүтэй зээл олгох, шинээр ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллах	Бизнес, үйлдвэрлэл эрхлэгчид, тоо	300	ХХҮХэлтэс, ХХҮХ	100.0
	Дүүргийн ажил идэвхитэй хайж буй иргэдэд зориулж “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 12 ажил олгогч байгууллагуудтай хамтран Чингис СООСЭ их сургууль дээр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ажил идэвхитэй хайж буй 500 гаруй иргэд хамрагдаж, ажил олгогч байгууллагууд 400 гаруй ажлын байрандаа шууд ярилцлага авч, шалгуур хангасан иргэдийг ажлын байраар хангасан. “Шөнийн гэрэлт гудамж” шөнийн худалдаа, үйлчилгээний арга хэмжээнд дүүргийн жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 5 аж ахуйн нэгж, 7 иргэнийг оролцуулсан. Уг арга хэмжээний үеэр үхэр тэрэгний хэв загвар бүхий үндэсний хэв шинжийг агуулсан явуулын 2 лангууг ажиллуулж, үйлдвэрлэгчид 12 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалж, 1.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Дүүргийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд бараа, бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлж “Сонгинохайрхан аутлет төв”-ийг Пирамид үйлчилгээний төвийн урд 2018 оны 11 сард нээж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Тус төвд 2 иргэнийг ажлын байраар ханган, 100 гаруй үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалж байна.				

12	1.2.2. Дүүргийн баялаг бүтээгчдийг бодлогоор дэмжин эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагаанд үзүүлнэ. дэмжлэг	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд "Ажил олгогчдын уулзалт зөвлөгөөн" зохион байгуулах Дүүргийн Засаг даргын 2018 оны А/330 дугаар захирамжийн дагуу "Сонгинохайрхан-Экспортлогч дүүрэг" ажил олгогчдын уулзалт, зөвлөгөөнийг 450 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хамруулан Корпорейт зочид буудлын хурлын их танхимд зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо Хайлаар хотын Лүмбэн хотын худалдааны төвийн "Сонгинохайрханд үйлдвэрлэв" байнгын борлуулалтын цэгийн талаар танилцуулга хийж, Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотын зочид төлөөлөгчдөд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэгчдийн ноос, ноолууран эдлэл, савхи болон эсгий эдлэл, үндэсний дээл зэрэг 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн гаргасан. Зөвлөгөөний зардалд Засаг даргын Тамгын газраас 2.3 сая төгрөгийг зарцуулж, TV5 телевиз, Royal HD телевизээр сурталчилсан.	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, тоо	50	ХХҮХэлтэс, ХХҮХ	100.0
13	Баялаг бүтээгчдийг гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаанд оролцоход нь дэмжин, хамтран ажиллах Мишээл Экспо үзэсгэлэнгийн танхимд "Улаанбаатарт үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг 2018 оны 4-р сард зохион байгуулсан. Үзэсгэлэнд дүүргийн 26 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, 76.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. "Хичээлийн шинэ жил - 2018" үзэсгэлэн худалдааг 8 цэгт гаргасан. Үзэсгэлэн худалдаанд "Өүлэн менч" ХХК болон жижиг дунд бизнес эрхлэгчид оролцож, ард иргэдэд хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг нэг дороос хямдралтай, үйлдвэрийн үнээр худалдан авах боломжийг бий болгосон. ОХУ, Монгол улс, БНХАУ-ын баялаг бүтээгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг уламжлал болгон зохион байгуулах тухай "Санамж бичиг"-ийн хүрээнд БНХАУ-ын Хөлөнбуйр аймгийн Хайлаар хотод 2018 оны 09 дүгээр сард "Хамтран ажиллах 3 талт гэрээ" байгуулсан. Гэрээний дагуу Хайлаар хотын Лүмбэн их дэлгүүрт 1200м2 талбай бүхий байнгын борлуулалтын цэг бий болгон, 17 нэр төрлийн 118.0 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлсэн. Уг арга хэмжээний үеэр үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, дүүргийн 11 аж ахуйн нэгж, 24 өрхийн үйлдвэрлэгчид 34 нэр төрлийн бүтээгдэхүүн худалдаалж, 200.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. Зохион байгуулах комиссоос Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг өндрөөр үнэлж "Шилдэг бүтээл" шагнал олгосон.	Үйлдвэрлэл эрхлэгчид, тоо	50	ХХҮХэлтэс ХХҮХ	100.0	
14	1.2.3. Өрхийн болон бичил бизнес, жижиг, дунд үйлдвэрлэл, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж, бизнес инкубатор төв болон борлуулалтын нэгдсэн төвийг байгуулна.	Өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдийн төсөл хөтөлбөрийн хүрээнд сургалтад хамруулах "Маркетинг борлуулалт, жижиг, дунд бизнесийн санхүүжилт" сургалтыг 2018 оны 02 дугаар сард зохион байгуулж, 40 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулсан. МҮИС-ийн Старт-ап төслийн багтай хамтран гарааны бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийнүйл ажиллагааг санхүүгээр дэмжих, бизнесийг нь сурталчлахад хэрхэн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах тухай сургалтыг зохион байгуулсан. Арга хэмжээнд дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч эмэгтэйчүүдийн 10 төлөөлөл оролцож, санал бодлоо	Сургалтад хамрагдах иргэн, тоо	300	ХХҮХэлтэс	100.0

	<p>солилцсон. “Монгол ногоо” хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны үр ашиг, шаардлага, хэрэгцээний талаар танхимын цогц сургалтыг өрхийн тариалан эрхлэгчдийг хамруулан 2 удаа Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороон дээр, талбайн сургалтыг 24 дүгээр хорооны тариаланч Даваасүрэнгийн талбайд 1 удаа зохион байгуулсан. Сургалтад 2, 22, 24, 25 дугаар хороодын 42, “Жишиг гудамж”, “Загвар өрх” төслийн 24, нийт 70 орчим иргэдийг хамруулан газар тариалангийн талаарх мэдлэг олгож, зөвлөгөө мэдээллийг өгсөн. Иргэд хашаандаа төмс, хүнсний ногоо тариалж, хэрэгцээгээ хангахаас гадна өрхийн орлогоо нэмэгдүүлэх үр өгөөж, ашиг тусыг таниулсан арга хэмжээ болсон. “Өрхийн тариаланчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” семинарыг “Жишиг гудамж”, “Загвар өрх” төсөлд хамрагдсан 24, өрхийн тариалан эрхлэх сонирхолтой 2 дугаар хорооны 22, нийт 46 өрхийн тариалан эрхлэгчдийг хамруулан Чингис зочид буудлын Их танхимд зохион байгуулсан. Семинараар олон улсын болон орон нутгийн ногоочдын туршлага, арга барил, техник, технологийн хөгжил дэвшлийн талаар мэдээлэл хүргэж, гарын авлага материалаар хангасан. “Иргэдийн оролцоог дэмжих” сэдэвт сургалтыг дүүргийн Иргэний танхимд зохион байгуулсан. Сургалтад дүүргийн газар тариалан, ногоон цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй 60 гаруй иргэдийг хамруулан, үрслэг тариалах, жимс жимсгэнэ тарьж, ургуулах технологи сэдвүүдээр мэдээлэл өгч гарын авлага материалаар хангасан.</p>				
15	<p>Жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж тэдний эцсийн бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлж ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>ХХҮХэлтэс</p>	<p>100.0</p>
	<p>Монгол ногоо хөтөлбөрийг “Фермер эмэгтэйчүүд” ТББ-тай хамтран 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд “Жишиг гудамж” төсөлд 22, 24, 25 дугаар хороодын 3 гудамжны 60 орчим өрх, “Жишиг загвар өрх” төсөлд 5, 7, 20, 24, 26 дугаар хороодын зорилтот бүлгийн 5 өрхийг хамруулж, нийт 70 гаруй сая төгрөгийн багаж хэрэгсэл, хүлэмж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, үр үрслэгийн төв байгуулан өгч, ногооны үрээр ханган, тариалалтын ажлыг газар дээр нь зааж сурган, бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Төсөл хэрэгжүүлж буй 2 жилийн хугацаанд тариаланчид 7328 м2 талбайд тариалалт хийж, 20.5 тн ургац хураан авсан байна. Дүүргийн хэмжээнд 413 өрх, 11 аж ахуйн нэгж 361.1 га-д төмс хүнсний ногоо тариалж, 397.3 га талбайгаас 4561.7 тн төмс, хүнсний ногоо /ил талбай болон хүлэмжээс/ хураан авсан. Өрхийн тариалалтыг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-наас олгосон 3.1 сая төгрөгийн өртөг бүхий 192 кг хүнсний ногооны /шар манжин, лууван, хүрэн манжин, сонгино, сармис, гоньд зэрэг/ үрийг 2, 4, 5, 7, 8, 9, 10, 22, 24, 25, 26, 28 дугаар хороодын 250 гаруй өрхийн тариалан эрхлэх сонирхолтой иргэдэд тараасан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нийслэл хотын хооронд байгуулсан “Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалан эрхлэдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих талаар хамтран ажиллах” санамж бичгийн хүрээнд: 17 дугаар хороонд байрлах асарт 30 иргэнд, 19, 22 дугаар хороодод байрлуулсан чингэлэгт 12, нийт 42 иргэнд төлбөр түрээсгүй үйл ажиллагаа явуулах тухай зөвшөөрөл олгож, дэмжсэн. “Монгол ногоо” хөтөлбөрийн зүгээс 24, 25 дугаар хороодын “Жишиг гудамж” төслийн 30 гаруй өрхийн дунд 24, 29 дүгээр хороодод дулаалгатай 4 улирлын</p>				

		туршид ажиллах боломжтой 2 ногооны мухлаг байгуулж, байнгын борлуулалт хийх боломж олгосон. “Алтан намар-2018” арга хэмжээний үеэр нийт 5 цэгт 60 гаруй ногоочид 601.1 тн ногоо худалдан, 150.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Монгол ногоо төсөл, хөтөлбөрийн “Жишиг загвар өрх” төсөлд хамрагдсан 5, 20, 26 дугаар хороодын зорилтот бүлгийн 3 өрхийн зүтгэлийг өндрөөр үнэлэн, төмс хүнсний ногоо хатаагч тоног төхөөрөмж 1, хүлэмж 2 өрхөд олгож, дэмжин урамшуулсан. Төмс хүнсний ногоо хатаагч тоног төхөөрөмжөөр ногоогоо дахин боловсруулан хатааж, савлан худалдаанд гаргаж эхэлсэн. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага “Жишиг гудамж” төсөлд хамрагдсан 24, 25 дугаар хороодын ногоочдын үйл ажиллагааны үр дүнг HD Монгол, Үндэсний MNB телевизээр олон нийтэд сурталчилсан.				
16	1.2.4. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн, ХАА-н хоршоодын үйл ажиллагааг дэмжих	Мал, амьтныг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс, МХХ	100.0
<p>2019 онд дүүргийн нутаг дэвсгэрийн мал амьтны халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах эм бэлдмэл, оношлогооны био бэлдмэл, халдваргүйтгэлд шаардагдах бодисын захиалга болон вакцинжуулалтад хамруулах мал, амьтны судалгааг гарган, НМЭГ-т хүргүүлсэн.</p> <p><u>Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд:</u> Дүүргийн Засаг даргын 2018 оны А/225 дугаар захирамжийн дагуу мал, амьтны гоц халдварт шүлхийн 2 удаагийн, төл малын бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 удаагийн вакцинжуулалтад “Буян хөхий” ХХК 1049 өрхийн 47660 мал амьтан /давхардсан тоогоор – 80.6 л вакцин/, 198 өрхийн 2100 төл /2.1 мянган тун вакцин/, “Рээ” ХХК 350 өрхийн 8322 мал, амьтан /давхардсан тоогоор-28.2 л вакцин/, 210 өрхийн 2584 төл /2.6 мян.тун/ “Бамбуу” ХХК 1090 өрхийн 50140 /84.8л вакцин/ нийт 2897 өрхийн 110806 /давхардсан тоогоор/ толгой мал, амьтан хамруулж 24.6 сая төгрөгийн өртөг бүхий шүлхийн 193.6 л, бруцеллэзын 9.08 мян.тун вакцин зарцуулсан. Вакцинжуулалтын ажлыг 98.4 хувьтай гүйцэтгэж, 2.5 сая төгрөг зарцуулсан.</p> <p><u>Халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний хүрээнд:</u></p> <p>15 нэр төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад “Буян хөхий” ХХК 47150 толгой мал хамруулахаас 48744-г хамруулж, 99.0%, “Рээ” ХХК 180 өрхийн 20100 толгой мал амьтан хамруулахаас 19187 хамруулж, гүйцэтгэл 95.5%.</p> <p><u>Паразитах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд:</u> малын угаалганд “Буян хөхий” ХХК 13000 толгой мал, амьтан хамруулахаас 11200 хамруулж 93.9%, “Рээ” ХХК 4000 толгой мал амьтан хамруулахаас 3703 хамруулж гүйцэтгэл 92.6%.</p> <p><u>туулгалтанд:</u> “Буян хөхий” ХХК 10000 толгой мал, амьтан хамруулахаас 12500 хамруулж, 102.5%, “Рээ” ХХК 5000 толгой мал амьтан хамруулахаас 5000 хамруулж гүйцэтгэл 100%-тай тус тус гүйцэтгэсэн байна. Малд үзлэг тандалт хийх, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих тухай дүүргийн Засаг даргын 2018 оны А/135 дугаар захирамжийн дагуу үзлэг тандалтыг явуулж, 0.9 сая төгрөг зарцуулсан. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж “Буян хөхий” ХХК малын хашаа саравч, гахай шувууны 58 байрны 17900м2, тэжээлийн агуулах, тээврийн хэрэгслийн 35700м2 нийт 53600м2 талбайд, “Рээ” ХХК Нарийний хэсэг, Шар хадны хэсгийн малтай өрхүүдийн малын хашаа саравч, өтөг бууцны 20000м2, “Бамбуу” ХХК Рашаант, Жаргалант тосгоны айл өрхүүдийн хашаа, хогийн цэгт ариутгал халдваргүйтэл болон малд үзлэг тандалтыг хийж гүйцэтгэсэн.</p>						

17		“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
<p>Дүүргийн хэмжээнд нийт 1543 өрхийн 79713 толгой мал байна. Үүнээс: Сүүний чиглэлийн 15-аас дээш үнээтэй-183, 50-иас дээш үнээтэй-5, мах сүүний чиглэлийн 15-аас дээш үнээтэй-16, 50-иас дээш үнээтэй 2 нийт 206 иргэн, аж ахуйн нэгж эрчимжсэн мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж, 7 төрлийн үүлдрийн сүүний чиглэлийн 5826, махны чиглэлийн 437, мах сүүний чиглэлийн 339 үхэр, импортоор оруулж ирсэн мах, ноосны чиглэлийн 5 төрлийн үүлдрийн 664 хонь, нутгийн омгийн махны чиглэлийн 2267 хонь, 1620 ямаа үржүүлж байна. 2018 оны нийлүүлгийн улиралд үржилд орох хээлтэгч, хээлтүүлэгчийн тоо болон үржүүлж буй үүлдэр, омгийн малын судалгааг гарган НХХААГ-т хүргүүлсэн. Мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, олон залуучуудыг ажлын байраар хангасан, мал маллах арга ухаанд сургасан, хөдөө аж ахуйн салбарт шинэлэг технологи нэвтрүүлсэн зэрэг амжилттай ажиллаж байгаа малчид, фермерүүдийг дэмжин уламжилснаас 21 дүгээр хорооны “Тайшир өргөө” ХХК “Улсын тэргүүний фермер”-ээр, 21, 32 дугаар хорооны 4 фермер “Нийслэлийн тэргүүний фермер”-ээр тус тус шалгарсанд хүндэтгэл үзүүлсэн. Сүүний чиглэлийн үнээний эрчимжсэн фермерийн аж ахуйн үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор ХХААХҮЯ-наас зарласан ТСШ-18.04.18/ТНН төсөлд хамрагдах хүсэлт гаргасан “Хоргын хүү дэлгэрэх” ЗГБХНөхөрлөл болон 2 малчны хүсэлтийг ХХААХҮЯ, Мал хамгаалах санд дэмжин уламжлав. 21 дүгээр хорооны Нарийний хэсэгт “Сүү” ХК-ий 5 тоннын хүчин чадалтай хөргөлттэй тасаг 1, “АПУ Дэйри” ХХК-ий 1, “Тесо трейд” ХХК-ий 1, Жаргалант тосгонд “АПУ Дэйри” ХХК-ий 1 нийт 5 цэгт малчдын гар дээрээс сүү худалдан авч байна.</p> <p><u>“Жи Си Эс” ТББ-тай хамтран 2017-2020 онд “Фермерийг хөгжүүлэх-үүлдрийг сайжруулах” төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу:</u></p> <p>2018 онд 200 үхэрт зохиомол хээлтүүлэг хийхээр төлөвлөснөөс 21 дүгээр хорооны 28 малчны 136 үхэрт хар тарлан цэвэр үүлдрийн хээлтүүлэг хийгдэж, 70 хувийн хэрэгжилттэй байна. Уг ажилд төслөөс 10.0 сая төгрөг зарцуулсан байна. 21 дүгээр хорооны 105 малчдад зохион байгуулсан 3 удаагийн сургалтаар сүүний үхрийн үүлдэрлэг байдал, ашиг шимийг нэмэгдүүлэх боломж, сүүний үхрийн аж ахуйг нөхөн үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөөр дамжуулан үр ашигтай эрхлэх боломж, малын эрүүл мэндийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга, фермерийн үйл ажиллагааг сурталчлах зэрэг сэдвүүдээр мэдээлэл хүргэж, “Сүүний үхрийн үүлдэр, ашиг шимийг сайжруулах арга зам бол зохиомол хээлтүүлэг” ном, хуурцаг тараасан. Гарын авлага материал болон бусад зардалд төслөөс 40 гаруй сая төгрөг зарцуулсан байна. 21 дүгээр хорооны малчдад Малын генетик нөөцийн тухай хууль болон бусад журам, Жи Си Эс ТББ хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаар танилцуулга хийж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх шаардлага, ашиг тусын талаар мэдээ, мэдээллийг хүргэсэн. Сургалтад оролцсон малчдад 21 дүгээр хорооны “Хоргын хүү дэлгэрэх” ЗГБХНөхөрлөлийн сүүний чиглэлээр хөгжүүлж буй фермерийн үйл ажиллагааг танилцуулан, туршлага солилцох, судлах арга хэмжээг зохион байгуулж, Малчин, Рояал телевизээр сурталчилсан. 21 дүгээр хорооны Нарийны хэсэг, Шар хад, Ногоон толгойд мал аж ахуй эрхэлж буй малчидтай малын тоо толгойноос хамааран 1.5-2 га газрыг 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан, ногоон тэжээлийн тариалалт эрхлүүлэх ажлыг 2017 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Энэхүү арга</p>						

	<p>хэмжээний хүрээнд 80 гаруй иргэд Ногоон толгой, Шар хад, Нарийны хэсэгт 143.5 га-д ногоон тэжээл тарьсан. Нийт 800-1600 боодол буюу 30-65 орчим тн ногоон тэжээл хураан авсан. Дүүргийн хэмжээнд малчдын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн хэрэгцээ тэжээлийн нэгжид шилжүүлснээр 14992.2тн байна. Энэ жилийн хувьд малын тарга хүч дунджаар 80.0 хувьтай, малчдын өвс хадлан тэжээл бэлтгэл, татан авалт 60.0 хувь, худгийн бэлэн байдал 99.2 хувь, малын усан хангамж 98.3 хувь, малчин өрхийн хашаа бууцны хангамж 98.3 хувь, өрхийн өвөлжилтийн бэлтгэл 84.1 хувь, өвөлжилтийн бэлтгэл хангасан ерөнхий байдал 89.5 хувьтай байна. Өвөлжилтийн мэдээ тайланг НХХААГ-т хүргүүлсэн.</p>				
18	Хөдөө аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
	<p>Малын түүхий эдийг дотоодын үйлдвэрт тушаасан, арьсны урамшуулалд хамрагдах 8 малчны холбогдох материалын бүрдлийг нэгтгэж, НХХААГ-т уламжлан шийдвэрлүүлэв. 21 дүгээр хорооны 40 малчдыг Дээдийн шаргал, Өрмөн шаргал хоршоонд нэгтгэж, дундын өмчит сүү үйлдвэрлэх цех байгуулж, хүлээлгэн өгсөн. Уг цех нь 1 өдөрт 3 тн сүү боловсруулан, савлах хүчин чадалтай бөгөөд хоршооны гишүүдээс 2 болон мэргэжлийн чиглэлээр /технологич инженер, хүнсний эрүүл ахуйч/ 2, нийт 4 хүнийг тогтмол ажлын байртай, цөөн тооны малтай малчид сүүгээ тогтмол нийлүүлэх цэгтэй болох боломжуудыг бүрдүүлсэн. 2018 онд "Өрмөн шаргал" хоршоонд 5 өрхийг нэмж элсүүлэн, үүлдэр сайтай 20 үхэр олгож, хоршоологчдын гишүүдийн тоо болон хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлсэн. Хоршоонд элссэн болон цаашид элсэх сонирхолтой 60 гаруй малчдад мэдлэг, мэдээллийг олгох сургалтыг 2 удаа явуулсан.</p>				
19	Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд байгаа малыг гаргах ажлыг зохион байгуулах	Гаргах мал, толгой	4281	ХХҮХэлтэс	100.0
	<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Агаарын бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай", нийслэлийн Засаг даргын "Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хязгаарыг тогтоох тухай" 2017 оны А/18 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүгийн дэмжлэг авч, хөдөө орон нутагт мал аж ахуй болон газар тариалан эрхлэн суурьших хүсэлтэй 12 хорооны 96 өрхийн судалгааг хавсралтын дагуу гаргаж, НХХААГ-т 08/523 тоот албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 85 дугаар тогтоол, нийслэлийн нутаг дэвсгэрт малын халдварт, гоц халдварт өвчин тархах, халдвар дамжих эрсдлээс сэргийлэх болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд хориглосон бүсээс мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлж, малын хашаа саравчийг буулгах, ариутгал халдваргүйтэл хийх ажлыг зохион байгуулж ажилласан. Үүнд: -"Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хориглосон бүсээс мал амьтныг гаргах тухай" зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, мал бүхий хороод, бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажилласан. -"Мал нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай" дүүргийн Засаг даргын 2018 оны А/173 дугаар захирамжийн хүрээнд: Газрын алба, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсүүд, мал бүхий хороодтой хамтран 13 хорооны 127 өрхөд нэгдсэн унаагаар үйлчлэн, газар олгох, тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэн, 2.6 сая</p>				

		<p>төгрөг зарцуулсан.</p> <p>-Дүүргийн Засаг даргын 2018 оны А/258 дугаар захирамжийн дагуу тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хуулийн хугацаанд хэрэгжүүлээгүй мал бүхий иргэдэд хугацаатай албан шаардлага өгч, малыг албадан гаргах арга хэмжээг авч ажилласан.</p> <p>-Мал бүхий хороодын малчидтай хороо тус бүр дээр уулзалт зохион байгуулж, холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулж, албан шаардлага мэдэгдэл, мэдээллийг өгч, малчдад сэрэмжлүүлэг, зөвлөмжийг тараасан.</p> <p><u>Хэрэгжилт:</u> Хориглосон бүсийн 13 хорооны 221 өрхийн 6021 толгой малаас 11 хорооны 212 өрхийн 5761 толгой малыг гаргасан. Гүйцэтгэл 95.7 хувьтай. 22 дугаар хорооны Шар цэцэгтийн хөндийд 7 өрхийн 246, ээмэгжүүлсэн мал бүхий 2 өрхийн 14 нийт 9 өрхийн 260 толгой мал байна. Хууль тогтоомжийн хэрэгжилт, шаардлагыг эсэргүүцсэн Шар цэцэгтийн хөндийд суурьшиж байгаа малтай иргэдийн газарзүйн байрлал, онцлог, иргэдийн өргөдөл хүсэлт, эрүүл мэндийн нөхцөл шалтгааныг судлан, 22 дугаар хороонд хэсэгчилэн зөвшөөрөгдсөн бүс тогтоох, 32 дугаар хорооны Мал бордох, Баруунтүрүүн, 384-н гармын нутаг дэвсгэрийг мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс болгохыг дэмжин уламжилж, шийдвэрлүүлэх тухай саналыг НХХААГ, УБХЗАА-нд 03/2266 тоот, 32 дугаар хорооны Мал бордохын 28 өрхийн 1566 гахай, Баруунтүрүүний 7 өрхийн 125 гахай шувууны дэлгэрэнгүй судалгааг 08/2333 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд байгаа мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай дүүргийн Засаг даргын 2018 оны А/389 дүгээр захирамжийн дагуу үлдсэн мал бүхий иргэдийг гаргах, малын хашаа саравчийг буулгах, өтөг бууцыг цэвэрлэн тээвэрлүүлэх ажлыг гүйцэтгэж, мал эмнэлгийн “Буян хөхий” ХХК нийт 9750м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн. Хэрэгжилтийг 96.7 хувьтай хангуулж, 1.1 сая төгрөг зарцуулсан.</p>				
20	1.2.5. Малын захыг мах боловсруулах үйлдвэрийн хамт байгуулж, мал эмнэлгийн ариун цэврийн шаардлагад нийцсэн, баталгаат бүтээгдэхүүн нийлүүлнэ.	Малын захыг мах боловсруулах үйлдвэрийн хамт байгуулах боломжийг судлах, иргэн, аж ахуйн нэгжийн санал санаачлагад дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
		<p>Малын зах, мах боловсруулах үйлдвэр байгуулах үйлдвэрийн байршлыг 32 дугаар хорооны Эмээлтийн баруун талд сонгож, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/516 дугаар захирамжаар НХХААГ-ын эзэмшилд 15 га газар олгосон. НХХААГазар “МБҮ трейд” ХХК-тай төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан. Гүйцэтгэл 70.0 хувьтай явагдаж, гадна талбайн ажил хийгдсэн байна. 361-н гарам, Эмээлт, Тахилтад дулааны аргаар мах боловсруулах 15 үйлдвэр шинээр ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс стандартын болон бусад холбогдох хууль журмын хэрэгжилтийг хангасан 10 аж ахуйн нэгжтэй Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлийн гэрээ байгуулсан. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/476 дугаар захирамжийн дагуу явуулсан хяналт шалгалтаар 5 аж ахуйн нэгжид илэрсэн зөрчил дутагдлыг арилгах хугацаатай үүрэг чиглэлийг өгсөн.</p>				

21	1.2.6. Худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээний стандартыг мөрдүүлж ажиллана.	<p>Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудыг аттестатчилах ажлыг зохион байгуулж, стандартыг мөрдүүлэх</p> <p>”Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчилалын шалгалт явуулах тухай” удирдамжийн дагуу бэлтгэл ажлыг хангуулах, шалгах чиглэлийн талаархи хурлыг Соёмбо кино театрт 150 гаруй аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгуулсан. Дүүргийн Засаг даргын А/193 дугаар захирамжийн хүрээнд “Согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллыг зохион байгууллаа.</p> <p><u>Нийтийн хоолны чиглэлээр:</u> Хоол үйлдвэрлэлийн 64 объектоос 12 газар үйл ажиллагааны чиглэл өөрчлөн, үйл ажиллагаагаа зогсоож, 2 аж ахуйн нэгж өөр дүүрэгт үйл ажиллагаа явуулж, 3 аж ахуйн нэгж 2017 онд тусгай зөвшөөрлөө сунгуулж, 47 газар хяналт шалгалтад хамрагдлаа. Ангиллаар нь авч үзвэл ресторан 19, баар 22, кафе 6 хамрагдсан байна. Үүнээс 15 нь орон сууцны 1 давхарт үйл ажиллагаа явуулж байна. “Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага” MNS 4946:2005 стандартын шаардлагыг 90.0 хувиас дээш хангасан байдлыг шалгахад 22 буюу 47.0 хувь нь стандартын шаардлагыг зохих түвшинд буюу 80.0-90.0 хувьтай, 23 буюу 49.0 хувь 60.0-80.0 хувьтай хангаж байна. 2 буюу 4.0 хувь нь 50.0 хувиас доош буюу стандартын шаардлага хангахгүй байна. Шалгалтын явцад нийт 109 зөрчил илрүүлж 78-г арилгуулж, 6 иргэнд 1.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний 41 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг сунгах, үйл ажиллагаагаа зогсоосон 18 ААН, стандартын шаардлага хангахгүй 2 ААН-ийн тусгай зөвшөөрлийг түр түтгэлзүүлэх, өөрсдийн хүсэлтээр 3 ААН-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг УБХЗАА-нд хүргүүлж ажилласан.</p> <p><u>Худалдааны салбарын чиглэлээр:</u> Аттестатчиллын шалгалтад нийт 204 аж ахуйн нэгж хамрагдсанаас тусгай зөвшөөрөл сунгах 112, урьдчилан сунгагдсан байсан 17, үйл ажиллагаа нь зогссон болон чиглэлээ өөрчилсөн 53, стандартын шаардлага хангахгүй 15, тусгай зөвшөөрлийг түр түтгэлзүүлэх 7 аж ахуйн нэгж хамрагдлаа. Шалгалтын явцад “Сувадизм” ХХК-ий Тумбааш худалдааны төвд 3.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 3 аж ахуйн нэгж зөвшөөрөлгүй тамхи худалдаалж байсныг хурааж зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авсан. 56 аж ахуйн нэгжид хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулж ажилласан.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
22		<p>Худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах</p> <p>Нийтийн эзэмшлийн зам талбайд зохих зөвшөөрөлгүй чингэлэг байршуулсан, ТҮЦ, чингэлэгт хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй 33 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт хийж, гарсан зөрчлийг газар дээр нь арилгуулж, хугацаат үүрэг даалгавар өгч, газар чөлөөлөх арга хэмжээ авч хамтран ажиллаа. Төлөвлөгөөт бус удирдамжит хяналт шалгалтыг 12 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл үйлчилгээний 8, худалдааны 8 аж ахуйн нэгжийг хамруулан явуулсан.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс, МХХ	100.0

	Шалгалтаар зөрчил бүхий 2 аж ахуйн нэгж байгууллагад Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу 200.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан, 2 аж ахуйн нэгжид хугацаатай үүрэг даалгавар өгч, нийтийн хоолны 3, орон сууцны нэг давхарт үйл ажиллагаа явуулж байсан 3 ААН-ын тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг УБХЗАА-нд хүргүүлсэн. Шалгалтаар 2 аж ахуйн нэгж зөвшөөрөлгүй тамхи худалдаалж байсныг хурааж, зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авсан. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 205 дугаар тогтоолоор батлагдсан нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тусгай зөвшөөрөл сунгуулах 63, шинээр авах 22, ААН-ийн анхан шатны хяналт хийж, уламжлан шийдвэрлүүлсэн. УБХЗАА-аас архины тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан 13 аж ахуйн нэгжийн нэрс ирүүлсний дагуу хорооны Засаг даргатай хамтарсан ажлын хэсэг хяналт тавьж саналыг хүргүүлсэн.				
23	Аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
	Аялал жуулчлалын чиглэлээр 15 зочид буудал, 70 дэн буудал, 12 амралтын газар нийт 97 иргэн, аж ахуйн нэгж мэдээллийн санд бүртгэлтэй байна. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын дагуу зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах, сунгуулах хүсэлт гаргасан 60 (зочид буудал 15, дэн буудал 45) аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007 стандарт, Зочид буудлын үйлчилгээний зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4588:2008 стандартын биелэлтийн шалгалтыг хийж хууль, тогтоомж, стандартын тухай зөвлөгөө өгч ажиллав. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/96, А436 дугаар захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа саун, зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулав. Шалгалтад давхардсан тоогоор 5 саун, 14 зочид буудал, 91 дэн буудал хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчлийг үндэслэн 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, 24 аж ахуйн нэгжид 4.0 сая төгрөгийн торгууль ногдуулж барагдуулсан. Илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар 71 иргэн, аж ахуйн нэгжид 197 хугацаатай үүрэг даалгавар /давхардсан тоогоор/ өгч, биелэлтийг хангуулж ажилласан.				
24	Худалдаа, үйлчилгээний салбарт мөрдөгдөх хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийг ААНБ-дад сурталчилж, гарын авлага материалаар хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
	Аялал жуулчлалын чиглэлээр: “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” авах, сунгуулах, Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулахаар хүсэлт ирүүлсэн 144, 3 удаагийн төлөвлөгөөт болон бусад хяналт шалгалтад хамрагдсан 284, холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан 2 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт оролцсон 40, нийт 468 иргэн, аж ахуйн нэгжид худалдаа, үйлчилгээний салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж,				

	<p>үйлчилгээний стандартын тухай сургалт, сурталчилгаа хийсэн.</p> <p><u>Худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр:</u> Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газрууд болон худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг газруудын ажиллах цагийн хуваарийг шинэчлэх талаарх санал асуулгын хэлэлцүүлгийг дүүргийн 32 хорооны худалдаа, үйлчилгээ эрхлэгч болон иргэдийн дунд зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт 356 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оролцлоо. Хэлэлцүүлгийн явцад гарсан саналыг нэгтгэн 02/1370 дугаар албан бичгээр УБХЗАА-нд хүргүүлсэн. НИТХТ-ийн хуралдаанаас “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын төслийн хэлэлцүүлгийг дүүрэг, нийслэлд зохион байгуулах тухай тогтоолын дагуу төслийн хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, иргэдийн төлөөлөл нийт 200 гаруй хүн оролцлоо. Хэлэлцүүлэгт оролцогч аж ахуй нэгж, иргэдийн саналыг нээлттэй сонсож, мөн хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос бичгээр санал хүлээн авсан бөгөөд саналыг нэгтгэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлсэн. Худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг баталж, мөрдүүлэх 2 дахь удаагийн хэлэлцүүлгийг 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт дүүргийн 33 ААНБ хамрагдаж бичгээр-88, амаар-12 ААНБ саналаа өгсөн. УБХЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран “Худалдааны тухай хууль”-ийн хүлээлт ба салбарын өнөөгийн байдал-2018 бизнес эрхлэгчдийн чуулган Туушин зочид буудлын хурлын танхимд зохион байгуулагдсан. Чуулганд худалдааны 35 аж ахуйн нэгжийг оролцуулсан.</p> <p><u>Авто засвар болон бусад үйлчилгээний чиглэлээр:</u> Хоёрдогч түүхий эд худалдан авагчдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтад хамрагдсан 14 хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгээс хулгайн байж болзошгүй аккумуляторуудыг хураан авч, эд зүйлээ хулгайд алдсан хохирогч нарт таниулах үйл ажиллагааг явуулсан. Хоёрдогч түүхий эд авах үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хууль, журмыг сурталчлах, мэдээ мэдээллийг хүргэх сургалт зохион байгуулсан. “Хог хаягдлын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэгт 30 гаруй иргэн аж ахуйн нэгжийг оролцуулсан. Нийслэлийн тээврийн газартай хамтран зохион байгуулсан сургалтад 22, 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт авто засвар, авто угаалгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 20 аж ахуйн нэгжийн захирал, ажиллагсдыг, дугуй засварын үйл ажиллагаа эрхэлдэг 5 иргэнийг хэлэлцүүлэгт хамруулж, орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулж байх талаар болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хүргэж, мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчилсан.</p>				
25	<p>Авто засвар болон бусад үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>ХХҮХэлтэс</p>	<p>100.0</p>
<p>Дүүргийн хэмжээнд авто үйлчилгээний нийт 312 иргэн, аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/277 дугаар захирамжийн хүрээнд авто засвар, авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгжүүдэд хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулсан. Шалгалтад 200 иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдаж, зөрчил бүхий 43 иргэн, аж</p>					

		<p>ахуйн нэгжид мэдэгдэх хуудас өгч, 14 аж ахуйн нэгж байгууллага, иргэнд нийт 11.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, “Албан шаардлага”-ыг 21 иргэнд өгсөн. Илэрсэн зөрчлүүдийг арилгах талаар 40 иргэн, аж ахуйн нэгжид 58 хугацаатай үүрэг даалгавар өгч, 26 зөрчлийг газар дээр нь арилгуулж биелэлтийг шалгалтын хугацаанд тооцон ажилласан. 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт авто худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 16 аж ахуй нэгжид хяналт шалгалт явуулж “Авто үйлчилгээний ангиллын гэрчилгээ” аваагүй аж ахуй нэгжид мэдэгдэх хуудсыг хүргүүлж ажилласан. “Хяналт шалгалт зохион байгуулах тухай” дүүргийн Засаг даргын 2018 оны А/06, А/235, А/444 дүгээр захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, явган хүний зорчих хэсэг, гарц болон автобусны буудлууд дээр байрласан Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн үйл ажиллагаанд 4 удаа хяналт шалгалт зохион байгуулсан. Шалгалтаар зөрчил бүхий 110 иргэнд сануулах, анхааруулах зэрэг холбогдох арга хэмжээнүүдийг авч ажилласан. Энхтайваны өргөн чөлөөнд байрлах 47 ТҮЦ-нд шаардах хуудас өгч, 38 ТҮЦ-ийг нүүлгэн шилжүүлсэн. Зөрчлийн тухай хуулийн 5.1.1.д заасны дагуу 15 иргэнийг нийт 0.3 сая төгрөгөөр торгож, 20 дугаар хорооны Энхжин худалдааны төвийн баруун талд явган хүний зам дагуу байрлах төмрийн худалдааг нүүлгэн шилжүүлж, зөвшөөрөлгүй байрласан ТҮЦ-ийг ачиж зөөвөрлөсөн.</p>				
26	1.2.7. Баянхошуу, Толгойт бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулах санаачлагыг дэмжинэ.	Стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулах иргэн, аж ахуйн нэгжийн санал, санаачлагыг дэмжин, хамтран ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
		Баянхошуу бүсэд 7 дугаар хороонд “Үлэмж стар хаус” ХХК-ий Гэгээ худалдааны төв, “Таац алт” ХХК-ий Таац алт худалдааны төв, Толгойт бүсэд 1 дүгээр хороо “Зүүн алдар” ХХК-ий Тунгалаг худалдааны төв, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Алтан жолоо трейд” ХХК-ий Сансар худалдааны төв зэрэг томоохон худалдааны төвүүд байгуулагдан дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй гэрээ байгуулсан. Гэр хорооллын иргэдэд худалдааны олон төрлийг ойртуулан дүүргийн 95 иргэнийг ажлын байраар хангаж ажиллаж байна.				
27	1.2.8. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй, баталгаат байдлыг хангахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.	Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн ААН-ийн хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс, МХХ	100.0
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/96 дугаар захирамжаар дүүргийн 1-5, 18, 19, 20, 21, 22, 26, 27, 32 дугаар хороодын нутаг дэвсгэрийн үйл ажиллагаа эрхэлж буй согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад хяналт, шалгалтын ажлыг зохион байгууллаа. Шалгалтад хамрагдах 94 объектоос 26 аж ахуйн нэгж нь үйл ажиллагааны чиглэл өөрчлөн, үйл ажиллагаагаа зогсоосон болон тухайн өдөр ажиллаагүй, засвартай үйл ажиллагаагаа түр зогсоосон байсан бөгөөд 68 аж ахуйн нэгж нь хяналт шалгалтад хамрагдлаа. Ангиллаар нь авч үзвэл: Ресторан 26, баар 34, кафе 8 хамрагдсан байна. Шалгалтын явцад нийт 51 зөрчил илрүүлж 38-г арилгуулж, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн				

	<p>холбогдох заалтаар 7 газарт 0.7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Шалгалтад хамрагдсан газруудад эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал эзэмших талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Давсны зохистой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний танилцуулах уулзалт 2018 оны 01 дүгээр сард ХХААХҮЯ-ны хурлын танхимд зохион байгуулагдаж, дүүргийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 20 ААН, иргэнийг оролцуулсан. “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээ нь 2 үе шаттай, 1 дүгээр үе шат нь нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдаж, одоогоор 101, 112, 226 дугаар цэцэрлэгүүд тус арга хэмжээнд оролцсон. Тус дүүргийн 112 дугаар цэцэрлэгийн хамт олон “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг дэмжье” I дүгээр шатны арга хэмжээнд ГРАН ПРИ шагналыг хүртсэн. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн дунд хүнсний бүтээгдэхүүний аюулгүй, баталгаат байдлыг хангахад чиглэгдсэн сургалтыг Драгон төвийн 6 давхарын зааланд дүүргийн зохион байгууллаа. Сургалтад 180 гаруй аж ахуй нэгж хамрагдсан.</p>				
28	<p>Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS4946:2005” стандартыг мөрдүүлж, хяналт тавьж ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>ХХҮХэлтэс, МХХ</p>	<p>100.0</p>
<p>Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх удирдамжийн хүрээнд хяналт шалгалтын ажлын зохион байгууллаа. Шалгалтад төрийн өмчийн 23, төрийн бус өмчийн 6 ерөнхий боловсролын сургууль, нийт 29 байгууллага хамрагдсан. Дээрх 29 сургуулийн хоолны газраас 23 буюу 79.3 хувь нь зориулалтын байртай, 6 буюу 20.7 хувь нь зориулалтын бус байранд хоол үйлдвэрлэл явуулж, 25 буюу 86.2 хувь нь “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг, 4 буюу 13.8 хувь нь цайны газраар багш, сурагчдад үйлчилгээ үзүүлж, 3-7 хүнийг ажлын байраар хангаж ажиллаж байна. Шалгалтаар нийт 150 зөрчил илрүүлж, 56 буюу 37.3 хувийг шалгалтын явцад арилгуулж ажиллалаа. НМХГ-ын төв лабораторид 32 сорьц дээж шинжлүүлж, лабораторийн сорилтын дүнгээр эерэг сорьцтой 4, улсын байцаагчийн 14 дүгнэлт гаргаж шалгагдсан байгууллагуудад хүргүүлсэн. Шалгалтын явцад тус хоол үйлдвэрлэлийн газруудад илэрсэн зөрчлийг арилгуулахаар 5 байгууллага, аж ахуй нэгжид 1.2 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн аж ахуйн нэгж, байгууллага, бизнес эрхлэгчид болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлага, тогооч нарт “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP, GHP/ нэвтрүүлэх нь” сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт 178 ААНБ-ын төлөөлөл хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд “Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь” сургалтыг 12 дугаар сургуулийн урлаг зааланд зохион байгууллаа. Тус сургалтад төрийн өмчийн болон төрийн бус өмчийн 75 цэцэрлэг оролцож, “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний талаар танилцуулсан. Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй</p>					

		холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулидад хяналт шалгалтыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлийн талаар цаашид анхаарч ажиллах талаар мэдээлэл чиглэл хүргэх болон лаборатори сургалтыг Чингис соосэ сургуулийн зааланд 09 дүгээр сард зохион байгууллаа. Сургалтад 68 байгууллага хамрагдсан.				
29	1.2.9. Эрүүл соёлтой үйлчилгээ үзүүлдэг бизнесийн байгууллагыг дэмжинэ.	Худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ, авто засварын чиглэлээр соёлтой үйлчилгээ үзүүлэн, стандарт хангаж үйл ажиллагаа явуулж буй байгууллагыг шалгаруулах, сургалт, өдөрлөг, уралдаан тэмцээн зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХэлтэс	100.0
		“Дүүргийн аварга үсчин, гоо засалч”-ыг шалгаруулах ажил мэргэжлийн уралдааныг 5 төрлөөр зохион байгуулсан. Ажил мэргэжлийн уралдаанд 15 салоны 47 үсчин, гоо засалч оролцсон ба төрөл тус бүрээр эхний 3 байр эзэлсэн оролцогчдод өргөмжлөл, медаль, мөнгөн шагналыг гардуулсан. Мөн “Шилдэг эрэгтэй модель”, “Шилдэг эмэгтэй модель”, “Шилдэг салбар”-ыг шалгаруулж өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнасан. Ахуйн үйлчилгээний салбарын үйлчилгээний тав тухтай орчинг бүрдүүлсэн соёлтой, найрсаг үйлчилгээтэй аж ахуйн нэгжээр 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн Х.Баасансүрэнгийн “Сондор” салон 2017, 2018 онд дараалан шалгарч, дүүргийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнагдсан. Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдийн дунд салбарын орчин үеийн чиг хандлагыг таниулах, хууль эрх зүй, стандартын зохистой хэрэглээг хэвшүүлэх, каластрын үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр “Сургалт хэлэлцүүлэг”-ийг Драгон төвийн 6 давхарын зааланд зохион байгууллаа. Сургалтад 180 гаруй аж ахуй нэгж оролцлоо. Худалдаа үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн дунд спорт тэмцээнийг 2 төрлөөр зохион байгууллаа. Тэмцээнд нийт 20 баг тамирчид оролцож, төрөл бүрээс тэргүүн, дэд, гутгаар байрыг шалгаруулан медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. “Худалдааны хуулийн хүлээлт ба салбарын өнөөгийн байдал-2018” нийслэлийн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бизнес чуулганыг “Туушин” ХХК-ны “Соёмбо” танхимд зохион байгууллаа. Чуулганы үеэр худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор УБХЗАА, МҮХАҮТ-ын хооронд “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулан, нийслэлийн 350 гаруй худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид оролцлоо.				
30	1.2.10. Мал аж ахуй, газар тариалан фермер болон аж ахуйн зориулалтаар төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмших, ашиглах эрх олгогдсон газруудын ашиглалтад хяналт тавих	Дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмших, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар ашиглалтад хяналт тавьж зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгаа гаргаж Газрын тухай хуулийн дагуу хүчингүй болгож, эдийн засгийн эргэлтэд оруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Газрын алба	100.0

		<p>Газрын тухай хуулийн 40.1.6-д заасны дагуу 205 иргэн, хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн 30 хоногийн хугацаатай мэдэгдэх хуудас хүргүүлсэн.</p> <p>Дээрх мэдэгдлийн хүрээнд :</p> <ul style="list-style-type: none"> • 28 иргэн, хуулийн этгээд эзэмшил газар дээрээ хашаа барьсан. • 60 иргэн, хуулийн этгээд Газар эзэмшүүлэх гэрээний үүргийн 4.5-д заасны дагуу газрын төлбөрөө төлж төсөвт 107.4 сая төгрөг төвлөрүүлсэн. <p>Газрын тухай хуулийн 40.1.6 “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил ашиглаагүй”-д заасны дагуу нэр бүхий 117 иргэн, хуулийн этгээдэд Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийг үндэслэн хугацаатай мэдэгдэх хуудас болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэний үндсэн дээр газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгохоор дүүргийн Засаг даргын захирамжийн төсөл боловсруулагдсан.</p>				
31	1.2.11. Шинээр газар эзэмших, ашиглах хүсэлт гаргасан иргэд, аж ахуй нэгж байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгоно.	Иргэн, аж ахуй нэгж байгууллагад газар эзэмших, ашиглах эрх олгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Газрын алба	100.0
<p>Дүүргийн 21 дүгээр хороонд төмс, хүнсний ногоо, мод үржүүлгийн зориулалтаар дүүргийн Засаг даргын А/336 дугаар захирамжаар газар эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалтын ажлын хэсэг байгуулагдаж 60 хоногийн хугацаанд төсөл шалгаруулалтыг зарлан иргэн, хуулийн этгээдээс материалыг хүлээн авч, 2 удаа хуралдан шалгаруулалтын ажлыг зохион байгуулж 67 иргэн, хуулийн этгээдийн төсөлд дүүргийн Засаг даргын 2018 оны А/74 дүгээр захирамжаар газар эзэмшүүлэн гэрээ байгуулж гэрчилгээг олгоод байна. Дүүргийн Засаг даргын дэргэдэх газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүний 13 удаагийн хурлын шийдвэрээр 5356 иргэнд 585.9 га газрыг эзэмшүүлж, ашиглуулах гэрээ байгуулж гэрчилгээ олгосон.</p>						
ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ						
2.1. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.						
32	2.1.1. Халамжаас хөдөлмөр эрхлэлтрүү шилжиж, зорилтот өрх 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр орон нутгийн онцлогт тохирсон төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.	40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0
<p>Дүүргийн иргэдэд эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны тусламж үйлчилгээ үзүүлэх замаар багш, эмч зэрэг ажил хайж буй иргэдийн ур чадварт нь тохирсон ажлын байр бий болгох, эмнэлгийн мэргэжилтэй 40-өөс дээш хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж цагийн болон түр ажлын байраар хангах, нийгмийн идэвх санаачилгатай хөдөлмөрлөх хүсэлтэй иргэдийн бүлгийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, хорооны зорилтот бүлгийн иргэдэд шаардлагатай эмнэлэгийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх, экологийн бохирдол учруулж байгаа үйлдлийг таслан зогсоох, иргэдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, сургуулийн насны хүүхдийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих хичээлийн хоцрогдол арилгах зэрэг үндсэн зорилтуудын хүрээнд хэрэгжих 48.0 сая төгрөгийн санхүүжилттэй “Тусч үйлчилгээ” туршилтын төслийг боловсруулан ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зарласан орон нутгийн онцлогт тохирсон төслийн сонгон шалгаруулалтад оролцуулан санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/206 дугаар тушаалаар “Гэрээт малчин өрхийн</p>						

	<p>хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын төсөл”, “Зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл”–ийн хэрэгжилтийг ханган, төсөлд хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгааг нэгтгэн гаргасан. Энэхүү төсөлд зорилтот өрхийн 40-өөс дээш насны ажилгүй иргэдийг хамруулсан байна. “Зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл”-д дүүргийн хэмжээнд нийт 9 хороо, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төв зэрэг байгууллагуудад 10 бүлэг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан. 10 бүлэгт нийт 46 иргэн хамрагдаж, хөтөлбөр болон гэрээнд заасны дагуу гурвалсан гэрээг байгуулан ажиллаж байна. “Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ-тай хамтран бүлгийн гишүүдэд бүлгээр ажиллах болон хөдөлмөр эрхлэлт, харилцаа гэсэн сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулсан. Бүлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, саналыг нь нэгтгэн 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.“Зорилтот төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулах” чиглэлийн дагуу 14 төсөл хүлээн авч, “Нэмүү өртгийн сүлжээ бизнест бэлтгэх төв НҮТББ”-аас ирүүлсэн “Зуун эмэгтэй” төсөл, иргэн Н.Баярт-Од эсгий урлалын төсөл, М.Мөнхцэцэгийн Ноос боловсруулах үйлдвэрлэлийн төсөл, Т.Цогзолмаагийн “Эсгий бэлэн хувцас” төслийг тус тус шалгаруулж, нийт 200.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосон.</p>				
33	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг иргэдэд сурталчлах өдөрлөг, “Хөдөлгөөнт бирж” арга хэмжээнүүдийг зохион байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ, ХХҮХ	100.0
<p>-Ажилд зуучлалын үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор 32 хороонд “Хөдөлгөөнт бирж”, Өнөр, Баянхошуу, Толгойт, Төвийн хороодод “Хөдөлмөр, халамжийн нэгдсэн өдөрлөг яармаг”-ийг бүсчилсэн хэлбэрээр, “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг ажил олгогчдын хүсэлтээр тус тус зохион байгуулан ажиллаж, нийт 2600 гаруй иргэн оролцож, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн талаар мэдээлэл өгч 1000 гаруй иргэн ажилд зуучлалын үйлчилгээнд хамрагдсан байна. Өдөрлөг арга хэмжээний хүрээнд иргэдийн хэрэгцээг тодорхойлсны дагуу зорилтот өрх, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан ажилгүй, ажил хийх чин хүсэлтэй иргэдийг оролцуулж, ажил олгогчдын нөөцөд бүртгүүлэн, ажил хайх, ажилд ороход нь холбон зуучлах үйлчилгээг хүргэн ажиллаж байна.</p> <p>-“Эко констракшн” ХХК-тай хамтран нээлттэй ажлын байр арга хэмжээ зохион байгуулж барилгын өргөн мэргэжлээр болон туслах ажилтнаар ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэн, ярилцлага хийж тохирох ажлын байранд 25 иргэнийг зуучилсан.</p> <p>-Их засаг их сургуулийн төгсөгчдөд Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг сурталчлан “Оюутанд үйлчлэх өдөрлөг”-ийн арга хэмжээг хамтран зохион байгуулж, цагийн ажил хийх сонирхолтой 200 гаруй оюутнуудын бүртгэлийг авч, зуучлах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.</p> <p>-“Өрхийн хөгжил” уулзалт сургалтыг 9 өдөр, 27 удаа 32 хороонд зохион байгуулж 1587 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч, 389 иргэнд АМЧБО ганцаарчилсан зөвлөгөө өгөх болон ажилд зуучлалын үйлчилгээ үзүүлсэн байна. Сургалтад хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийг түлхүү хамруулан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, төсөл хөтөлбөр, “Нэг өрх нэг ажлын байр” хөтөлбөр, Зохион байгуулалттай ажлын байр туршилтын төсөл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хэрхэн хамрагдах талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, тохирох ажлын байранд зуучлалын үйлчилгээ үзүүлсэн.</p>					

34		Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0
“Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдахаар бичил бизнес буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч 70 ахмад настан төсөл ирүүлснээс 29 төслийг шалгаруулж, нийт 39.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгоод байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй 62 ахмад төсөл ирүүлсэнээс хэрэгжүүлэх боломжтой 54 төслийг дэмжин гэрээ байгуулан хамтран ажиллаж, 15.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Дүүргийн хэмжээнд “Үнэ цэнэтэй ахмадууд” төслийг амжилттай хэрэгжүүлж “Андууд арвижих”, “Баялаг”, “Арвижихуй”, “Өсөх ирээдүй” гэсэн хуримтлалын 4 бүлэг үүсч, бие даан үйл ажиллагаа явуулж байна. Төсөлд хамрагдсан ахмадууд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэхийн зэрэгцээ санхүүгийн боловсролоо дээшлүүлж, хуримтлал үүсгэсэн байна.						
35		Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангах, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0
Зорилтот өрхийн нийгмийн халамжийн тусламж дэмжлэг шаардлагатай 2486 иргэний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт хэрэгцээг тодорхойлж, ажил хийх хүсэлтэй, ажилгүй 1017 иргэнийг 8 удаагийн “Ажилд зуучлал”-ын өдөрлөг яармагт оролцуулж, 30 гаруй байгууллагын хүний нөөцөд бүртгүүлэн ажил хайх, ажилд ороход нь туслан дэмжиж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтын үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй 400 иргэнийг гэрээт 2 сургалтын байгууллагын бүлгийн сургалтад хамруулсан. Зорилтот өрхийн ажилгүй иргэдээс байнгын болон түр ажлын байранд 180 иргэнийг ажилд зуучилсан байна.						
36	2.1.2. Сонгинохайрхан дүүргийн амралт цогцолборын үйл ажиллагааг өргөжүүлж амралт, сувиллын газрыг бий болгох	Дүүргийн амралт цогцолборын газрын материаллаг баазыг бэхжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	40.0
4 дүгээр сарын 24-ний өдөр дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг амралт цогцолборын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж Засаг даргын зөвлөлийн хурлаар асуудлыг хэлэлцүүлсэн. Мөн асуудлыг дүүргийн ИТХ-ийн Нийгмийн бодлогын хороогоор хэлэлцүүлж дэмжиж ажиллах чиглэлүүдийг тодорхойлж 2019 онд 64.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, урсгал засвар хийгдэхээр төлөвлөсөн.						
37	2.1.3. Иргэдийн санал санаачлагад тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж төсөл, хөтөлбөрийн хүрээнд 1200 ажлын байр шинээр бий болгож, ажил олгогч байгууллагуудтай хамтран ажилгүй 8000 иргэнийг ажилд	Иргэдээс санаачилсан төсөл хөтөлбөрийг дэмжих замаар шинэ ажлын байр бий болгох	Шинээр бий болох ажлын байр, тоо	300	НХХ, ХХҮХ	100.0
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлд хувиараа хөдөлмөр эрхлэгч 85 иргэн, аж ахуй нэгж хамрагдаж 195 шинэ ажлын байр бий болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөрүүдийг танилцуулах, иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор 5 төрлийн гарын авлага тараах материал бэлтгэн хэвлүүлж дүүргийн 32 хороонд хүргүүлж, иргэдэд танилцуулга хийх ажлыг зохион байгуулж, 1000 гаруй иргэнийг хамруулсан. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдаж, санхүүгийн						

	<p>зуучлан, дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг 55 хувьд хүргэнэ</p>	<p>дэмжлэг авах хүсэлтэй иргэдийн төсөл хүлээн авах ажлыг зохион байгуулж, нийт 232 иргэний төсөл хүлээн авч, 160 иргэний төслийг дэмжин гэрээ байгуулж, 360.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхчүүд нийт 115 иргэний төслийг хүлээн авч, 77 иргэний төслийг дэмжин гэрээ байгуулж, 190.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байнгын ажлын байртай болгох, бизнесийн эхлэл санаачилгаа хэрэгжүүлэхэд дэмжлэг болгох, ажил хөдөлмөр хийж туршлагажих, орлого олоход дэмжлэг үзүүлэх зорилгоор МСҮТ-ийн төгсөгч болон төгсөгчийн бүлгийн нийт 22 төсөл хүлээн авч, сонгон шалгаруулалтаар 3 төгсөгчийн бүлэг, 15 төгсөгч нийт 18 төслийг дэмжиж 62.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. “Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл удирдамж” батлагдсантай холбогдуулан ХХҮЕГ-аас зорилтот төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, 17 иргэн, ААНБ-аас төсөл ирүүлсэн. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлаар нийт төслүүдийг хэлэлцүүлж Нэмүү өртгийн сүлжээ бизнест бэлтгэх төв НҮТББ-аас ирүүлсэн “Зуун эмэгтэй” төсөл, иргэн Н.Баярт-Одын “Эсгий урлалын төсөл”, иргэн М.Мөнхцэцэгийн “Ноос боловсруулах үйлдвэрлэлийн төсөл”, Т.Цогзолмаагийн “Эсгий бэлэн хувцас үйлдвэрлэл” төсөл тус тус шалгарч нийт 200.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан. Дээрх орон нутгийн онцлогт төслүүд хэрэгжсэнээр нийт 157 ажлын байр бий болсон.</p>				
38	<p>Ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилгүй иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучлах</p>	<p>Ажилд орох иргэн, тоо</p>	2000	НХХ, ХХҮХ	100.0	
<p>Давхардсан тоогоор 280 гаруй ажил олгогч байгууллагуудаас авсан 2330 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг бүртгэн, бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж хандсан ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй 3480 иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, 2010 иргэнийг ажилд зуучилсан.</p>						
39	<p>Асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, мэргэжил эзэмшүүлэх сургалтуудад хамруулж түр болон байнгын ажлын байраар хангах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ, ХХҮХ	100.0	
<p>Хорих ангиас суллагдсан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдийн тухай мэдээлэл хийж, АМБЧО болон ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Хорих ангиас суллагдсан 2 иргэн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдаж, санхүүгийн дэмжлэг авч төсөл хэрэгжүүлж байна. “Зохион байгуулалттай ажлын байр” туршилтын хөтөлбөрт хорих ангиас суллагдсан 5 иргэн 1 бүлэг болон хамтран ажиллах гэрээ байгуулан хөтөлбөр, гэрээнд заасан ажлуудыг хийж, урамшууллаа авсан байна. Бичил бизнес болон хувиараа хөдөлмөр эрхлэгч ХБИргэдэд зориулсан аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулахаар “Бэст метод” ХХК, “Баялаг бүтээгч-Монгол хүн” ТББ, “Карьер бьюлдинг институт”</p>						

		<p>ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Аж ахуй эрхлэлтийн сургалтад нийт 239 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан. Ажил хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөрт бэлтгэх сургалт зохион байгуулахаар тус дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй гэрээ байгуулан 65 иргэнийг хамруулсан. Мэргэжлийн болон давтан сургалтад хөгжлийн бэрхшээлтэй 49 иргэн хамрагдаж, тогооч, оёдолчин, эсгүүрчин, талх нарийн боовчин, цэцэрлэгийн багшийн туслах зэрэг мэргэжлээр суралцаж, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн. “Шилэн хийц” ХХК, “Нүүдэл тэжээл” ХХК, “Улаанбаатар БҮК” ХК, “Соник-Эдүкэйшн” ХХК, “Ачит боломж” ХХК, “ХНХТ” ХХК-иудад хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэнийг ажилд зуучлан оруулсан. ХБИргэнийг ажлын байраар хангасан ажил олгогч байгууллагыг “Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ”-нд хамруулах зорилгоор 7 аж ахуйн нэгж байгууллагатай урамшуулал олгох 10 гэрээ байгуулсан. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон өрхийн хөдөлмөрийн насны, ажилгүй 200 иргэн, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны, ажилгүй 150 иргэн, нийт 350 иргэнийг эрх бүхий гэрээт сургалтын байгууллагуудад “Хөдөлмөрт бэлтгэх сургалт”-д хамруулсан.</p>				
40	2.1.4. Ажил мэргэжилгүй 4000 иргэнийг мэргэжил олгох, 200–аас доошгүй иргэнийг мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулна.	Ажилгүй иргэдийг мэргэжил олгох болон аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулж чадавхижуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0
		<p>Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн хэрэгцээг тодорхойлох судалгааг авч Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгааг хороо тус бүрээр гаргаж нэгтгэн, судалгааг үндэслэн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, төсөл хөтөлбөр, жижиг зээлд хамрагдсан иргэдийн үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор аж ахуй эрхлэлтийн сургалт явуулах эрх бүхий байгууллагуудын материалыг хүлээн авч дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих Бизнес инкубатор төв, “Бизнес хөтлөх харгуй” ТББ, “Элит интернэшнл инвестмент” ХХК-ны сургалтын төв, “Эмэгтэйчүүд хөгжлийн тэмүүлэл” ТББ-уудыг шалгаруулсан. Тус байгууллагуудтай гэрээ байгуулан аж ахуй эрхлэлтийн сургалтад нийт 579 иргэнийг хамруулж цаашид бизнесээ хэрхэн амжилттай авч явах, хөгжүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч сертификат олгосон. Мэргэжлийн болон давтан сургалтад оёдол эсгүүр-70, үсчин-31, гоо засалч-11, талх нарийн боовчин-5, хатгамал даавуу эсгий урлал-5, худалдагч касс нярав-17, гагнуурчин-3, засал чимэглэлч-3, цахилгаанчин-12, тогооч-8, авто машины засварчин-1, машин механизмын төхөөрөмжийн оператор-7, төмөр замын замчин-1, цэцэрлэгийн багшийн туслах-84, төмс хүнсний ногоо, жимс тариалагч-19, гэр бүлийн туслах ажилчин-4, даралтат сав цэнэглэгч түгээгч-4, нарийн бичиг-албан хэргийн ажилтан-1, сантехникч-3, фермерийн аж ахуй-1, хөнгөн үйлдвэрлэлийн сүлжигч-1, нийт 293 иргэн суралцаж, мэргэжил ур чадвараа дээшлүүлсэн байна.</p>				
41		Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд ур чадвар эзэмшүүлэх, бизнесээ өргөжүүлэхэд нь дэмжлэг болохуйц мэргэжлийн зөвлөгөө өгөх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0

		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 1300 гаруй иргэдэд тухай бүр мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан байна. Нээлттэй өдөрлөгийн арга хэмжээний хүрээнд 3200 гаруй иргэнд ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч, гарын авлага, танилцуулга түгээн сурталчилсан.				
42	2.1.5. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дэд хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлэх	Батлуулж хэрэгжүүлэх хөтөлбөр, тоо	1	НХХ, ХХҮХ	100.0
		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны А/47 дугаар тогтоолоор батлуулсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд иргэд, ААНБ-уудад зориулсан 18 удаагийн сургалт, сурталчилгааны ажлууд хийгдэж, 300 гаруй ЕБС-ийн сурагч, 216 МСҮТөвийн суралцагч, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын 2500 гаруй ажиллагсад, 100 гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид тус тус хамрагдсан. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэрэгцээнд зориулан гарын авлага хэвлүүлж, дүүргийн 350 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлсэн.				
43		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдрийг угтан аян зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0
		Дүүргийн хэмжээнд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2018” арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан Засаг даргын 2018 оны А/165 дугаар захирамжаар батлуулан хэрэгжилтийг 100.0 хувь ханган ажилласан. Аяны хүрээнд зохион байгуулсан томоохон ажлууд: - Дүүргийн төрийн болон хувийн хэвшлийн нийт 100 аж ахуйн нэгж байгууллагад ХАБЭА-н уриалга бүхий зурагт плакат, эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж, ХАБЭА-н тухай хууль, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс байгуулах аргачилсан зөвлөмжүүдийг тус тус хүргүүлж сурталчилсан. - Дүүргийн нийт иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сарын аяныг сурталчилан нийтийн эзэмшлийн талбай, самбарт “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн соёлыг төлөвшүүлэхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлцгээе” уриалга бүхий самбарыг сарын турш байршуулан сурталчилла. -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, дүрэм журмыг иргэд, аж, ахуйн нэгж байгууллагад сурталчилах зорилгоор 2 төрлийн 2000 ширхэг брошур хэвлүүлэн, 32 хорооны иргэд, аж ахуйн нэгж байгууллагад түгээж сурталчилсан. -ЕБСургуулийн төгсөх ангийн сурагчдын дунд “НЭН ТҮРҮҮНД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт гар зургийн уралдаан зарлаж, дүгнэсэн. Уралдаанд нийт 300 гаруй сурагч оролцон бүтээл ирүүлсэн бөгөөд нэгдүгээр шатанд 45 бүтээл шалгарч, хоёрдугаар шатны шалгаруулалтаар эхний байруудыг тодруулсан. “Нэн түрүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал” гар зургийн уралдаан нь хүүхэд, залуучуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ойлголт, мэдлэг, мэдээллийг тэлж, тэдний оролцоог нэмэгдүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон. Энэхүү уралдааны шилдэг 12 бүтээлээр ширээний календарь гаргаж, ААНБ-уудад түгээн сурталчилж байна. “Эрүүл аюулгүй ажлын байрны төлөө хамтдаа” сэдэвт хүнс, хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч байгууллагуудын				

		<p>хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад дүүргийн ХАБЭА-н зөвлөлийн дарга болон гишүүд, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөл, ХНХЯамны төлөөлөл болон хүнс хөнгөн үйлдвэрлэл эрхлэгч 20 байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан болон удирдлагууд оролцсон. Дүүргийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын дунд “ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЕ” сэдэвт 2 үе шаттай илтгэлийн уралдаан зарлаж, 4 МСҮТ-ийн 21 суралцагч оролцож нэгдүгээр шатанд 5 илтгэл шалгарч, хоёр дугаар шатны шалгаруулалтыг Чингэс СооСэ Их Сургууль дээр зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд МСҮТөвийн 200 гаруй суралцагчдыг зохион байгуулан оролцуулж, эцсийн шатанд шалгарсан илтгэлүүд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль журам, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ойлголт, мэдээлэл хүргэсэн. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага, телевизүүдтэй тогтмол хамтран ажиллаж, мэдээлэл өгсөн. Мөн дүүрэг, хороодын болон хэлтсийн цахим хуудсанд байршуулан сурталчилан ажиллаж байна. ХАБЭА-н тухай хуулийн хүрээнд 6 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 450 гаруй ажиллагсад сургалт зохион байгуулж, ХАБЭА-н талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлсэн.</p>				
44	2.1.6. Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн хамгааллын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Зорилтот бүлгийн өрх, иргэнийг нийгэмшүүлэн, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болоход чиглүүлэх төсөл, хөтөлбөрт хамруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ХХҮХ	100.0
		<p>“Бүлгийн төсөл хэрэгжүүлэх” ажлын хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 92 иргэний материалыг хүлээн авч сонгон шалгаруулалт хийн 48 бүлгийн төслийг шалгаруулж ажлын байртай 46 бүлэгт /96 хүн/ 62.8 сая төгрөгийг олгоод байна. Үүнээс зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан өрхүүдээс ОНОТХҮ-нээс 12 бүлгийн 24 иргэн хамрагдаж 16.2 сая төгрөгийн санхүүжилт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд төсөл хөтөлбөрт 18 иргэн хамрагдаж, 41.0 сая төгрөгийн санхүүжилт авч өрхийн үйлдвэрлэл эрхэлж байна. Зөвлөхийн бус үйлчилгээний тендер нээж, үнэлгээ хийж байна. 13 багцад нийт 22 байгууллага оролцсоноос 4 багцад хамгийн сайн тендер ирүүлсэн байгууллагатай гэрээ байгуулж, 9 багцад дахин нээлттэй тендер зарлан 7 байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.</p>				
45		Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлэх өрх, тоо	6400	НХХ, ХХҮХ	100.0
		<p>Дүүргийн хэмжээнд нийт 6616 өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдахаар судалгаа гарсан. Үүнтэй холбогдуулан хороодын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд өрхийг баталгаажуулах, түдгэлзүүлэх, үйлчилгээг зогсоох талаар мэдээлэл зөвлөгөө өгч, арга зүйгээр</p>				

		хангаж, 32 хорооны хэсгийн ахлагч, Амьжиргааг дэмжих зөвлөл, хороодын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр өрхүүдийг хэлэлцүүлж, илтэд амьжиргааны түвшин боломжтой, хүнсний эрхийн бичигт хамрагдах шаардлагагүй, судалгааг буруу өгсөн, өөрийн хүсэлтээр татгалзсан зэрэг шалтгаанаар 664 өрхийн үйлчилгээг зогсоосон. Оршин суух хаягт байхгүй, холбоо тогтоох боломжгүй, утас солигдсон, түр оршин сууж байгаад /орцны жижүүр, манаач гэх мэт/ нүүсэн 348 өрхийн үйлчилгээг түдгэлзүүлэн нийт 1012 өрхийн үйлчилгээг зогсоосон. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхийн өрх иргэний хувийн хэрэг, бичиг баримтын бүрдэл болон өрхүүдэд хяналт хийх, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа дэлгүүрүүдэд эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын баталгааг бүрэн хангасан, зөвшөөрөгдсөн хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлийн дундаж үнээр, сонголттой худалдаалж байгаа эсэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Дүүргийн хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч, хувийн хэрэг нээлгэсэн 5434 өрхөөс 84.6 хувь буюу 4600 өрхийн хувийн хэргийн баяжилт бүрдлийг шалгаж, түүврийн аргаар 20 хорооны 68 өрхийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, 42 өрхийн үйлчилгээг зогсоох буюу түдгэлзүүлэх саналыг тухайн өрхийн оршин суудаг хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлд хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. 2018 онд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэхээр гэрээлэн ажиллаж байгаа 50 дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцаж, арга зүйн зөвлөгөө өгч, гаргасан зөрчил дутагдлыг арилгуулсан. 2018 оны жилийн эцсийн байдлаар 5122 өрхийн 13396 насанд хүрэгч, 14718 хүүхдэд нийт 332.1 сая төгрөг буюу нийт 4.3 тэрбум төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлээд байна.				
46		Нийгмийн хамгааллын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Батлуулж хэрэгжүүлэх хөтөлбөр, тоо	1	HXX, ХХҮХ	00.0
		Өөрсдөө бие даан хөгжих боломж нөхцөл хязгаарлагдмал, нийгмийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүдийг сэтгэл зүйн хувьд нөхөн сэргээх, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээ үзүүлэх замаар дэмжин тусалж, нийгэм, хамт олны дунд бусдын адил хөгжих боломжийг бүрдүүлэх, төрөөс үзүүлж буй хөгжлийн дэмжлэг, халамж үйлчилгээг өрх, гэр, хүн бүрт хүргэхээр Нийгмийн хамгааллын дэд хөтөлбөрийн төслийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.				
47	2.1.7. Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, өрх толгойлсон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, ахмадын талаарх бодлогыг дүүргийн түвшинд хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг бий болгоход анхаарч ажиллана	“Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	HXX, ХХҮХ	100.0
		Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 0-3 насны хүүхдээ асарч байгаа 24988 эх хүсэлт ирүүлснээс хуулийн заалт хангасан 22573 иргэнд 9.9 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон. Журмын дагуу сар бүр нийгмийн даатгалын мэдээллийн сантай тулгалт хийж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 2415 эхийн үйлчилгээг зогсоож, шимтгэл төлөөгүй эхчүүдэд тэтгэмжийг олгож байна. 0-18 настай 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 379 эх, эцэгт 358.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.				
48		Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, барилга байгууламжийн бүтцэд хяналт тавих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	HXX, ХХҮХ, MXX	100.0

	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу 2103 иргэнд 365.6 сая төгрөгийн хөнгөлөлт, тусламжийг халамжийн сангаас олгосон байна. Үүнд: Рашаан сувилалын хөнгөлөлтөд 331 иргэнд 63.4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 69 хүүхдэд 16.6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 53 хүүхдийн асран хамгаалагчид 1.1 сая төгрөг, Протезийн /шүд/ хөнгөлөлтөд 377 иргэн, хүүхдэд 42.2 сая төгрөг, Ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлтөд 1195 иргэн, хүүхдэд 206.5 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оршуулгын тэтгэмжийг 59 иргэнд 59.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 19 хүүхдэд 19.0 сая төгрөг тус тус олгосон байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдрийг угтан дүүргийн Засаг даргын 2018 оны А/528 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан, “ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИН, ЗАГВАР ДҮҮРЭГ” 1 сарын аян зарлаж аяны хүрээнд 20 ажил төлөвлөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хандан уриалга гарган хүргүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, хөгжүүлэх стандартад нийцсэн жишиг байртай болох зорилтын хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨГЖИЛ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ” хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан. Дүүргийн төрийн өмчийн 24 сургуулийн удирдлагуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн ерөнхий газартай хамтран хөгжлийн бэрхшээлийн ойлголт, хандлага, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд хамруулах талаарх сургалтыг зохион байгуулан ажилласан.</p>				
49	Ахмадын өргөө барих газрын асуудлыг шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, Ахмадын хороо	100.0
	<p>1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Ахмадын өргөөний барилга барих газрын асуудлыг шийдвэрлэсэн. 2019 оны улсын төсөвт 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ахмадын өргөөний барилга баригдахаар туссан. Мөн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт улсын төсвийн хөрөнгөөр баригдах Соёлын ордонд ахмадын танхим тохижуулахаар төлөвлөөд байна.</p>				
50	Ахмад, дунд, залуу 3 үеийн чуулга уулзалтыг салбар бүрээр зохион байгуулж тэдний холбоог бэхжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, Ахмадын хороо	100.0
	<p>Боловсролын байгууллагын удирдах ажилтан ахмад, дунд, залуу 3 үеийн “Алтан холбоог бэхжүүлэе” уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад Монгол улсын гавъяат багш н.Дамдинжав, П.Донжоо, Л.Гомбожав, Доржсүрэн, ахмад ажилтан ардын боловсролын тэргүүний ажилтан Б.Батбаяр, Т.Байгаль, Х.Ичинноров, нийслэлийн Ахмадын хорооны орлогч дарга н.Болд нар болон ерөнхий боловсролын сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч нийт 80 хүн оролцож ахмадууд туршлагаасаа ярьж, харилцан зөвлөлдөн зөвлөмж гаргаж, Монгол улсын гавъяат багш П.Донжоогийн “108 сэдэл ажил” номын нээлт, “Захирал багш” дуу хүлээн авах ёслолыг хийсэн. Ахмадын өдрийг угтан 09 дүгээр сарын 27-ны өдөр Засаг даргын Тамгын газраас тэтгэвэртээ гарсан 107 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, гурван үеийн чуулга уулзалтыг зохион байгууллаа. Чуулга уулзалтад нийт 107 ахмад, 20 залуу, дунд үеийн төрийн албан хаагч нарт оролцсон.</p>				

51	2.1.8. Хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн, шуурхай хүргэж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, шинээр ажил олгогч, даатгуулагчдыг заавал болон сайн дурын хэлбэрээр хамруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ЭМНДХ	100.0
<p>Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулахын тулд алслагдсан хороод болох Тахилт, Партизан, Эмээлт буюу 21, 22, 32 дугаар хороодын малчин иргэдэд сурталчлан таниулах ажлыг нээлттэй хаалганы өдөрлөгөөр зохион байгуулж ажиллалаа. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 4386 иргэдийн сайн дурын гэрээг байгуулж даатгалд хамрагдуулж, 15306 иргэдийн гэрээг сунгах, мэдээллийн баазад сар бүр ногдуулалт хийж төлсөн шимтгэлийн хэмжээгээр нь нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийн баталгаажуулж даатгалын үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. Эрүүл мэндийн даатгалын санд малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэдээс 3 дугаар улирлын байдлаар 866.8 сая төгрөг хуримтлуулах төлөвлөгөөтэйгээс 1.15 тэрбум төгрөг хуримтлуулж ажилгүй буюу хувиараа хөдөлмөр эрхлэгч 27262 иргэдийг хамруулж эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 132.8 хувь буюу 283.5 сая төгрөгөөр сар бүр жигд давуулан биелүүлж иргэдийн мэдээллийг мэдээллийн баазад бүрэн оруулж эрүүл мэндийн гэрчилгээн дээр бичилт хийж баталгаажуулан даатгалын үйлчлэгээ авах нөхцөлийг ханган үйлчилж байна.</p>						
2.2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.						
52	2.2.1. Ургийн эрт оношлогоонд жирэмсэн эхчүүдийг хамруулж, эх нялхсын эндэгдлийг бууруулж ажиллана.	Ургийн гажиг оношлох 3D, 4D ЭХО аппаратаар салбар амбулаторуудыг хангах талаар гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ	70.0
<p>Ургийн гажиг оношлох 3D, 4D ЭХО аппаратаар хангах судалгааны ажил хийгдэж Азийн хөгжлийн банкны “Эрүүл мэндийн салбарын хөгжил, хөтөлбөр 5” төсөлд болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагуудад хүсэлт хүргүүлсэн. 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02/2721 дүгээр албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүсэлт хүргүүлснээр 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4-2/4453 албан бичгээр асуудлыг шийдвэрлэхээр судалгаанд авсан тухай хариуг ирүүлээд байна.</p>						
53		2018 оныг “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих –эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах” жил болгон эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ ӨЭМТ	100.0
<p>2018 оны A/02 дугаар захирамжаар эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2018 оныг “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж, 4 зорилтын хүрээнд 37 заалт төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p> <p>1 дүгээр зорилтын хүрээнд: Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, эх нярайн</p>						

эндэгдлийг бууруулах үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн “Эрүүл Сонгинохайрханчууд” дэвжээ тэмцээнийг зохион байгуулж, шилдэг бүтээлийг шалгаруулсан. “Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулья” удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд дүүргийн 90 гаруй удирдах ажилтан оролцож, дүүргийн Засаг даргын 03 дугаар албан даалгаврыг гарган, хэрэгжилтийг ханган ажилласан.

2 дугаар зорилтын хүрээнд: 32 өрхийн эрүүл мэндийн төвд 10 нэр төрлийн 123.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олгож, 17 өрхийн эрүүл мэндийн төвд тус бүр 15.0 сая, нийт 255.0 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж дуусгаад байна. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүд жирэмсэн эх, хүүхдийн үзлэгийн өрөөг тохижууллаа. 1, 2, 3, 7, 11, 22, 23, 24, 25, 26, 29, 32 дугаар хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дархлаажуулалтын цэгийг шинээр нээн, үйл ажиллагааг жигдрүүлээ. Хороо, өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран 0-5 настай болон өсвөр насны хүүхэд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг эрүүл мэндийн бүлэг, өвчлөлийн байдлаар тус тус гарган мэдээллийн сан үүсгэсэн. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/391 дүгээр захирамжаар цэцэрлэг, Ерөнхий бовловсролын сургуулийн хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, 43 цэцэрлэгийн 8000, 21 сургуулийн 10000 гаруй хүүхдийг хамруулан, эрүүлжүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. 1-2 насны архаг хууч өвчтэй, сульдаатай, тураалтай 2000 гаруй хүүхдийг Хүүхдийн клиник сувилалд 3 сарын хугацаатайгаар хамруулсан. “Гэр бүл төлөвлөлт”, “Хүсээгүй жирэмслэлт”, “Жирэмслэхээс сэргийлэх арга”, “Өсвөр насныхны эрүүл мэнд”, “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь” зэрэг 17 сэдвээр 86 удаагийн сургалтаар 3210 гаруй иргэнд мэдлэг олгож, 17000 орчим иргэнд цахим болон цаасан хэлбэрээр сурталчилгааг хүргэн ажилласан. Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах “Эх хүүхдийн эндэгдэл хэлэлцэх зөвлөл”-ийг байгуулж 2018 онд 8 удаа, амьгүй төрөлт, эрт нярайн эндэгдэл, 0-5 насны хүүхдийн эндэгдлийн асуудлаар хуралдаж, 10 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ. Мөн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эмэгтэйчүүдийн эмч нарыг хуваарийн дагуу ажиллуулж, Эрүүл мэндийн төвийн зөвлөх эмчээр ЭХЭМҮТ-ийн төрөх тасгийн эрхлэгч н.Энхтуяаг ажиллуулж байна. 2018 онд нөхөн үржихүйн насны 5043 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 2364 өвчлөл илэрсний 67.0% буюу 1578 эмэгтэй эрүүлжсэн. Илүү өртөмтгий бүлгийн 18348 эмэгтэйн 26.5% 4862 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, 86.0% нь жирэмснээс сэргийлэх арга хэрэглэж байна. Мөн шинээр 3432 эх хяналтад орж түүнээс 0-3 сартай жирэмсний хяналт 3058 буюу 89.0 хувьтай байгаа бөгөөд 3104 эх төрөөд байна.

3 дугаар зорилтын хүрээнд: “Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж дүүргийн Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 32 сувилагч, 14 эмчийг хамруулсан. Шинэчилсэн Хүүхдийн өвчний цогц мэдлэгээр сургалт зохион байгуулж, 30 шинэ, залуу эмчийг хамрууллаа.

4 дүгээр зорилтын хүрээнд: Дүүргийн Засаг даргын 2018 оны А/495 дугаар захирамжаар “Эрүүл эх-Эрүүл хүүхэд” болзолт уралдааныг зарлан, 32 хороо бүрт хүүхдийн хоол, тэжээлийн сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэлээ. Сургагч багш нарын хийсэн хоол, тэжээлийн үзэсгэлэнг гаргаж олон нийтэд сурталчлан ажилласан. Бага насны хүүхдийг ахуйн осол гэмтэл, түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх “Хүүхдийн түлэгдэлт-Эцэг эхийн хариуцлагаас” аяныг дүүргийн Засаг даргын А/547 дугаар

		захирамжаар 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлүүллээ. Аяны хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтыг 11 дүгээр сарын 21, 30-ний өдөр зохион байгуулж 32 хорооны нийгмийн ажилтан, 32 өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, нийт 64 албан хаагч хамрагдаж, 12 өрхийн эрүүл мэндийн төвд төрийн бус байгууллагын дэмжлэгээр мэдээллийн самбар хийлгэн, хүлээлгэж өглөө. 2018 онд эхийн эндэгдэл 1 гарсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4 тохиолдлоор буурсан. Урьд оны мөн үетэй харьцуулахад 0-1 насны хүүхдийн эндэгдэл -1,4 промилль, 1-5 насны хүүхдийн эндэгдэл -0,2 промилиэр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт 90.2 хувийн биелэлттэй хэрэгжлээ.				
54	2.2.2. Эмнэлгийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулна.	Дүүргийн эрүүл мэндийн төвийн эрчимт эмчилгээ яаралтай түргэн тусламжийн тасгийг иж бүрэн тоног төхөөрөмж, бүрэн тоноглогдсон машинтай болгох асуудлыг холбогдох байгууллагад уламжлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ	70.0
		2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02/2721 дүгээр албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүсэлт хүргүүлснээр 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4-2/4453 дугаар албан бичгээр асуудлыг шийдвэрлэхээр судалгаанд авсан тухай хариуг ирүүлсэн.				
55		2 дугаар амбулаторийг шүдний БОР машинаар хангах ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ	100.0
		Дүүргийн Эрүүл мэндийн төвийн (тоног төхөөрөмжийн) төсвийн хүрээнд 2018 оны 07 дугаар сард тендер зарлан 2 дугаар амбулаторит 13.0 сая төгрөгийн үнэ бүхий иж бүрэн шүдний БОР-ын аппаратыг хүлээлгэн өглөө. Аппарат олгосноор амбулаторын шүдний үзлэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэг эмчид ноогдох ачаалал 40.0 хувиар буураад байна. БНСУ-аас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхэт Элчин сайд У Сун болон “Дэлхийн сайн санаат хүмүүс” ТББ-ын төлөөлөл дүүрэгт зочилж, хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, санамж бичгийн хүрээнд 42, 76 дугаар сургуулиудад шүдний кабинет байгуулах төслийн саналыг хүргүүллээ.				
56		Хавдрын тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн химийн эмчилгээг хийдэг болох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ	100.0
		Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дотрын 1, 2 дугаар тасагт тус бүр 4 ортой хавдрын химийн болон хөнгөвчлөх эмчилгээ үзүүлэх тасгийг нээн ажиллуулж байна. Хими эмчилгээг 119 удаагийн давталттайгаар 48 хүнд, хөнгөвчлөх эмчилгээг 86 хүнд үзүүлээд байна.				
57		8 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийг “ЭХО” аппаратаар хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0
		Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 17.0 сая төгрөгөөр хийгдэхээр үнэлгээний хороо байгуулагдан, тендер зарлаж, “Нуган” ХХК шалгарч 11.8 сая төгрөгийн ЭХО аппаратыг 8 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвд хүлээлгэж өгсөн.				
58		31 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийг дуудлагын авто машинтай болгох асуудлыг шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0

		Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгөөр “Приус 20” маркын автомашиныг худалдан авч, 31 дүгээр хорооны Өрхийн эрүүл мэндийн төвд хүлээлгэж өгсөн.				
59	2.2.3. Улаанбурхан, салхинцэцэг болон бусад цочмог вируст халдварт өвчлөлийг бууруулах талаар анхаарч ажиллана.	Улаанбурхан, салхинцэцэг болон бусад цочмог вируст халдварт өвчлөлийн талаар сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ	100.0
		Менингит, салхинцэцэг, улаанбурхан өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 ажил төлөвлөн, 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүллээ. 2018 онд салхинцэцэгийн тохиолдол 299 бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 240 тохиолдлоор буюу 8.2 промилиэр буурсан үзүүлэлттэй байна. Мөн салхинцэцэг, улаанбурхан гахай хавдар, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах, нэмэлт вакцин хийх ажлын хүрээнд дүүргийн их дээд 5 сургуульд нэмэлт дархлаажуулалт зохион байгуулж 60.4%-тай дуусгалаа. 0-15 насны хамрагдвал зохих дархлаажуулалт 96.1%-тай, үүнээс халдварт саа, тавт вакцины бүрэн тунгийн хамралт 96.3%, УГУ-эсрэг вакцины бүрэн тунгийн хамралт буюу 95.7%-тай байна. Мөн вирүст гепатит А-ын эсрэг вакциныг 1нас 2 сартай, 2 настайд товллын дагуу 2 тунгаар хийж, нийт 2962-2925 буюу 98.7%, 2 настай 3250-3227 буюу 99.2%-тай, бүрэн тунгийн хамралт 98.8%-тай байна.1, 2, 3, 7, 11, 22, 23, 24, 25, 26, 29, 32 дугаар хороодын өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дархлаажуулалтын цэгийг шинээр нээн, үйл ажиллагааг жигдрүүлээ.Тууралтат халдварт өвчин салхинцэцэг, менингококкт халдварт өвчний эмнэлзүй, авах арга хэмжээний талаар шинэ залуу 21, хүүхдийн байгууллагын 60 эмч ажилтнуудад 5 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 206 эмчийг хамруулсан. Халдварт, цочмог халдварт өвчний талаар нийт 140 удаагийн сургалтаар 3500 орчим иргэнд мэдээлэл хүргэж, 9000 гаруй иргэнд сурталчилгаа явуулж, 8250 ширхэг сурталчилгааны материал тараасан.				
60		Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг тогтмол зохион байгуулах, байгууллага, аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулах ажлыг эрчимжүүлэх, томуу, томуу төст өвчний дархлаажуулалтад эмзэг бүлгийн иргэдийг хамруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ЭМТ	100.0
		Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 6 зорилт 46 заалттайгаар гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хөтөлбөр 90%-тай хэрэгжсэн. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/480 дугаар захирамжаар томуу, томуу төст өвчний үед авах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дүүргийн нэгдсэн эмнэлэгт 50 ортой нэмэлт тасгийг нээж, Монголын Улаан загалмайн хорооноос 50 эвхдэг орны дэмжлэг үзүүллээ. Томуугийн вакцин хийх ажлыг зохион байгуулж 33 цэцэрлэгийн 15338 хүүхдээс 12280 хүүхдийг, 425 жирэмсэн эмэгтэй, 673 өндөр настан, нийт 13378 иргэнийг хамруулан дархлаажууллаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнуудад 7 хоног бүр томуу, томуу төст өвчний				

		<p>байдлын талаар мэдээлэл хийж, мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажиллахын зэрэгцээ уртасгасан цагаар ажиллуулж байна. Харьяа хүүхдийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 120 эмчийг хамруулсан. Сүүлийн 5 жилийн байдлаар зорилтот бүлгийн хүн амын дундах халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг хувиар гаргахад сүүлийн 3 жилд хамрагдалт 15%-иар нэмэгдсэн байна. Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт 74692 зорилтот бүлгийн хүн хамрагдахаас 41192 буюу 55.1 хувь нь хамрагдаж 1212 артерийн гипертензи оношлогдон өрхийн болон 2 дах шатлалын эмчийн хяналтад, чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлгийн үзлэгт 74692 зорилтот бүлгийн хүн хамрагдахаас 31333 буюу 41.9 хувь нь хамрагдаж 187 хүн оношлогдон дотоод шүүрлийн булчирхайн эмчийн хяналтад тус тус орсон байна. Элэгний В, С илрүүлэх үзлэг шинжилгээнд зорилтот 40-65 насны 77789 иргэнээс 20451 даатгуулагч хамрагдаж 4388 С, 1567 В вирус, 15-39 насны 138262 иргэнээс 10004 даатгуулагч хамрагдаж, 256С, 489 В вирус илрээд байна. Нийт С вирус илэрсэн 4644 хүнээс 1583 иргэн эмчилгээнд хамрагдаад байна. Хөгжлийн бэрхшээлтэй элэгний С вирустэй 100 иргэнд Жи Си Ай Олон улсын төрийн бус байгууллагатай хамтран 3 сар уух эмийг үнэгүй олгосноос анхан шатны шинжилгээгээр 30 хүн буюу 30.0 хувь нь вирус идэвхгүй болсон хариуг аваад байна. Онош баталгаажуулах сүүлийн шинжилгээг 12 дугаар сарын 20-нд өгөхөөр төлөвлөөд байна. Хепатитын вирусын халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт хамрагдвал зохих 23321 хүн байгаагаас 9385 хүн буюу 40.2 хувь нь хамрагдсан нь өмнөх оноос 5 хувиар өссөн байна.</p>				
61		<p>Нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p> <p>Нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн:</p> <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт сурталчилгаа хийх зорилт 100% 2. Сургалт сурталчилгааг идэвхжүүлэх техник тоног төхөөрөмжөөр хангах зорилт 70% 3. Бэлгийн идэвхитэй амьдралтай эрсдэлтэй бүлгийн хүмүүст БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, хавьтлыг илрүүлэх замаар иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилт 100% 4. Сүрьеэ өвчний талаар сургалт, мэдээллээр хангах замаар иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг чанаржуулах зорилт 100% 5. Халдварт бус өвчний өвчний эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээ зохион байгуулж өвчлөлийн түвшинг тогтоох зорилт 100.0 %-тай хэрэгжсэн ба нийт 5 зорилт 94.0 %-тай хэрэгжсэн байна. 	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувь	100	НХХ, ЭМТ ӨЭМТ	100.0
62	2.2.4. Хүн ам, ялангуяа эрсдэл ихтэй бүлгийн дунд тандан шинжих аргыг нэвтрүүлж, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт өвчин, сүрьеэгийн тархалтыг бууруулна.	<p>Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдварыг бууруулах ажлыг зохион байгуулах</p> <p>Дүүргийн Эрүүл мэндийн төвийн БЗДХ/ДОХ/ХДХВ-ийн кабинетаар нийт 33235 үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 26441 буюу 79.0 хувь, диспансерийн хяналт 2.76 буюу 8.0 хувь, өвчний учир 4035 буюу 12.0 хувь хамрагдаж нийт 639 өвчлөл илэрснийг эмчлэн эрүүлжүүлсэн. Дүүргийн Засаг даргын захирамжаар урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж 137 байгууллагын 8335 ажилтныг БЗДХӨ</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ЭМТ, ОУБ-ууд	100.0

	<p>илрүүлэх шинжилгээнд хамруулснаас 178 өвчлөл илрүүлж, эрүүлжүүллээ. “Хааны эрэл” Олон Улсын эмч нартай хамтран дүүргийн 254 иргэнийг шинжилгээнд хамруулан 23 өвчлөл илрүүлж, эмчилгээнд хамруулсан. 22 дугаар хороонд БЗДХ-н эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж 5490 иргэнийг хамруулснаас 73 тохиолдлыг 19 хавьталын хамт эмчилгээнд хамруулсан. Үзлэгт хамрагдсан 5000 гаруй иргэнд сурталчилгаа хийж мэдээлэл олгох ажлыг хийгээд байна. “Ганц-зам Итгэл” ТББ-ын зорилтот бүлгийн 26 иргэн, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлж буй 12 аж ахуйн нэгж, байгууллагын эзэн, менежер, зохион байгуулагч нарт БЗДХ-с хэрхэн сэргийлэх, бэлгэвчийн зохистой хэрэглээ сэдэвт, сургалт зохион байгуулсан. “Гэр бүл төлөвлөлт”, “Хүсээгүй жирэмслэлт ба жирэмслэхээс сэргийлэх арга”, “Өсвөр насныхны эрүүл мэнд” зэрэг 10 сэдвээр 60 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, 2100 гаруй иргэнд мэдлэг олгож, 17000 орчим иргэнд цахим болон цаасан хэлбэрээр сурталчилгааг хүргэсэн. Нийт давхардсан тоогоор 83600 гаруй иргэнд хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан сурталчилгааг хийсэн. ДОХ-той тэмцэх өдрийг угтан ерөнхий боловсролын 8 сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдад “БЗДХ-аас сэргийлье” сургалтыг зохион байгуулж, “ДОХ-бидний нүдээр” зохион бичлэг, гар зургийн уралдааныг зарлаж дүгнэсэн. “Саранбат” ТББ-тай хамтран нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх сургалтыг дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын дунд 14 хоногийн хугацаанд зохион байгуулж, нийт 2040 хүүхдийг хамрууллаа. Дүүргийн хүн ам, хүүхэд залуучуудад чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа, үзлэг оношлогоог хамтран зохион байгуулах хүсэлтийг 2018 оны 02/2782, 02/2783 дугаар албан бичгээр “Саранбат” ОУТББ, 11 дүгээр сарын 01-ний 02/2895 дугаар албан бичгээр “GoodPeople” ОУТББ-уудад хүргүүлээд байна. Хүсэлтийн дагуу “Саранбат” ОУТББ нөхөн үржихүйн эрүүл мэндийн өсвөрийн сургагч багш бэлтгэх, сургуулиудад кабинет тохижуулах зэрэг ажлуудыг дэмжин ажиллахаар 2019 оны төлөвлөгөөнд тусгаад байна.</p>				
63	<p>Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>НХХ, ЭМТ ӨЭМТ</p>	<p>100.0</p>
<p>Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 6 зорилт 46 заалттайгаар гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Хөтөлбөр 90.0 хувьтай хэрэгжсэн. 3193 халдварт өвчин бүртгэгдсэнээс 2124 буюу 66.6 хувийг цочмог халдварт өвчин эзэлж байна. Үүнээс 1913 халдварт өвчний тохиолдлын голомтод эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг авч ажилласан. Менингокт халдвартай тэмцэх сэргийлэх ажлын хамар залгиурын үрэвсэлт өвчин илрүүлэх үзлэгийг хийж, нийт 121236 хүнийг үзлэгт хамруулж, залгиурын үрэвсэлтэй 26122 хүнийг илрүүлэн, 21553 хүнийг эмчлэн эрүүлжүүлсэн. Нийт 44 цэцэрлэгийн 32114 хүүхдийг үзлэгт хамруулж, хамар залгиурын үрэвсэлтэй 5663 хүүхдийг илрүүлэн эрүүлжүүлсэн. Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээний хамралтыг сайжруулах "Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, сургалт зохион байгуулах тухай" А/217 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, ААНэгжүүд, иргэдийг үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд 97 байгууллагын 5983 ажилтан,</p>					

		албан хаагчдыг хамруулж 154 өвчлөл илрүүлж, эрүүлжүүлсэн. Мөн зорилтот бүлгийн иргэдийг үзлэг шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд 22 дугаар хорооны зорилтот 6087 иргэнийг сүрьеэ болон БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамруулж, 200 гаруй өвчлөл илэрснийг эмчилгээнд хамруулсан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх “Сүрьеэгүй дүүрэг” уулзалт хэлэлцүүлгийг дүүргийн удирдах ажилтан 80 хүнийг хамруулан зохион байгууллаа. “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг 12, 42, 65, 67, 76, 107, 80, 81, 82, 83 дугаар сургуулиудын 2000 хүүхдэд 11 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” дүүргийн дэд хөтөлбөрийг боловсруулан 11 дүгээр сарын 19-ний өдрийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн бариад байна.								
64	2.2.5. Агаар, орчны бохирдлоос иргэдээ хамгаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, албан даалгавар гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0				
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/480 дугаар захирамжаар “Агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөл болон томуу, томуу төст өвчний үед авах арга хэмжээний тухай” төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Агаарын бохирдлоос сэргийлэх”, “Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх” сэдвээр нийт 140 удаагийн сургалт, сурталчилгааг зохион байгуулж, 3500 орчим иргэнд сургалт хийж, 9000 гаруй иргэнд сурталчилгаа хүргэн, 8250 ширхэг сурталчилгааны материал тараасан. Томуу, томуу төст өвчний үед уртасгасан цагаар ажиллах хуваарийг 10 цэгт байршуулан, хүүхдийн эмч нар, ӨЭМТ-ийн эмч нар уртасгасан цагаар ажиллаж эхлээд байна. Мөн хүүхдийн үзлэгийн кабинетад зөвлөгөө өгөх 98188851 утсыг 24 цагаар ажиллуулж байна. Дүүргийн ӨЭМТөвүүдэд 31 ширхэг, ЭМТөвд 5 ширхэг агаар цэвэршүүлэгч төхөөрөмж олгогдсон. Агаарын бохирдлыг бууруулах газраас Хүүхдийн нэгдсэн эмнэлэгт 59 ширхэг агаар цэвэршүүлэгч төхөөрөмж олголоо. “Утааны эсрэг аав, ээжүүд” группын сургалтын багтай хамтран 10 дугаар сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хугацаанд “Гэр байшингаа дулаалцгаая” сургалтыг зохион байгуулж, нийт 22 хорооны 1000 иргэнийг хамруулсан. Мөн зорилтот бүлгийн 60 жирэмсэн эмэгтэйд “Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалъя” сургалтыг зохион байгуулж, жирэмсэн эмэгтэй тус бүрт 3 сарын хэрэглээний амны хаалтыг олгоод байна.								
65	2.2.6. Оношлогоо эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан дүүргийн загвар нэгдсэн эмнэлгийг байгуулна.	Жишиг эмнэлгийн барилгын ажлыг үргэлжлүүлэх	Барилгын гүйцэтгэл, хувиар	50	НХХ, НЭ	100.0				
		2017 онд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4” төслийн хүрээнд жишиг нэгдсэн эмнэлгийн барилгын ажлыг Австрийн “Вамед Инжинеринг Жи Эм Би Эйч” компани эхлүүлсэн. Барилгын явц 75.0 хувийн гүйцэтгэлтэй буюу 2018 онд төлөвлөсөн ажлаа 100% гүйцэтгээд байна.								
66		Жишиг эмнэлэгт ажиллах боловсон хүчнийг сургах, дадлагажуулах ажлуудыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, НЭ	100.0				

		<p>ЭМСХХ-4, 5 төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Жишиг дүүргийн нэгдсэн эмнэлэг”-т ажиллах 29 эмчийг үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад хамруулснаас 13 эмч төгссөн. Гэмтэл согог судлал, Арьсны өвчин судлал, Дүрс оношлогоо, Чих хамар хоолой судлал, Мэдрэл судлал, Сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ, Мэдээгүйжүүлэг, Нүд судлал, Лаборатори чиглэлийн эмч нар төгсөж төрөлжсөн мэргэжлээр үргэлжлүүлэн сургахаар төлөвлөн ажиллаж байна.Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Арьсны өвчин судлал (Бэлгийн замын халдварт өвчин) - Мэдээгүйжүүлэг (Өвдөлт намдаалт) - Мэдрэл судлал (Тархины цахилгаан бичлэг, Тархины судасны бичлэг) - Сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ (Диализ) <p>Байгууллагаас 11 сувилагчийг дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрууллаа. Үүнд: 3 асрагчийг туслах сувилагчийн 3 сарын сургалтад, 3 сувилагчийг хүүхдийн сувилахуйн төрөлжсөн мэргэжлээр, 1 сувилагчийг мэс заслын сувилахуйн төрөлжсөн мэргэжлийн сургалтад, 1 сувилагчийг эрчимт эмчилгээний сувилахуйн төрөлжсөн мэргэжлийн сургалтад, 6 сувилагчийг төрөлжсөн нарийн мэргэжил эзэмших сургалтад тус тус хамруулсан.</p>				
67		<p>Дүүргийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ. ЭМТ	40.0
		<p>Дүүргийн Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлын худалдан авах ажиллагааны эрх Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/55 дугаар тушаалаар шилжин ирж, дүүргийн Засаг даргын А/131 дүгээр захирамжаар үнэлгээний хороо байгуулагдсан.Зураг, магадлалын ажил хийлгэх 2.8 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын 2018 оны А/232, А/326 дугаар захирамжаар шийдвэрлэсэн ба 10 дугаар сарын 15-ны өдөр батлагдан ирсэнээр 10 дугаар сарын 17-ны өдөр тендер зарлаж 11 дүгээр сарын 19-ний өдөр нээж үнэлэхэд шаардлага хангасан тендерийн материал ирээгүй. 11 дүгээр сарын 29-ний өдөр дахин тендер зарласан.</p>				
68	2.2.7. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэх, бие бялдрын түвшинг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана.	<p>Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн материаллаг бааз сайжруулах, уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ, БТСХ	100.0
		<p>Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн дунд /Буудлага, Тэшүүр, Таэквондо, Жү-до бөх, Чөлөөт бөх, 100 буудалт даам, Үндэсний бөх, Ширээний теннис, Шатар, Дугуй, ЕБС-ийн Уран хөдөлгөөнт гимнастик, аэробик, Спорт бүжиг, Хөнгөн атлетик, Хөлбөмбөгийн тэмцээн, 3х3 сагсан бөмбөг, МJ сур жүдо бөх/ нийт 18 төрлөөр дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 15.3 сая төгрөгийг зарцууллаа. 18 тэмцээнд 249 байгууллагын 4291 өсвөрийн тамирчид оролцсон. Өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээний буудлага, чөлөөт бөх, жүдо бөх, дугуй, 100 буудалт даамны төрөлд тамирчид оролцон 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн. Залуучуудын УАШТ-ний бокс, буудлага, дугуй, чөлөөт бөхийн төрөлд 1 алт, 1 мөнгө, 3 хүрэл хүртсэн амжилтуудыг үзүүлээд байна.</p>				

69		Үндэсний спортын ҮI их наадам, иргэдийн спортын наадам, ахмадын спортын II наадам, хүүхдийн спортын наадам болон спортын уралдаан, тэмцээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БТСХ	100.0
Үндэсний спортын ҮI их наадмыг 7 дугаар сард спортын 7 төрлөөр, Иргэдийн спортын наадмыг 8-10 дугаар сарын хооронд спортын 8 төрлөөр зохион байгуулж, нийт 99 байгууллагын 1420 иргэн оролцлоо. Үндэсний спортын наадамд уламжлалт сурын харваанд багаараа хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Дүүргийн иргэдийн спортын наадамд 13 дугаар хороо тэргүүн байр, 3, 5 дугаар хороо удаах байруудыг эзэллээ. Нийслэлийн Иргэдийн спортын наадамд байгууллагаараа 6 дугаар байр, олс таталтын төрөлд мөнгө, сагсан бөмбөгийн төрөлд мөнгө, залуучуудын аэробекийн төрөлд мөнгө, ахмад настны хийн дасгалын төрөлд хүрэл, явган аялалын төрөлд хүрэл медаль тус тус хүртсэн. Нийтийн биеийн тамир спортын (ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын явган аялал, бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил, өвлийн спорт наадам, байгууллагуудын спорт наадам зэрэг) уралдаан, тэмцээн, өдөрлөгийг 33 удаа зохион байгуулж 490 байгууллагын 23576 тамирчныг хамрууллаа. Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарын санаачилгаар зохион байгуулагдаж буй сагсан бөмбөгийн “Сонгино Лиг”-ийн тэмцээн 6 дугаар сард дүүргийн спорт цогцолборт болж 32 хорооны 480 тамирчид оролцлоо.						
70		Биеийн тамир спорт хорооны гадна талбайн хашаа болон хяналтын камертай болох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БТСХ	100.0
Байгууллагын гадна талын гол хаалганд 2 ширхэг хяналтын камер байршуулж, 24 цагийн турш хяналт тавин ажиллаж байна. Хашаажуулах ажлыг “Их буян бүүвэй” ХХК хариуцан гүйцэтгэсэн.						
71		Ирээдүй цогцолборын 2 дугаар бага сургууль, 67 дугаар сургуулиудад спорт заалны өргөтгөл барих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
Ирээдүй цогцолборын 2 дугаар бага сургуулийн спорт заалны барилгыг улсын төсвөөс 574.0 сая төгрөгөөр санхүүжүүлж "Өндөр хайрхан дулаан" ХХК гүйцэтгэн ажиллаж байна. Ажлын явц 70.0 хувьтай байна. 67 дугаар сургуулийн спорт заалны өргөтгөлийг нийслэлийн төсвөөс 600.0 сая төгрөгөөр санхүүжүүлж “Сайрын харанга” ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан.						
72		Чийрэгжүүлэлтийн танхимын засвар, тохижилт, тоног төхөөрөмж нийлүүлэх /1, 2, 3, 5, 8, 16, 26, 28 дугаар хороо/	Хороо, тоо	8	НХХ, БТСХ	70.0
1, 2, 3, 8, 26, 28 дугаар хороодын чийрэгжүүлэлтийн танхимыг дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангаас 35.9 сая, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангаас 122.9сая, нийт 158.8 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжөөр хангаж, засварлах ажил хийгдсэн.						
73		Сагсан бөмбөгийн талбай байгуулах /1, 2, 20, 24 дүгээр хороо/	Сагсан бөмбөгийн талбай, тоо	4	ТНААХ	70.0

		Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1 дүгээр хороонд 14.3 сая төгрөгөөр “Эвсэг” иргэдийн бүлэг, 2 дугаар хороонд 13.7 сая төгрөгөөр “Нөхөрлөл” иргэдийн бүлэг, 20 дугаар хороонд 18.2 сая төгрөгөөр “Чанар” иргэдийн бүлгүүд тус тус сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан.				
2.3. Боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлнэ.						
74	2.3.1. Ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэн, бүх сургуулиудыг 2 ээлжээр хичээллэх боломжтой болгон, ангидүүргэлтийн стандартыг мөрдүүлнэ.	9, 62, 65, 76, 106, 107, 122, Ирээдүй цогцолборын нэгдүгээр бага сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		9, 62, 65, 106, 107, 122, Ирээдүй цогцолборын 1-р бага сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын төсөв 2018 оны улсын төсөвт батлагдсанаас оны эцсийн байдлаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Улсын төсвийн хөрөнгөөр 9 дүгээр сургуулийн 320 хүүхдийн суудалтай давхарлах барилгын ажлыг “Би Ди Би” ХХК гүйцэтгэж, барилгын ажил 70.0 хувьтай явагдаж байна. - 62 дугаар сургуулийн 640 хүүхдийн өргөтгөлийн барилгыг улсын төсвийн 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдах тендер шалгаруулалт явагдаж, “Ган зосон” ХХК шалгарсан. - 65 дугаар сургуулийн өргөтгөлийн төсөв 2018 онд батлагдсан боловч төсөвт өртөг бага тусгагдсан учир хойшлогдсон. БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хүрээнд 26 дугаар хороонд 920 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдаж байгаа тул 65 дугаар сургуульд өргөтгөл баригдах шаардлагагүй гэж үзсэн. - Улсын төсвийн 3.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 106 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын газар шорооны ажил хийгдэж эхлээд байна. Гүйцэтгэгчээр “Номин-Содон констракшн” ХХК ажиллаж байна. - 107 дугаар сургуулийн 450 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэгчээр “Хитрөү констракшн” ХХК ажиллаж байна. - Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2.5 сая долларын өртөгтэй “Ногоон сургууль” төслийн хүрээнд 122 дугаар сургуулийн 640 хүүхдийн хүчин чадалтай өргөтгөлийн барилга 2019 онд баригдахаар шийдвэрлэгдсэн. - Улсын төсвийн хөрөнгөөр Ирээдүй цогцолборын 1 дүгээр бага сургуулийн 480 хүүхдийн суудалтай өргөтгөлийн барилгын ажлыг “Солид Констракшн” ХХК хариуцан ажиллаж, гүйцэтгэл 50 хувьтай байна. 				
75		13, 16, 23, 28, 32 дугаар хороодод тус бүр 640 хүүхдийн суудалтай сургууль, 31 дүгээр хороонд цэцэрлэг бага сургуулийн цогцолбор барилга шинээр барих ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	70.0
		13, 23, 28, 32 дугаар хороодын сургуулийн барилгын ажлын төсөв 2018 оны улсын төсөвт батлагдсан. Оны эцсийн байдлаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:				

		<ul style="list-style-type: none"> - 13 дугаар хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгыг 99 дүгээр цэцэрлэгийн урд барихаар төлөвлөгдсөн боловч газрын хэмжээ стандартад хүрэхгүй шалтгааны улмаас БСШУС-ын сайдын 2018 оны А/494 дүгээр тушаал гарч худалдан авах ажиллагааг зогсоосон. - Улсын төсвийн 6.2 тэрбум төгрөгөөр 23 дугаар хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил эхэлж, гүйцэтгэгчээр “Хүрэл ордон” ХХК ажиллаж байна. - 28 дугаар хороонд 17 нэгж талбарын газар чөлөөлөлт удааширсан тул барилгын ажил хийгдээгүй. 2019 онд улсын төсвийн 5.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдахаар батлагдсан. - 32 дугаар хороонд 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдахаар 2 удаагийн тендер шалгаруулалт явагдаж, шаардлага хангасан компани ороогүй хойшлогдсон. 2019 онд улсын төсвийн 4.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баригдахаар батлагдсан. - 31 дүгээр хороонд баригдах бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын газрын асуудлыг нийслэлийн Засаг даргын 2018 оны А/632 дугаар захирамжаар чөлөөлсөн. Улсын төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 250 хүүхдийн цэцэрлэгийн барилга, 4.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга тус тус 2019 онд баригдахаар батлагдсан. 				
76		Ерөнхий боловсролын сургууль барих боломжтой газрын судалгаа гарган, холбогдох байгууллагуудад уламжлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ, ГА	100.0
		Ерөнхий боловсролын сургууль барих боломжтой байршил, газрын судалгаа гарган, дүүргийн 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал тусган ажиллаж байна. Сургуульгүй 10 /4, 5, 7, 10, 20, 27, 28, 29, 30, 31/-н хороо, 3-н ээлжээр хичээллэж байгаа 3 /12, 62, 65/-н сургууль, сургуулийн өргөтгөл бариулах 8 /12, 123, Ирээдүй цогцолборын 6-н сургууль/-н сургуулийн судалгааг нэгтгэн гаргасан.				
77	2.3.2. Хороо бүрт цэцэрлэгтэй байх бодлогыг баримтлан, хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах “Жаргалтай үрс” төсөл хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролд	20 дугаар хороонд шинээр баригдаж буй цэцэрлэгийн барилгын үйл ажиллагаанд хяналт тавьж, ашиглалтад оруулах	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	100	НХХ, БХ	100.0
	хамрагдалтыг 80 хувьд хүргэнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр 20 дугаар хорооны 150 хүүхдийн ортой 228 дугаар цэцэрлэгийн барилга 2018-2019 оны шинэ хичээлийн жилд ашиглалтад орж, 350 хүүхэдтэйгээр сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.				
78		26 дугаар хорооны 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	100	НХХ, БХ	100.0
		26 дугаар хороонд Улсын төсвийн хөрөнгөөр 240 хүүхдийн хүчин чадалтай 253 дугаар цэцэрлэг 4 дүгээр сарын 17-нд нээлтээ хийн, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.				
79		1, 2, 5, 10, 11, 16, 22, 23, 24, 26, 28 дугаар хороодод шинээр цэцэрлэгийн барилга барих ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100	НХХ, БХ	70.0
		Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд 1, 2, 11, 22, 23, 24, 26, 28 дугаар хороодод тус бүр 150 хүүхдийн ортой цэцэрлэг, 5 дугаар хороонд 100 хүүхдийн ортой цэцэрлэг, 16 дугаар хороонд тус бүр 200 хүүхдийн				

		<p>ортой 2 цэцэрлэг, 21 дүгээр хороонд 116 дугаар цэцэрлэгийн 50 хүүхдийн ортой өргөтгөл, 10 дугаар хороонд хуучин барилгыг буулгаж шинээр 280 хүүхдийн ортой цэцэрлэг баригдахаар батлагдсан. Оны эцсийн байдлаар дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 1 дүгээр хорооны цэцэрлэгийн газар чөлөөлөлтийн явц удааширсаны улмаас барилгын ажил эхлээгүй. Улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой цэцэрлэг 2019 онд баригдахаар батлагдсан. - 2 дугаар хороонд 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баригдахаар барилгын суурь тавигдсан. - Улсын төсвийн хөрөнгөөр 5 дугаар хороонд 100 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажил эхлээд байна. Гүйцэтгэгчээр “Арь констракшн” ХХК ажиллаж байна. - 10 дугаар хорооны цэцэрлэгийн барилгыг буулгаж, 280 хүүхдийн ортой цэцэрлэг барихаар 2018 онд батлагдсан боловч төсөвт өртөг хүрээгүйн улмаас хийгдээгүй. 2019 онд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдахаар батлагдаж, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/593 дугаар захирамжаар 4406 м.кв газрыг олгосон. - 11 дүгээр хороонд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгөөр 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдах тендер зарлагдсан боловч хүчингүй болж, дахин зарлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/758 дугаар захирамжаар 6100 м.кв газрыг олгосон. - 16 дугаар хороонд нийслэлийн төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 113 дугаар цэцэрлэгийн 200 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын суурийн ажил эхэлсэн. Гүйцэтгэгчээр “Инж-хамий” ХХК ажиллаж байна. - 16 дугаар хороонд улсын төсвийн 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 119 дүгээр цэцэрлэгийн 200 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын ажлын тендер 2 дахь удаа зарлагдаад, шууд гэрээ байгуулахаар болсон. - 22 дугаар хороонд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 150 ортой цэцэрлэгийн барилга баригдахаар барилгын ажил эхэлсэн. - 23 дугаар хороонд улсын төсвийн 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдахаар тендер зарлагдсан боловч шаардлага хангасан компани ороогүй тул дахин зарлагдсан. НЗД-ын 2018 оны А/869 дугаар захирамжаар 4370 м.кв газрыг олгосон. - 24 дүгээр хороонд улсын төсвийн 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажлын тендер зарлагдаж, барилгын гүйцэтгэгч шалгарсан. - Улсын төсвийн хөрөнгөөр 26 дугаар хороонд 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын шав тавигдаж, барилгын гүйцэтгэгчээр “Энэрэлт их эрдэнэ” ХХК ажиллаж байна. Мөн тус хороонд Нарны хүүхдүүд-2 төслийн хүрээнд 75 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдаж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болсон. - Улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 28 дугаар хороонд 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажил 50 хувьтай хийгдэж байна - Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх төслийн хүрээнд 8 дугаар хороонд 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдаж, үйл ажиллагаа эхлүүлэхэд бэлэн болоод байна. - 21 дүгээр хороонд улсын төсвийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 116-р цэцэрлэгийн 50 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажил 50%-тай явагдаж байна. Гүйцэтгэгчээр “Дэлгэрэх
--	--	--

		<p>констракшн” ХХК ажиллаж байна.</p> <p>- 12 дугаар хороонд улсын төсвийн нийт 684.6 сая төгрөгийн хөрөнгөөр 105-р цэцэрлэгийн 120 хүүхдийн ортой цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 60%-тай баригдаж, гүйцэтгэгчээр “Зорь бүтээ” ХХК ажиллаж байна.</p>				
80		<p>18 дугаар хорооны 55 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгыг барих, 30 дугаар хорооны 125 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлэх</p>	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	40	НХХ, БХ	70.0
		<p>Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 18 дугаар хорооны 55 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих ажлын хүрээнд цэцэрлэгийн үндсэн барилгыг буулгасан. 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Рендер Бай” ХХК ажиллаж, гүйцэтгэл 25.0 хувьтай байна. Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 30 дугаар хорооны 125 дугаар цэцэрлэгийн 240 хүүхдийн өргөтгөлийн барилгын тендер шалгаруулалт 2 дахь удаа тендер зарлагдаж, үнэлгээ хийгдэж байна.</p>				
81		<p>6 дугаар хороо, Содон хороололын цэцэрлэгийн барилгыг худалдан авах, үйл ажиллагааг эхлүүлэх</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100	НХХ, БХ,	100.0
		<p>Улсын төсвийн хөрөнгөөр 6 дугаар хорооны Содон хороололд 120 хүүхдийн ортой 259 дүгээр цэцэрлэг шинээр ашиглалтад орж, 2018-2019 оны хичээлийн жилд 290 хүүхэдтэй сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.</p>				
82		<p>4 дүгээр хорооны халуун усны барилгыг засварлан 226 дугаар цэцэрлэгт 2 бүлэг нэмж ажиллуулах</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь	100	НХХ, БХ,	ҮБ
		<p>4 дүгээр хорооны нийтийн ахуйн үйлчилгээний барилгад засвар хийж, 226 дугаар цэцэрлэгийн өргөтгөл болгон тохижуулах ажилд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 100.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр шийдвэрлэгдээд байна.</p>				
83		<p>Хүүхдийн цэцэрлэг барих боломжтой байршил, газрын судалгаа гарган, холбогдох байгууллагуудад уламжлах</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ, ГА	100.0
		<p>Хүүхдийн цэцэрлэг барих боломжтой байршил, газрын судалгаа гарган, дүүргийн 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал тусган ажиллаж байна. Цэцэрлэггүй 28, 29 дүгээр хороод болон өргөтгөл бариулах 14 /26, 78, 80, 84, 90, 92, 110, 156, 158, 176, 112, 104, 195, 226/-н цэцэрлэгийн судалгааг гаргаж холбогдох байгууллагуудад уламжилсан. Нийслэлийн Засаг даргын захирамжаар 1, 2, 4, 5, 10, 11, 22, 23, 26, 28, 30 дугаар хороодод цэцэрлэгийн газар, 31 дүгээр хороонд бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын газрын асуудлыг шийдвэрлээд байна.</p>				
84	2.3.3. “Эко сургууль, цэцэрлэг” аян хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгт хүүхдэд ээлтэй,	<p>“Эко сургууль”, “Ногоон цэцэрлэг” аяныг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0

	эрүүл аюулгүй орчин бий болгон, сургалтын орчныг сайжруулна.	“Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд Эко сургууль хөтөлбөрийг 105 дугаар сургууль дээр хэрэгжүүлж байна. Ногоон паспорт аяныг ерөнхий боловсролын 10-11 дүгээр ангийн 2949 сурагчдын дунд өрнүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд Олон улсын хүүхдийн Найрамдал төв дээр зохион байгуулагдсан нийслэлийн Эко клубын чуулга уулзалтад дүүргийн 16 сургуулийн 17 клубын 96 багш, суралцагчид хамрагдлаа. БСШУСЯам, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, JCI олон улсын байгууллагаас хамтран зохион байгуулсан Хаврын цэцгийн баярт 104, 105, 106 дугаар сургуулийн 500 сурагч оролцсон.			
85	Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэн туршлага түгээн дэлгэрүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
	Дүүргийн төрийн өмчийн 25 сургууль, төрийн бус өмчийн 6 сургуулийн цайны газруудад “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт тавьж зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. “Ерөнхий боловсролын сургуулиудын хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад Төрийн хяналт шалгалтын тухай, Эрүүл ахуйн тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Стандартчилал тохирлын үнэлгээний тухай, Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага MNS 4946:2005, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал САС RCP-39:2009 стандартын мөрдөлт, Хоолны газрын нийтлэг журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалт хийгдсэн. Шалгалтыг 10 дугаар сарын 09-16-ны хооронд хийж, ерөнхий боловсролын 22 сургууль хамрагдсан. Шалгалтын явцад нийт 84 зөрчил илрүүлж, 24 зөрчлийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчил дутагдалд “Хамада” ХХК, “Эргэх хас-Эрдэнэ” ХХК, “Бадмаа арвижих” ХХК, “Коко десерт” ХХК, “Тод ган” ХХК, “Судаэн” ХХК, “Халиунбат арвижих” ХХК, “Цолмон маргад трейд” ХХК, “Энгүүн мандах” ХХК, “Бордог шүтээн” ХХК зэрэг 10 аж ахуй нэгж, байгууллагад 60 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. БНСУ-ын KOICA олон улсын байгууллага, “WITN” төрийн бус байгууллагын санхүүжилттэй “Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүүхдийн хоол, шим тэжээл-хоол үйлдвэрлэл үйлчилгээний менежментийн сайжруулах” төслийн хүрээнд “Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, шим тэжээлийн асуудлууд” хамтарсан сургалтыг төрийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, тогооч нарт зохион байгууллаа.				
86	Сургууль, цэцэрлэгийн бүсийн стандартыг хангаж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0

	<p>Сургууль, цэцэрлэгийн гадна орчны аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд сургуулиуд “school police” эргүүлийг тогтмол ажиллуулж, байгууллага бүр гадна талбайн гэрэлтүүлэг, камержуулалт, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагчийг байрлуулан ажиллаж байна. Нийслэлийн төсвөөр 65, 107, 122 дугаар сургуулиудын орчинд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажлуудыг нийт 166.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн. Сургуулийн өмнөх насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадлыг багаас нь зөв хэвшүүлэх, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор жил бүр явагддаг “Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” тэмцээнд 19 цэцэрлэгийн 278 хүүхэд оролцсоноос 110, 55, 112 дугаар цэцэрлэгүүд эхний байруудад шалгарсан. Сургууль бүр “School police” эцэг, эхийн эргүүл жижүүрийг тогтмол ажиллуулан сургуулийн ойролцоох зам, гарц дээр ажиллуулан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тогтмол явуулж байна. Бага насны хүүхдүүдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмтэл ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “ONE COMMUNITY” төслийн хүрээнд 104 дүгээр сургууль дээр хүүхдэд ээлтэй гарц байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Ногоон гэрэл, цагаан шугам-2018” тэмцээнийг дүүргийн Спорт цогцолборт зохион байгуулж 22 сургуулийн 276 сурагчид оролцож эхний байруудад Ирээдүй цогцолборын 2 дугаар бага сургууль, 62 дугаар сургууль, 123 дугаар сургуулиуд шалгарсан.</p>																																																
87	Сургууль, цэцэрлэгүүдэд хийгдэх шаардлагатай барилгын болон их засварын ажлуудыг хийж гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0																																												
2018 онд улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нийт 22 байгууллагад 5222.0 сая төгрөгийн санхүүжилтээр их засварын ажлууд хийгдсэн. Үүнд:																																																	
<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="734 869 797 970">№</th> <th data-bbox="797 869 1469 970">Хийгдсэн ажил</th> <th data-bbox="1469 869 1668 970">Төсөвт өртөг /сая.төг/</th> <th data-bbox="1668 869 2007 970">Төсвийн эх үүсвэр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="4" data-bbox="734 970 2007 1002" style="text-align: center;">Сургууль:</td> </tr> <tr> <td data-bbox="734 1002 797 1098">1</td> <td data-bbox="797 1002 1469 1098">9-р сургуулийн ариун цэврийн өрөөний иж бүрэн тохижилт, цахим анги байгуулах</td> <td data-bbox="1469 1002 1668 1098">319.0</td> <td data-bbox="1668 1002 2007 1098">БСШУЯ-ны дэмжлэгээр БНСУ-ын Дежон хотын санхүүжилт</td> </tr> <tr> <td data-bbox="734 1098 797 1129">2</td> <td data-bbox="797 1098 1469 1129">65-р сургуулийн дотор сантехникийн их засвар</td> <td data-bbox="1469 1098 1668 1129">92.0</td> <td data-bbox="1668 1098 2007 1129">Улсын төсөв</td> </tr> <tr> <td data-bbox="734 1129 797 1161">3</td> <td data-bbox="797 1129 1469 1161">76-р сургуулийн гадна фасад, дээврийн засвар</td> <td data-bbox="1469 1129 1668 1161">828.6</td> <td data-bbox="1668 1129 2007 1161">Улсын төсөв</td> </tr> <tr> <td data-bbox="734 1161 797 1193">4</td> <td data-bbox="797 1161 1469 1193">67-р сургуулийн биеийн тамирын заал</td> <td data-bbox="1469 1161 1668 1193">585.0</td> <td data-bbox="1668 1161 2007 1193">Улсын төсөв</td> </tr> <tr> <td data-bbox="734 1193 797 1257">5</td> <td data-bbox="797 1193 1469 1257">Ирээдүй цогцолбор 2-р бага сургуулийн биеийн тамирын заал</td> <td data-bbox="1469 1193 1668 1257">630.1</td> <td data-bbox="1668 1193 2007 1257">Улсын төсөв</td> </tr> <tr> <td data-bbox="734 1257 797 1321">6</td> <td data-bbox="797 1257 1469 1321">104-р сургуулийн гадна тохижилтын ажил</td> <td data-bbox="1469 1257 1668 1321">45.6</td> <td data-bbox="1668 1257 2007 1321">Улсын төсөв</td> </tr> <tr> <td data-bbox="734 1321 797 1353">7</td> <td data-bbox="797 1321 1469 1353">105-р сургуулийн биеийн тамирын заалны засвар</td> <td data-bbox="1469 1321 1668 1353">25.0</td> <td data-bbox="1668 1321 2007 1353">Орон нутгийн төсөв</td> </tr> <tr> <td data-bbox="734 1353 797 1385">8</td> <td data-bbox="797 1353 1469 1385">124-р сургуулийн гадна биеийн тамирын талбай</td> <td data-bbox="1469 1353 1668 1385">75.5</td> <td data-bbox="1668 1353 2007 1385">Улсын төсөв</td> </tr> <tr> <td colspan="2" data-bbox="734 1385 1469 1414" style="text-align: center;">Дүн</td> <td data-bbox="1469 1385 1668 1414">2600.8</td> <td data-bbox="1668 1385 2007 1414"></td> </tr> </tbody> </table>						№	Хийгдсэн ажил	Төсөвт өртөг /сая.төг/	Төсвийн эх үүсвэр	Сургууль:				1	9-р сургуулийн ариун цэврийн өрөөний иж бүрэн тохижилт, цахим анги байгуулах	319.0	БСШУЯ-ны дэмжлэгээр БНСУ-ын Дежон хотын санхүүжилт	2	65-р сургуулийн дотор сантехникийн их засвар	92.0	Улсын төсөв	3	76-р сургуулийн гадна фасад, дээврийн засвар	828.6	Улсын төсөв	4	67-р сургуулийн биеийн тамирын заал	585.0	Улсын төсөв	5	Ирээдүй цогцолбор 2-р бага сургуулийн биеийн тамирын заал	630.1	Улсын төсөв	6	104-р сургуулийн гадна тохижилтын ажил	45.6	Улсын төсөв	7	105-р сургуулийн биеийн тамирын заалны засвар	25.0	Орон нутгийн төсөв	8	124-р сургуулийн гадна биеийн тамирын талбай	75.5	Улсын төсөв	Дүн		2600.8	
№	Хийгдсэн ажил	Төсөвт өртөг /сая.төг/	Төсвийн эх үүсвэр																																														
Сургууль:																																																	
1	9-р сургуулийн ариун цэврийн өрөөний иж бүрэн тохижилт, цахим анги байгуулах	319.0	БСШУЯ-ны дэмжлэгээр БНСУ-ын Дежон хотын санхүүжилт																																														
2	65-р сургуулийн дотор сантехникийн их засвар	92.0	Улсын төсөв																																														
3	76-р сургуулийн гадна фасад, дээврийн засвар	828.6	Улсын төсөв																																														
4	67-р сургуулийн биеийн тамирын заал	585.0	Улсын төсөв																																														
5	Ирээдүй цогцолбор 2-р бага сургуулийн биеийн тамирын заал	630.1	Улсын төсөв																																														
6	104-р сургуулийн гадна тохижилтын ажил	45.6	Улсын төсөв																																														
7	105-р сургуулийн биеийн тамирын заалны засвар	25.0	Орон нутгийн төсөв																																														
8	124-р сургуулийн гадна биеийн тамирын талбай	75.5	Улсын төсөв																																														
Дүн		2600.8																																															

		Цэцэрлэг:				
		9	48-р цэцэрлэгийн дотор болон гал тогооны засвар	50.0	Улсын төсөв	
		10	78-р цэцэрлэгийн дээвэр, цахилгаан, дохиолол, дотор засвар	420.5	Улсын төсөв	
		11	90-р цэцэрлэгийн дээвэр, фасад, сантехникийн засвар	329.9	Швейцарын хөгжлийн агентлаг	
		12	101-р цэцэрлэгийн сэрүүн өрөөний засвар	63.2	Улсын төсөв	
		13	117-р цэцэрлэгийн барилгын болон сантехникийн шугамын засвар	250.0	Япон улсын Засгийн газрын "Өвсний үндэс" төсөл	
		14	125-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын засвар	5.5	Орон нутгийн төсөв	
		15	127-р цэцэрлэгийн барилгын фасад, дээврийн засвар	360.3	Швейцарын хөгжлийн агентлаг	
		16	127-р цэцэрлэгийн гадна тоглоомын талбайн тохижилт	34.9	Улсын төсөв	
		17	163-р цэцэрлэгийн сантехник, цахилгаан, гадна хашааны засвар	489.2	Улсын төсөв	
		18	163-р цэцэрлэгийн дээвэр, гадна фасад, цонхны их засвар	312.0	Улаанбаатар Цэвэр агаар сан	
		19	188-р цэцэрлэгийн цэвэрлэх байгууламж, бохирын шугамын засвар	80.0	Улсын төсөв	
		20	188-р цэцэрлэгийн 1 бүлгийн анги танхимын тохижилт	10.0	Улсын төсөв	
		21	192-р цэцэрлэгийн гадна фасад, дээврийн засвар	205.7	Улсын төсөв	
		22	244-р цэцэрлэгийн 1 бүлгийн анги танхимын тохижилт	10.0	Улсын төсөв	
			Дүн	2621.2		
			Нийт дүн	5222.0		
		Сургууль, цэцэрлэгүүдийн сантехник, цахилгаан, дулааны шугамууд олон жил их засвар хийгдээгүйгээс шугам хагарах, бөглөрөл үүсэх, дулаан алдагдах доголдол үүсэж байгаа тул яаралтай хийгдэх шаардлагатай газруудын судалгааг гарган, БСШУС-ын сайд Ц.Цогзолмаад дүүргийн Засаг даргын 2018 оны 01/311, БСШУСЯаманд хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэст 02/832, 02/953, 02/3008 тоот албан бичгүүдээр хүргүүлээд байна.				
88		Гэр хорооллын алслагдсан Ерөнхий боловсролын сургуулиудыг автобустай болгох асуудлыг судалж, холбогдох байгууллагуудад уламжлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазарын дэмжлэгтэйгээр алслагдсан 21 дүгээр хорооны 74 дүгээр сургууль хүүхдийн автобустай болсон.				

89	2.3.4. Сургуульд “Биеийн тамирын талбай”, “Монгол зан заншил, соёлын төв”, цэцэрлэгт “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв”-ийг байгуулна.	Сургуульд “Монгол зан заншлын жишиг төв”-ийг байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0																											
		БСШУСЯам болон Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа “Боловсролын чанарын шинэчлэл” сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 2 дахь шатны төслийн хүрээнд 9, 104, Ирээдүй 3 дугаар бага сургуулиуд 18.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий “Ёс заншлын өргөө” байгуулсан. Сургууль бүр өөрсдийн бололцоогоор хөрөнгө оруулалт хийж ёс заншлын булан, танхимыг бий болгосон. /Нийт 29.0 сая төгрөг/. Ерөнхий боловсролын сургуулиуд монгол зан заншлын кабинет, өргөө гэр байгуулж суралцагчдад зан заншил, өв соёлыг сурталчлах, хөлөгт тоглоомоор тоглуулж монгол ахуй соёл түүхтэй танилцах дадлага ажлуудыг зохион байгуулж ажиллаж байна.																															
90	Цэцэрлэгт “Эцэг эхэд зөвлөгөө өгөх жишиг төв”-ийг байгуулах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0																											
		“Хүн болох багаасаа” аяны хүрээнд эцэг эхэд зөвлөгөө өгөх төвийг цэцэрлэг бүр байгуулан, сайн зохион байгуулалттай, үйлчилгээний хүртээмжтэй жишиг төвийг бүсийн хэмжээнд шалгаруулан урамшуулах ажлыг амжилттай зохион байгуулсан. Төрийн болон төрийн бус өмчийн 39 цэцэрлэг заах аргын нэгдлийн өрөөг түшиглэн “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв”-ийг байгуулан ажиллаж байна.																															
91	2.3.5. Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ	“Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” үйл ажиллагааг сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын суралцагчдад хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0																											
		Сургалтын стандарт хэрэгжилтийн тоо баримт:																															
		<table border="1"> <thead> <tr> <th>Боловсролын түвшин</th> <th>Амжилт /хувиар/</th> <th>Чанар /хувиар/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="3" style="text-align: center;">2016-2017 оны хичээлийн жилд:</td> </tr> <tr> <td>Бага</td> <td>99.8</td> <td>94.5</td> </tr> <tr> <td>Суурь</td> <td>99.9</td> <td>59.5</td> </tr> <tr> <td>Бүрэн дунд</td> <td>99.9</td> <td>70.0</td> </tr> <tr> <td colspan="3" style="text-align: center;">2017-2018 оны хичээлийн жилд:</td> </tr> <tr> <td>Бага</td> <td>99.7</td> <td>94.4</td> </tr> <tr> <td>Суурь</td> <td>98.4</td> <td>62.1</td> </tr> <tr> <td>Бүрэн дунд</td> <td>100.0</td> <td>72.4</td> </tr> </tbody> </table>					Боловсролын түвшин	Амжилт /хувиар/	Чанар /хувиар/	2016-2017 оны хичээлийн жилд:			Бага	99.8	94.5	Суурь	99.9	59.5	Бүрэн дунд	99.9	70.0	2017-2018 оны хичээлийн жилд:			Бага	99.7	94.4	Суурь	98.4	62.1	Бүрэн дунд	100.0	72.4
Боловсролын түвшин	Амжилт /хувиар/	Чанар /хувиар/																															
2016-2017 оны хичээлийн жилд:																																	
Бага	99.8	94.5																															
Суурь	99.9	59.5																															
Бүрэн дунд	99.9	70.0																															
2017-2018 оны хичээлийн жилд:																																	
Бага	99.7	94.4																															
Суурь	98.4	62.1																															
Бүрэн дунд	100.0	72.4																															
		Ерөнхий боловсролын сургуулиудын 12 дугаар ангийн төгсөгчдийн дунд элсэлтийн ерөнхий шалгалтын өмнөх сорилын шалгалтыг математик, нийгэм, монгол хэл, англи хэл зэрэг сурагчдын сонгосон судлагдахууны дагуу 5 дугаар сарын 9, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Шалгалтад 67, 74, 76, 104, 105, 121, 124 дүгээр сургуулийн 671 сурагч хамрагдаж, суралцагчдад судлагдахуун бүрээр даалгаврын гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Боловсролын үнэлгээний төвөөс ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөд зориулсан элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл мэдээллийн сургалтыг сургууль бүрт зохион байгуулсан. Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд нийслэлийн Боловсролын Газраас батлагдсан																															

		<p>удирдамжийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдын дунд математик, монгол хэл, нийгмийн ухааны хичээлээр “Амжилтын гараа” 1, 2 дугаар шатны уралдааныг 4, 5 дугаар саруудад амжилттай зохион байгууллаа. Уралдааны 1 дүгээр шатанд 18 сургуулийн давхардсан тоогоор 6486, 2 дугаар шатанд 18 сургуулийн давхардсан тоогоор 4758 суралцагчид хамрагдаж, 106, 105, 65, ИЦ 1-р ахлах, 121 дүгээр сургуулиуд эхний 5 байранд орсон. Дүүргийн олимпиадыг тус дүүргээс сонгогдсон УИХ-ын 6 гишүүн олимпиадыг өөрийн нэрэмжит болгон ивээн тэтгэлээ. Үүнд: Физикийн олимпиадад 7-12 дугаар ангийн 456 суралцагчид, 20 багш, монгол хэлний олимпиадад 6-12 дугаар ангийн 1171 суралцагч, математикийн олимпиадад 5-12 дугаар ангийн 533 суралцагчид, 65 багш, түүх, нийгмийн олимпиадад 9, 12 дугаар ангийн 337 суралцагчид, 9, 12-р ангийн орос хэлний олимпиадад нийт 145 багш, сурагчид оролцлоо. Төрийн болон төрийн бус нийт сургуулиудын 2-12-р ангийн суралцагчдын дунд эх хэлээрээ зөв сайхан, хичээнгүй бичих чадварыг сайжруулах зорилгоор “Цээж бичиг” нэгдсэн ажиллагаа зохион байгуулагдсан. Энэ үйл ажиллагаанд 28 сургуулийн 2-12 дугаар ангийн 1167 бүлгийн 36028 суралцагчид хамрагдсан.</p>				
92		<p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын ахиц, амжилтыг тогтмол дүгнэж, стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ, БХ	100.0
		<p>“Стандарт цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад шинжилгээ хийх удирдамж”-ийн дагуу 2 дугаар сарын 26, 28-ны өдөр эхний шатны “Түвшин тогтоох-1” хөндлөнгийн шалгалтыг 13 хичээлээр 6-11 дүгээр ангийн суралцагчдаас авсан. Шалгалтад тус дүүргийн 26 сургуулийн давхардсан тоогоор 1535 бүлгийн 40749 суралцагчид хамрагдаж дүүргийн дундаж амжилт 21.3%, чанар 65.4%, гүйцэтгэлийн хувь дунджаар 60.7%-тай шалгагдсан байна. “Түвшин тогтоох-2” шалгалтыг 12 хичээлээр 23 сургуулийн 6-11 дүгээр ангийн суралцагчдаас авч, давхардсан тоогоор 1355 бүлгийн 37739 суралцагчид хамрагдаж, дүүргийн дундаж амжилт 26.93%, чанар 71.3%, гүйцэтгэлийн хувь дунджаар 61.0 хувьтай шалгагдсан. 2 удаагийн шалгалтыг харьцуулахад амжилт 5.63%, чанар 5.9%, гүйцэтгэлийн хувь 0.3%-ийн өсөлттэй шалгагдсан байна.</p>				
93	<p>2.3.6. Хүүхдийг амьдрах ухаан, бие даах чадвар, харилцааны зөв дадал хэвшилд сургаж, үндэсний бахархал, өргөн цар хүрээний сэтгэлгээтэй иргэн болгон төлөвшүүлнэ.</p>	<p>Засаг даргын нэрэмжит “Хүн болох багаасаа” хүмүүжлийн аяныг сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ, БХ	100.0
		<p>“Хүүхдийг амьдрах ухаан, бие даах чадвар, харилцааны зөв дадал хэвшилд сургаж, үндэсний бахархал, өргөн цар хүрээний сэтгэлгээтэй иргэн болгон төлөвшүүлэх” зорилтын хүрээнд цэцэрлэгийн өмнөх насны хүүхдүүдийн дунд дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хүн болох багаасаа” хүмүүжлийн аяныг зохион байгуулсан. Аянд төрийн өмчийн 46 цэцэрлэг, төрийн бус өмчийн 61 цэцэрлэгийн 22419 хүүхэд багачууд, эцэг эх, багш ажилтнууд хамрагдлаа. Аяны хүрээнд цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Ардын урлагаас өвлөж суралцагчаа” ардын язгуур урлагийн наадам, ухаалаг утас, дэлгэцээс ангид байх, улмаар донтох эмгэгт өртөх, буруу хэвшилтэй болох эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эерэг дадал” сэдэвт</p>				

		хөгжүүлэх үйл ажиллагаа, “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн сэтгэл зүйн онцлог, хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, ”Бага насны хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлог”, “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтууд, туршлага солилцох, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа зэрэг олон талт ажлуудыг амжилттай зохион байгууллаа.				
94		Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Монгол хүн” хүмүүжлийн аян, “Эх хэл соёлоо дээдэлье” аян зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		УИХ-ын гишүүн Д.Сумьяабазарын нэрэмжит жил бүр уламжлал болгон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг ахиулах, багш нарын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, сурагчдын монгол уламжлал, ёс заншлаа дээдлэн хүндэтгэж, эх хэлээрээ бахархах үзэл бүхий иргэн болж төлөвшүүлэх зорилгоор “Эх хэл, соёлоо дээдэлье” аяныг сарын хугацаанд зохион байгуулсан. Аяны үйл ажиллагаанд дүүргийн ерөнхий боловсролын төрийн болон төрийн бус өмчийн сургуулиудын 6-12 дугаар ангийн сурагчид, монгол хэл, бичиг, уран зохиолын багш, сургуулийн удирдах ажилтнууд хамрагдлаа. Аяны хүрээнд сургууль бүр ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, 11 дүгээр ангийн сурагчдын дунд “Миний эх хэл” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, 8 дугаар ангийн сурагчдын дунд “Би эх хэлээрээ зөв, түргэн уншдаг” уншлагын уралдаан, 7 дугаар ангийн сурагчдын дунд эх хэлний шалгалт, багш нарын дунд эх хэл бичгийн шалгалт, сургууль бүр багш, сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж, аяны үйл ажиллагааг эцэг эх, олон нийтэд сурталчлах ажлууд хийгдсэн. Аяны үйл ажиллагаанд амжилттай оролцсон багш, сурагчид, монгол хэл, бичиг, уран зохиолын заах аргын нэгдлийг шалгаруулж, дүүргийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа. Нийслэлийн ерөнхий боловсролын бага ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болон явагддаг “Би монгол хүүхэд” наадам Ирээдүй цогцолборын 3 дугаар бага сургууль дээр явагдлаа. Наадамд нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 17 сургууль оролцсон. Ёс заншлын наадмын эхний байрт Баянзүрх дүүргийн “Шавь” цогцолбор сургууль, “Ирээдүй” цогцолборын 3 дугаар бага сургууль, 67 дугаар сургууль шалгарсан. “Монгол хүн” хүмүүжлийн аяны хүрээнд “Монгол хүн бэлтгэхэд ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэх үүрэг оролцоо” сэдэвт сургалт, зөвлөгөөн Улаанбаатар паласын Их танхимд боллоо. Зөвлөгөөнд сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нар гэсэн 582 хүн хамрагдлаа.				
95	2.3.7. Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлнэ.	Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багш нарыг мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтуудад үе шаттайгаар хамруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор 3 удаагийн шинэчилсэн хөтөлбөрийн сургалт болон багшийн ёс зүйн сургалтуудыг зохион байгуулсан. Сургалтад 290 багш, туслах багш, удирдлагууд хамрагдсан байна.				

96		Төрийн бус цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
<p>Дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг даргатай төрийн бус өмчийн 8 сургууль, сургуулийн өмнөх боловсролын 63 байгууллагын төсвийн шууд захирагч нар үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хүн болох багаасаа” аяны хүрээнд төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийг татан оролцуулж, бүсчлэн шалгаруулснаас “Эерэг дадал” сэдэвт хөгжүүлэх үйл ажиллагааны төрөлд “Билгүүн-Ундарга”, “Гурван хөгжил”, “Бадди баавгай”, “Гэрэлт-Оюу”, “Гэгээн өргөө” цэцэрлэгийн багш нар, язгуур урлагийн төрөлд “Зөв эхлэл”, “Гурван хөгжил”, “Чухаг”, “Мөнх-Ундарга”, “Мөндөөхэй” цэцэрлэг, бүтээлч цэцэрлэгээр “Анаанда” цэцэрлэг, шилдэг цэцэрлэгээр “Дэлгэрхэн ургамал” цэцэрлэгийн хамт олон тус тус шалгарч, Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулсан. “Эх хэл соёлоо дээдэлье” аяны хүрээнд төрийн бус өмчийн сургуулиудын дунд “Миний эх хэл” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан, “Би эх хэлээрээ зөв, түргэн уншдаг” уншлагын уралдаан, багш, сурагчдын дунд эх хэл бичгийн шалгалтуудыг зохион байгуулж, нэгдсэн дүнгээр тэргүүний сургуулиар Д.Жаргалсайхан захиралтай Тольт сургуулийн монгол хэл, бичиг, уран зохиолын заах аргын нэгдэл шалгарч, аяны төрөл тус бүрээр тэргүүн байруудад шалгарсан багш, сурагчдыг Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн эрхлэгч нарын дунд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг Иргэний танхимд зохион байгуулсан. Төрийн бус өмчийн цэцэрлэгийн нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын дундаж нормативын санхүүжилт, хүүхдийн тоонд хяналт тавих ажлыг зохион байгуулсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн бус өмчийн сургуулийн өмнөх боловсролын удирдах ажилтнуудыг арга зүйгээр хангах, дүүргийн хэмжээнд түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Сургуулийн өмнөх боловсролын стандартыг хэрэгжүүлэх арга зам, сургалтын хөтөлбөр”, “Төсвийн шууд захирагч нарын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт” зэрэг сэдвүүдээр мэргэжил арга зүйн зөвлөн туслах сургалтыг төрийн бус өмчийн 63 цэцэрлэгийн удирдах ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан.</p>						
97	2.3.8. Багшийн мэргэжил, боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадваржуулна.	Хамтын ажиллагаатай байгууллагуудтай туршлага судлах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
<p>УИХ-ын гишүүн Н.Учралын санаачилгаар “Багш хөгжлийн академи-2018” залуу багш нарын уулзалт Олон улсын хүүхдийн Найрамдал төвд зохион байгуулагдсан. Уулзалтад нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн залуу багш нарын холбооны ахлагч багш нар оролцож, дүүргийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 28 залуу багш нар хамрагдлаа. Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Шинэ үе” МСҮТ-ийг ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлахын сургалтын менежерүүдэд танилцуулах хамтран үйл ажиллагаа явуулах зорилгоор уулзалт зохион байгуулсан. Боловсролын салбарын удирдах ажилтны ахмад, дунд, залуу 3 үеийн “Алтан хэлхээ” уулзалт өдөрлөгийг 67 дугаар сургууль дээр зохион байгуулсан. Уулзалт өдөрлөгөөс боловсролын</p>						

	<p>байгууллагын удирдах ажилтнуудад хандсан ахмад, залуу үеийн холбоог бэхжүүлэх, туршлага түгээн дэлгэрүүлэх талаар үйл ажиллагааны зөвлөмж гаргасан. Нийслэлийн Боловсролын газраас “Туршлага судлах, түгээн дэлгэрүүлэх үзүүлэх сургууль-2018” ажлыг нийслэлийн 8 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан ажлыг дүгнэж, урамшуулах “Нийслэлийн боловсрол-Бидний туршлага” хүндэтгэлийн арга хэмжээ 4 дүгээр сарын 26-ны өдөр Монголын Хүүхдийн ордонд болсон. Нийслэлийн хэмжээнд боловсролын шинэчлэлийг эрчимжүүлэх, боловсролын байгууллагын менежмент, хүний нөөцийн чадавхийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан үзүүлэх сургуульд 600 гаруй шилдэг бүтээл танилцуулагдсанаас 24 шилдэг бүтээлийг шалгаруулан “Батламж” гардууллаа. Тус дүүргээс УИХ-ын гишүүдийн санаачилсан дүүргийн олимпиадууд, “Багш солилцоо” хөтөлбөр, дүүргийн Засаг даргын санаачилсан “Алтан ЭЕШ” ажлууд шалгарч “Батламж” гардан авлаа. Тайвань улсын их дээд сургуулиудтай танилцах, хамтран ажиллах гэрээ байгуулах ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн захирлуудын 27 хүний бүрэлдэхүүнтэйгээр туршлага судлах ажлыг зохион байгуулсан. Дүүргийн ИТХ-ын дарга Б.Мөнхцэцэг тэргүүтэй нийт 24 цэцэрлэгийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй баг БНСУ-ын Чэжү хотын сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаатай танилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулсан. БНХАУ-ын Хөлөнбуйр хотын Хайлаар дүүргийн ерөнхий боловсролын бага, дунд сургуулиудтай хамтын ажиллагааны хүрээнд тус хотод айлчлал хийж, хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааны бүрэлдэхүүнд 67, 76, 129 дүгээр сургуулийн захирлууд орж ажилласан.</p>					
98	<p>Багшийн ур чадварыг хөгжүүлэх сургалтуудад ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг хамруулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	100	НХХ, БХ	100.0	
<p>Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нарын дунд монгол хэл, дүрслэх урлаг, технологи, математик, Хүн орчин-хүн байгаль, сургалт дэмжих үйл ажиллагаа гэсэн 5 судлагдахууны багаар хуваагдан хичээл тус бүрийн арга зүйн сургалтыг 105, 106, Ирээдүй цогцолборын 3 дугаар бага сургууль дээр тус тус зохион байгуулж, нийт 817 багш хамрагдлаа. Нийслэлийн Боловсролын газар, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн хуваарьт сургалтад 3 хүртэлх жил ажиллаж байгаа 16 бага ангийн сургалтын менежерүүд хамрагдсан. Төрийн өмчийн цэцэрлэгийн 46 арга зүйч нарт “Google drive” программын сургалтыг зохион байгуулсан. Бага насны хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хамгаалах, эцэг эх, цэцэрлэгийн багш, ажилтнуудад хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг чадвар олгох, багшийн ёс зүй, харилцааг сайжруулж, багшийг чадваржуулах зорилтын хүрээнд “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран “Хүүхэд хөгжил хамгаалал-Багшийн ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 100 багшийг хамруулсан. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор “Тогтвортой хөгжил-сургуулийн өмнөх боловсрол” улсын 2 дугаар зөвлөгөөн зохион байгуулагдаж, төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 96 эрхлэгч, арга зүйч нар оролцсон. “Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол” улсын 2 дугаар зөвлөгөөн зохион байгуулагдаж, нийт 26 сургуулийн 360 удирдах ажилтан, багш нар оролцлоо. “Боловсролын орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 12 дугаар сургууль дээр зохион байгуулж, төрийн</p>						

		болон төрийн бус өмчийн цэцэрлэгийн 100 удирдах ажилтан хамрагдсан. Монгол улсын шадар сайд Ө.Энхтүвшингийн ивээл дор зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшиг ба хариуцлагатай иргэн” сэдэвт лекц, нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв дээр болж сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан нар хамрагдсан.				
99	2.3.9. “Насан туршийн боловсролын төв”-өөр олгох сургалтын хүртээмжийг сайжруулж, онлайн хувилбарт хэлбэрээр хүргэж, сургууль завсардалтыг бууруулна.	Сургууль завсардалтыг бууруулах ажлын хүрээнд хүүхэд, залуучууд, иргэдэд ерөнхий боловсрол олгох сургалтуудыг танхимаар болон цахим хэлбэрээр зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		Насан туршийн боловсролын төвөөс сургууль завсардсан болон огт сургуульд суугаагүй хүүхэд, иргэд илрүүлэх, төвд хамруулан суралцуулах, сургууль завсардалтын хувийг бууруулах үүднээс 2 удаагийн судалгаа боловсруулан авсан. Судалгааны дүнд давхардсан тоогоор, огт суугаагүй болон сургууль завсардсан 88 хүүхэд байгаагийн 4 нь хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэггүй болон сургууль завсардсан 51 иргэн байгаагаас 8 нь хөгжлийн бэрхшээлтэй байсан. Огт суугаагүй болон сургууль завсардсан 20 хүүхдийн 8 нь төвд хамрагдан суралцаж, 10 иргэн бичиг үсгийн боловсрол олгох сургалтад хамрагдаад байна. 2018-2019 оны хичээлийн жилд Толгойт, Баянхошуу, Төвийн гэсэн 3 бүсээр 7 танхимд 12 бүлгээр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх дүйцсэн хөтөлбөрийн танхимын болон онлайн сургалтыг 194 хүүхэд, иргэдийг хамруулан батлагдсан хөтөлбөр, хуваарийн дагуу зохион байгуулж байна. Үүнээс: <ul style="list-style-type: none"> • Бага боловсролд-123 • Суурь боловсролд-50 • Бүрэн дунд боловсролд-21 Хөдөлмөрийн насны иргэдэд дүйцсэн хөтөлбөрөөр бүрэн дунд боловсрол нөхөн эзэмшүүлэх онлайн сургалтад 21 иргэн хамрагдан гэрээний дагуу суралцаж байна. 2018-2019 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтад 13 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэд хамрагдан суралцаж байна.				
100		Хүн амын дунд амьдрах, аж төрөх ухааны чадвар, дадлыг эзэмшүүлэх үндсэн 5 чиглэлийн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэдэд олгох насан туршийн боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		Албан бус насан туршийн боловсролын төвийн үндсэн чиглэлийн дагуу нийт 2475 иргэнд батлагдсан хөтөлбөр, хичээлийн хуваарийн дагуу дараах сургалтуудыг зохион байгуулсан. Амьдрах ухааны боловсролын сургалтад 777, иргэний боловсролын сургалтад 327, ёс суртахуун, төлөвшлийн боловсролын сургалтад 616, гоо зүй, мэдрэмжийн боловсрол сургалтад 395, гэр бүлийн боловсрол сургалтад 198, шинжлэх ухааны боловсролын сургалтад 50 иргэн тус тус хамрагдсан.				

101	2.3.10. Албан бус боловсролын үйлчилгээг сургалтын байртай болгон үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.	<p>Насанд хүрэгчдийн сургалтын орчин бүрдүүлэх, сайжруулах, техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах</p> <p>Сургалт үйл ажиллагааг зохион байгуулахдаа төрийн болон төрийн бус байгууллагыг түшиглэн сургалтын орчин бүрдүүлэн техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх ажилд анхааран ажиллаж байна. Тус төв нь ерөнхий боловсролын 12, 42, 65, 76, 124 дүгээр сургууль, дүүргийн Онцгой байдлын хэлтэс, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төв, “Харилцааны хөгжил төв” төрийн бус байгууллага зэрэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Сургалтын орчинг сайжруулах ажлын хүрээнд байгууллагын төсвөөр сурагчийн сандал 8 ширхэгийг шинээр нэмж аваад байна. Албан бус-насан туршийн боловсролын төвийн байр, хүүхэд зөөх автобус, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хэрэгцээний судалгааг БСШУС-ын сайд Ц.Цогзолмаад 01/3074 дугаар албан бичгээр хандсан. Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн эзэмшилд байдаг цагдаагийн байрыг нийслэлийн хөрөнгө оруулалтаар 20.0 сая төгрөгийн засварын ажлыг “Намнан хайрхан констракшн” ХХК хийж гүйцэтгэн тус төвд хүлээлгэн өгсөн. Энэ байрыг хүлээн авснаар насанд хүрэгчдийн сургалтыг зохион байгуулах сургалтын танхимтай болж сургалт үйл ажиллагааг зохион байгуулж байна.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
2.4. Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.						
102	2.4.1. Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.	<p>Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд “Хүрэл тулга”, “Уран жиргээ”, “Хүүхдийн найрал” дууны шилдэг хамтлаг шалгаруулах уралдаан зохион байгуулах</p> <p>Дүүргийн Засаг даргын А/103 дугаар захирамжаар 3 дугаар сард их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит өсвөрийн яруу найрагчдын “Хүрэл тулга-2018” наадмыг зохион байгууллаа. Уралдаанд 100 гаруй сурагчид 2 насны ангиллаар оролцсоноос 12 сурагч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдаж, 6 сурагч нийслэлийн уралдаанд амжилттай оролцсон. Найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах уралдаанд дүүргийн ерөнхий боловсролын 25 сургуулиас 7 сургуулийн 560 хүүхэд оролцлоо. Уралдаанд 62 дугаар сургууль тэргүүлж, 65, Ирээдүй цогцолбор сургуулиуд удаах байруудыг эзэлж нийслэлийн уралдаанд оролцсоноос 62 дугаар сургууль 3 дугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ БХ	100.0
103		<p>Соёлын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах</p> <p>Дүүргийн нутаг дэвсгэрийн соёлын үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулсан. Шалгалтад нийт 85 аж ахуйн нэгж хамрагдсанаас 5 аж ахуйн нэгжид зөрчил илэрснийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0

104		Соёлтой өрх, хороог шалгаруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0
“Шилдэг өрх” шалгаруулах болзолт уралдааны шалгаруулалтыг дүүргийн хэмжээнд зарлан “Шилдэг тохижилттой өрх”, “Шилдэг нийгмийн идэвхтэй өрх”, “Шилдэг халамжлан хүмүүжүүлэгч өрх”, “Шилдэг соёлч өрх”, “Шилдэг хүмүүнлэг өрх” зэрэг 5 төрлөөр зохион байгуулж, хороо тус бүрээс нэг, нэг шилдгүүдийг шалгаруулсан. Дүүргээс шалгарсан 31 дүгээр хорооны иргэн Л.Цэцэгмаа, 32 дугаар хорооны иргэн Н.Шаравын гэр бүлүүд нийслэлийн шилдэг өрхүүдээр шалгарсан.						
105		Угийн бичиг хөтөлдөг иргэдийн судалгааг гаргах, мэдээллийн сан бүрдүүлэн, сургалтуудыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0
Угийн бичиг хөтөлдөг 84 иргэдийн судалгааг гарган мэдээллийн сан бүрдүүллээ. Угийн бичиг хөтлөх арга зүйг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Угийн бичиг хөтлөлт” сэдэвт сургалтыг 2 удаа, давхардсан тоогоор хороодын 265 хэсгийн ахлагч нарыг хамруулан зохион байгуулсан.						
106	2.4.2. Аз жаргалтай хот хөтөлбөрийн хүрээнд иргэдэд соёл урлагийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэнэ.	Соёлын биет бус өв тээгч иргэдийг сурталчлах, улс, нийслэлийн уралдаан тэмцээнд амжилттай оролцуулахад дэмжлэг үзүүлэх, “Дээлтэй монгол” наадмыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
Дүүргийн Засаг даргын 2018 оны А/298 дугаар захирамжаар “Ардын урлагийн их наадам-2018” улсын наадмын анхан шатны шалгаруулалтыг бүсийн хэмжээнд зохион байгуулж 150 иргэдийг хамрууллаа. Наадмын анхан шатны шалгаруулалтыг яруу найраг, билэг урлаг, дүрслэх урлаг, бие биелгээ, уртын дуу, морин хуур, хөөмий, уламжлалт болон сонгодог, ардын бүжгийн төрлөөр зохион байгуулж Толгойт бүс тэргүүн байр, Өнөр бүс хоёрдугаар байр, Төвийн бүс гуравдугаар байр, Баянхошуу бүс дөрөвдүгээр байр тус тус эзлэн Засаг даргын өргөмжөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Шилдэг 25 оролцогч улсын их наадамд оролцон 7 төрөлд амжилт үзүүлсэн. Тус наадамд 6.1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагддаг “Дээлтэй Монгол” наадамд дүүргийн Засаг даргын 2018 оны А/301 дүгээр захирамжаар 32 хорооны 700 гаруй иргэн олон үндэстэн, ястаны хувцастай наадмын жагсаалд оролцлоо. Үндэсний хувцасаараа гоёх наадмын уралдааны номинацуудад: -Дүүргүүдийн үндэсний хувцастай парад -500 иргэн -Монгол үндэсний хувцастай гадаадын зочдын шилдэг хос -Үндэсний дээлтэй хамгийн бяцхан оролцогч-24 -Хамгийн сайхан дээлтэй хос- 4 хос оролцож “Хамгийн сайн зохион байгуулалттай, идэвхтэй оролцсон дүүрэг”-ээр шалгарч “Өргөмжлөл” 1.5 сая төгрөгөөр шагнагдсан.						
107		Соёлын ордны дэргэдэх “Хүүхэд хөгжүүлэх” дугуйлангийн сурагчдын ардын урлагийн хамтлагийг байгуулах, шавь сургалтыг зохион байгуулж хүүхдүүдийг өв уламжлал, ёс заншилд сургаж төлөвшүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ Соёлын ордон	100.0

	Соёлын ордны дэргэдэх хүүхэд хөгжүүлэх 6 төрлийн дугуйланд нийт 85 хүүхэд хамрагдаж байна. Үүнд морин хуур-8, хөөмий-3, дуу-22, төгөлдөр хуур-8, гар урлал-16 хүүхэд байна. “Өөрөө сурах төв” төслийн хүрээнд хэрэгжиж байгаа гар урлалын сургалт 7 хоногт 2 удаа хичээллэж 5-12-р ангийн 25 сурагчид хамрагдан, шүрэн урлал, туузан урлал, гоёл чимэглэл, шигтгээн урлал, үсний гоёл, цаасан урлал зэрэг олон зүйлийг урлаж сурсан. Ардын уламжлалт өв соёл, ёс заншлаа дээдлэх, ахуйн соёл, тоглоом наадгайг сэргээн өвлүүлэн үлдээх зорилгоор ардын ёс заншлын танхимыг ажиллуулж 16-24 хүүхэд хамрагдаж байна. Мөн Соёлын ордон, ДЗОУБ-тай хамтран зорилтот бүлгийн 43 хүүхдийг 5 төрлийн дугуйланд хамруулсан.				
108	Соёлын ордны ажилтан албан хаагчдыг мэргэшүүлэх, мөн мэргэжлийн боловсон хүчнээр хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, Соёлын ордон	100.0
	Соёлын ордны удирдлага, албан хаагчдыг “Угийн бичиг хөтлөх арга зүйн”, “Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх арга зүй” болон мэргэжлийн байгууллагуудын тайз, гэрэлтүүлгийн инженерүүдэд зориулсан сургалтад тус тус хамруулсан.				
109	Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	70.0
	Дүүргийн Засаг даргын А/124 дүгээр захирамжаар түүх соёлын үл хөдлөх 12 дурсгалт зүйлст “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлс”-ийн хадгалалт, хамгаалалтын байдалд шалгалт хийж, мэдээллийн санг шинэчилсэн. Нийслэлийн Соёл урлагийн газраас дүүргийн ЗДТГ, ОНАБХ-ын 05 дугаар анги, “Өнөр” СӨХ, ОУ-ын Найрамдал зуслан, Аврах тусгай анги, Жаргалант тосгоны Соёлын ордон, 16, 32 хороодтой “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлүүдийн хөшөө дурсгалын хадгалалт хамгаалалтыг хангах гэрээ” байгуулсан бөгөөд хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.				
110	Жаргалант тосгоны номын сангийн номын баяжилтыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, Соёлын ордон	100.0
	Номын сан 3000 ширхэг номын фондтой бөгөөд 2018 онд 300 ширхэг шинэ номоор баяжилт хийж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр ханган, иргэдэд цахимаар үйлчилгээг үзүүлэх бэлтгэлийг бүрэн хангаад байна. Иргэд, хүүхэд залуучуудын ном унших хүсэл сонирхлыг өрнүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.				
111	Төрийн байгууллагуудын номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0
	Төрийн өмчийн ерөнхий боловсролын 15 сургуулийн номын санчдыг Хүүхдийн төв номын сангаас зохион байгуулсан “Номын гэр” төслийн сургалтад, 3 номын санчийг БМДИ-ийн 5 дахь жилийн сургалтад, Соёлын ордны 1 номын санчийг Улаанбаатар хотын номын сангаас зохион байгуулсан “Кoнa” төслийн хүрээнд цахим системд ном хэрхэн шивж оруулах, хуучны элэгдэж хуучирсан номыг сэлбэн засах арга зүйн сургалтад тус тус хамруулж номын санчдын ур чадварыг дээшлүүлсэн.				

112	2.4.3. “Соёл урлагийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.	Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, Соёлын ордон	70.0
		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны А/66 дугаар тогтоолоор “Соёл урлагийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг батлуулж 2018 онд хэрэгжүүлэх 17 зорилтыг хяналтад авч ажилласнаар хэрэгжилт 70.0 хувьтай байна.				
113	2.4.4. Соёлын ордон байгуулж иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ	Дүүргийн соёлын ордон шинээр барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ	100.0
		Соёлын ордны шинэ барилга 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдахаар батлагдсан.				
114	2.4.5. Сургалтын хөтөлбөрт түүх, соёл, үндэсний зан заншил, соёлын үнэт зүйлсийг таниулах, хувь хүний соёл, өв уламжлал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэн төлөвшүүлэх ажлуудыг зохион байгуулна.	Ерөнхий боловсролын сургуулийг түшиглэн ардын урлагаас суралцах төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулж, сурталчлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, БХ	100.0
		Соёлын эртний өвийг хамгаалах, сэргээх, сурталчлах, хүүхэд залуучуудын гоо зүйн түвшинг дээшлүүлэх, ардын уламжлалт ёс заншлыг өвлүүлэх, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор төрийн өмчийн 21 сургуульд “Монгол зан заншлын танхим”-ыг ажиллуулж үндэсний тоглоом, наадгай, зүйр цэцэн үг, цээрлэх ёс, эртний хаадуудын зурган самбар, үзүүлэнгээр тохижуулан ажиллаж байна.				
2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлнэ.						
115	2.5.1. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлэх гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн байртай болж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэн, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн байрны барилгын зураг төсвийг хийлгэх зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	40.0
		Барилгын зураг төсвийг хийлгүүлэх хүсэлтийг нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт, газрын асуудлыг шийдвэрлэх талаар дүүргийн Газрын албанд тус тус албан бичгээр хүргүүлсэн.				
116		Хүчирхийллийн эсрэг дүүргийн жишиг төв байгуулах /4 дүгээр хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	ҮБ
		4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Дэлхийн зөн Толгойт орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн Соёл хүмүүжлийн төвийн барилгыг орон нутгийн өмчид шилжүүлэх албан хүсэлтийг “Дэлхийн зөн Монгол” ОУБ-д тавьсан боловч одоогоор хариу ирүүлээгүй байна. Барилгын засварын ажлын зураг төсвийг 190.0 сая төгрөгийн өртөгтэйгээр боловсруулан “Дэлхийн сайн санаат хүмүүс”, “Койка” ОУБ-дад тус тус хандсан.				
117		Хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах,	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ГБХЗХХ,	100.0

		үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг авч ажиллах				
		Хөгжил, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, чадваржуулах 32 удаагийн сургалтад давхардсан тоогоор 67 албан хаагчдыг хамруулсан. Хороодын нийгмийн ажилтнууд, хэсгийн ахлагчид, хамтарсан багийн гишүүд болон ЕБС-ийн багш, нийгмийн ажилтнууд, өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах 17 удаагийн сургалт өдөрлөг зохион байгуулж, давхардсан тоогоор 2436 албан хаагчдыг хамруулсан. Дүүргийн Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын 2018 оны 144 дүгээр тушаалаар хамтарсан багийн гишүүдийн чадваржуулах 2 сарын аяныг зарлан 32 хороодод ажиллан мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллалаа.				
118	2.5.2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, иргэдийг хамгаалах төвийг байгуулна.	Хүүхэд түр хамгаалах байрыг засварлах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	70.0
		Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Хүүхэд түр хамгаалах байранд өргөтгөл хийх, засварлуулахад шаардлагатай материалуудын тооцоо судалгааг бүрдүүлэн Азийн хөгжлийн банкинд хүргүүлснээр 2019 оны төсөвт суулгахаар шийдвэрлэсэн. Хүүхэд түр хамгаалах төвийг 2 давхарлан, өргөтгөж засварын ажил хийх болсонтой холбогдуулан дүүргийн Засаг даргын 2018 оны А/70 дугаар захирамжаар барилгын өмрөлт, мөөгөнцөр болон хийцийн бат бөхийн элементүүдэд судалгаа хийн дүгнэлт гаргуулах, цахилгааны 380 квт-н техникийн нөхцөл, цэвэр бохир усны техникийн нөхцөлийг тус тус хийлгэсэн.				
119		Хүүхэд хамгаалал чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ	100.0
		Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хөгжил, хамгааллын чиглэлээр УИХ, ЗГХА, нийслэл, дүүргийн ИТХ, ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагууд, хороод, эмнэлэг, боловсролын байгууллагууд, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг ангиуд, Дэлхийн зөн Монгол ОУБ, Гүүд нейборс, Японы хүүхдийн ивээх сан, Дэлхийн сайн санаат хүмүүс, Азийн хөгжлийн банк, асрамж, халамжийн төвүүд зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал Дэлхийн зөн Монгол ОУБ-ын “Толгойт”, “Сонгинохайрхан”, “Баянхошуу” ОНХХ-тэй хамтран албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах сургалтууд болон олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг түлхүү зохион байгуулсан бол Чингис СООСЭ Олон улсын их сургуультай хамтран мэргэжил сонголтын зөвлөгөө өгөх, лекц, сургалт явуулах, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж 2 удаагийн арга хэмжээнд 5200 оюутан, залуучуудыг хамруулсан.				
120		“Хүүхдийн тусламжийн утас-108”, “Гэр бүлийн хүчирхийллийн утас-107”-тай хамтран дуудлагын дагуу шуурхай ажиллаж, шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	100.0

		<p>“Хүүхдийн тусламжийн утас 108”-аас 947 дуудлага мэдээлэл хүлээн авсан. Үүнд: бие махбодийн хүчирхийлэлд өртсөн асуудлаар-137, сэтгэл санааны хүчирхийллийн асуудлаар-67, бэлгийн хүчирхийллийн асуудлаар-49, үл хайхрах хүчирхийллийн асуудлаар-184, хүүхдийн эрхийн зөрчил-38, хараа хяналтгүй хүүхдийн асуудлаар-73, асрамж халамжийн асуудлаар-18, сургуулийн орчинд-55, хүүхэд нас барсан-15, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар-129, бусад-78 дуудлага ирсэн байна. 829 дуудлагыг бүрэн шийдвэрлэж, 51 дуудлага шийдвэрлэх шатандаа явж байна. Дуудлагын дагуу шуурхай ажиллан шаардлагатай арга хэмжээг авч, асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тухай бүрт нь “Хүүхдийн тусламжийн утас 108”-д болон huuhdiinutas@yahoo.com цахим хаягаар тогтмол мэдээллэн ажилласан. “Гэр бүлийн хүчирхийллийн утас-107”-оос 113 дуудлага ирснээс 95 дуудлагыг шийдвэрлэж, 18 дуудлага шийдвэрлэх шатандаа явж байна.</p>				
121	2.5.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын эрхийг хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгааг тогтмолжуулан, гэр бүлд суурилсан хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжинэ.	“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд олон талт арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	100.0
		<p>“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан 8 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 4318 хүүхдийг хамруулсан. Тухайлбал “Ид шидийн аялал” хүүхдийн жүжгийг АСА циркэд зохион байгуулж дүүргийн 32 хороо болон асрамж халамжийн төвд өсөж буй 1500 хүүхэд үзүүлж, бэлэг гардуулснаас гадна ИТХ-ын ажлын алба, ГБХЗХХ, дүүргийн томоохон аж ахуйн нэгжүүд хамтран хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулсан. Мөн дүүргийн 32 хороо тус бүр дээр хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.</p>				
122		Өсвөр үе, хүүхэд, залуучуудад гэр бүлийн төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ	100.0
		<p>Зэвсэгт хүчний 013, 150 дугаар анги болон Хилийн цэргийн 0151 дүгээр ангиудын 520 алба хаагчид, дүүргийн 32 хорооны 192 хэсгийн ахлагч нарт “Гэр бүл төлөвлөлт ба хосуудын харилцаа”, ерөнхий боловсролын 123 дугаар сургуулийн 29 сурагчдад “Шилжилтийн насны онцлог” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулсан бөгөөд нийт 741 хүнийг хамруулсан. Монгол Улсын Боловсрол Соёл Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2018 оны А/453 дугаар тушаалаар 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн Эрүүл мэндийн хичээлийг ахлах болон дунд ангийн сурагчдад тус бүр 35 цагаар оруулахаар баталсныг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн хичээлийг 22 сургуулийн 4478 хүүхэд судалж байна.</p>				
123		Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага MNS5633:2013 стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ МХХ	100.0
		<p>“Хүүхдийн зуслангийн ерөнхий шаардлага” Монгол Улсын MNS 5633:2013 стандартын хэрэгжилтэд хяналт тавьж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор албан ёсны зөвшөөрөлтэй “Нарс” зуслан, Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборын үйл ажиллагаанд хяналт хийж, хүүхэд хамгааллын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.</p>				

124		Зорилтот өрхийн хүүхдүүдийг зусланд амраах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ	100.0																														
Дүүргийн зорилтот бүлгийн хүүхдүүдийн хөгжил, оролцоог дэмжих ажлын хүрээнд 6, 7, 22 дугаар хорооны нийт 7 хүүхдийг Анар, Янзага зэрэг зусланд амруулаад байна. “Хүүхдийн оролцооны байгууллагуудын зөвлөгөөн”-д 21 аймаг, 9 дүүргээс 600 хүүхэд оролцсон арга хэмжээ Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд дүүргээс 37 хүүхэд хамрагдсан бөгөөд Бидний манлайлал, Бидний оролцоо, Бидний байгаль дэлхий, Бидний эрүүл мэнд зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэгт оролцож 3 хоногийн турш үнэ төлбөргүй амарч, шинэ найз нөхөдтэй болж чөлөөт цагаа өнгөрүүлсэн.																																				
125	2.5.4. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Асрамж халамжийн төвд байгаа хүүхдүүдийн амьдралын нөхцөл байдалтай танилцаж шаардлагатай арга хэмжээг авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ, ГБХЗХХ	100.0																														
Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг асрамж, халамжийн 16 төвд амьдарч байгаа дүүргийн харьяалалтай 213 хүүхдүүдийн амьдралын нөхцөл байдалтай танилцахад бичиг баримтгүй 9 хүүхэд, захирамжгүй 28 хүүхэд, хүүхдийн мөнгө авдаггүй 39 хүүхэд байсан. Үүнээс 23 хүүхдийг дүүргийн Засаг даргын 2018 оны А/483, А/534 дүгээр захирамжаар асрамжийн газарт шилжүүлж, 3 хүүхдийг бичиг баримтжуулан, бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.																																				
126		Хөдөлмөр эрхлэгч, хараа хяналтгүй хүүхдүүдийг илрүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ	100.0																														
Хараа хяналтгүй, хөдөлмөр эрхлэгч хүүхдийн илрүүлгийн арга хэмжээг дүүргийн Засаг даргын 2018 оны А/519 дүгээр захирамж, холбогдох байгууллагуудын шийдвэрээр нийт 4 удаа зохион байгуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрийн хогийн цэг, сүм хийд, машин угаалгын газар, мал нядалгааны газар, интернэт, цахим тоглоомын газрууд, худалдаа, үйлчилгээний байгууллагууд, дэн буудал, насанд хүрээгүй хүүхэд хөдөлмөр эрхэлж болзошгүй газрууд, хараа хяналтгүй гуйлга гуйж, хөдөлмөр эрхлэх боломжтой байршлуудад илрүүлэлт хийсний үр дүнд нийт 70 хүүхдийг илрүүлсэн. Эдгээр хүүхдүүдийг эцэг эх асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгч, хүүхэддээ тавих анхаарал халамжаа сайжруулах шаардлагатай байгаа талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажиллаж байна.																																				
127		Эрх нь зөрчигдсөн хүүхдийг илрүүлэх, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, хүүхдийн эрсдлийн түвшинг бууруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ Цагдаагийн хэлтсүүд	100.0																														
Дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос <table border="1" data-bbox="752 1251 1921 1426"> <thead> <tr> <th>№</th> <th>Төрөл</th> <th>2017</th> <th>2018</th> <th>Харьцуулалт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд</td> <td>7</td> <td>26</td> <td>+19</td> </tr> <tr> <td>2</td> <td>Гэмт хэргийн хохирогч хүүхэд</td> <td>14</td> <td>40</td> <td>-26</td> </tr> <tr> <td>3</td> <td>Гэмт хэргийн гэрч хүүхэд</td> <td>3</td> <td>3</td> <td>=</td> </tr> <tr> <td>4</td> <td>Хүүхдийн эрх ашгийг хамгаалж ажилласан байдал</td> <td>24</td> <td>40</td> <td>+16</td> </tr> <tr> <td>5</td> <td>Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажилласан байдал</td> <td>17</td> <td>29</td> <td>+12</td> </tr> </tbody> </table>							№	Төрөл	2017	2018	Харьцуулалт	1	Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд	7	26	+19	2	Гэмт хэргийн хохирогч хүүхэд	14	40	-26	3	Гэмт хэргийн гэрч хүүхэд	3	3	=	4	Хүүхдийн эрх ашгийг хамгаалж ажилласан байдал	24	40	+16	5	Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажилласан байдал	17	29	+12
№	Төрөл	2017	2018	Харьцуулалт																																
1	Гэмт хэрэгт холбогдсон хүүхэд	7	26	+19																																
2	Гэмт хэргийн хохирогч хүүхэд	14	40	-26																																
3	Гэмт хэргийн гэрч хүүхэд	3	3	=																																
4	Хүүхдийн эрх ашгийг хамгаалж ажилласан байдал	24	40	+16																																
5	Хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажилласан байдал	17	29	+12																																

		6	Хүүхдийн сурган хүмүүжүүлэгчээр ажилласан байдал	7	11	+4
		<p>Мөн гэмт хэрэг зөрчилд холбогдон ял хойшлуулсан хүүхдийн зан чанарт нөлөөлөх сургалт хөтөлбөрийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан хүүхдийг дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, хүүхдийн боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, амьдралын эерэг хандлага, зөв дадалтай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглүүлэн ажиллаж байна.</p>				
128	2.5.5. Хүүхэд, залуучуудыг аливаа эрсдэл, хорт зуршил, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх ажлыг зохион байгуулна.	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, эцэг эх, хүүхдүүдийн дунд зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ	100.0
		<p>Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүд, сурагчид, олон нийтэд чиглэсэн 23 удаагийн сургалтаар 1945 иргэнд “Хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх”, “Ахуйн хүрээн дэх осол гэмтэл”, “Хахалт, усанд живсэн үед үзүүлэх анхны тусламж” зэрэг сургалтыг зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2018 оны 02 дугаартай “Хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” албан даалгаврын хүрээнд дүүргийн Засаг даргын 2018 оны А/332 дугаар захирамжаар ажлын хэсэг томилогдон, хүүхдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх, эрсдэл үүсч болзошгүй нөхцөл байдлыг арилгах ажлыг зохион байгуулах удирдамж боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаа. Удирдамжийн хүрээнд төрийн болон төрийн бус өмчийн 31 сургууль, 109 цэцэрлэгт дотоод орчны, 23 сургууль, 100 цэцэрлэгт гадаад орчны аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийсэн. Сургууль цэцэрлэгүүдийн дотоод орчинд цахилгааны утас ил задгай байдал их эрсдэлтэй байсан бол гадна орчинд биеийн тамирын талбай, тохижилт засварын ажил дутуу, авто зам, хурд сааруулагч тэмдэг тэмдэглэгээ байхгүй, хяналтын камерын үзүүлэлт хангалтгүй зөрчил илэрснийг арилгуулах арга хэмжээ авсан.</p>				
129		Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтыг Төрийн өмчийн Ерөнхий боловсролын нийт сургуулийн төгсөх ангийн сурагчдын дунд зохион байгуулах	Ерөнхий боловсролын сургууль, тоо	23	ГБХЗХХ	100.0
		<p>Өсвөр үеийн хүүхдүүдэд архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын хор уршиг, сөрөг үр дагавар, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх тухай мэдлэгийг олгох зорилгоор “Нөлөөллөөс дээгүүр” сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын 26 сургуулийн ахлах, дунд ангийн 3900 сурагчдын дунд үе шаттайгаар зохион байгуулж мэдээлэл хүргэсэн. Мөн архи, согтууруулах ундааны хор уршиг, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх зорилгоор 1300 гаруй өсвөр үе, хүүхэд, оюутан залуучууд, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдийн дунд дэвжээ, сургалт, ярилцлага зэрэг олон төрлийн нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.</p>				
130		Цахим тоглоомын газруудын үйл ажиллагаанд хяналт тавьж, стандартыг мөрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ МХХ, ОБХ	100.0

		<p>Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй интернет кафе, цахим тоглоомын газруудтай Хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтран ажиллах гэрээ байгуулан, чиглэл өгөх сургалтыг зохион байгуулан ажилласан. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/448 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт цахим тоглоомын газрын үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд “Цахим тоглоомын үйл ажиллагааг зохицуулах журам”, “Интернет кафе, цахим тоглоомын үйлчилгээний байранд тавих шаардлага” MNS 6430:2014 стандартын хэрэгжилтийг шалгах, зөрчлийг арилгах зорилгоор Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлыг хэсэг томилогдон 9 дүгээр сарын 25-наас 11 дүгээр сарын 22-ныг хүртэл хугацаанд ажиллалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн интернет кафе, цахим тоглоомын 54 газарт хяналт хийхэд үйл ажиллагаа явуулж байгаа 43, татан буугдсан 11 байсан. Ажлын хэсгийн 7 удаа хуралдаж үйл ажиллагаа явуулахад татгалзах зүйлгүй 19, үйл ажиллагааг 1 сарын хугацаатай хянах 5, үйл ажиллагааг зогсоож, цаашид үйл ажиллагаа явуулахгүй байхад хяналт тавих 11, зөвшөөрөл цуцлуулах 5 цахим тоглоомын газрууд байна. Үйл ажиллагааны зөвшөөрөл цуцлуулах 5 цахим тоглоомын газрын зөвшөөрлийг цуцлуулах тухай албан хүсэлтийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хүргүүлээд байна.</p>				
131	2.5.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт чиглэсэн нийгмийг үйлчилгээг өргөжүүлэх ажлыг дэмжинэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаанд оношлогоонд суурилсан өөрчлөлтүүдийг тогтмол хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	100.0
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоонд суурилсан судалгааг шинэчлэн, нэгтгэн гаргасан.						
		№	Төрөл	2017	2018	Харьцуулалт
		1	Оюуны хомсдолтой	39	68	+29
		2	Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй	73	66	-7
		3	Сэтгэцийн өөрчлөлттэй	48	24	-24
		4	Харааны бэрхшээлтэй	68	54	-14
		5	Тулгуур эрхтэний бэрхшээлтэй	122	114	-8
		6	Дауны синдром	48	59	+11
		7	ДЦП /саажилттай/	277	258	-19
		8	Аутизм	-	21	+21
		9	Зүрхний гажиг	50	32	-18
		10	Цусны хавдартай	13	30	+17
		11	Бусад /бөөрний дутагдал, тархины өвчлөл/	217	240	-23
			Нийт	955	966	+11
132		Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Бид чадна” чуулга уулзалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	НХХ ГБХЗХХ	100.0
Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг олон улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан чуулга уулзалтыг зохион байгуулж, уулзалтаас гарсан санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэн ажиллаж байна. ХБИЭХӨ-ийг угтан “Бид чадна” уриан дор зангиагүй уулзалтыг зохион байгуулж, 50 эцэг эх, 50 залуусыг хамрууллаа.						

133		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ГБХЗХХ	100.0
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 5 дахь өдөр бүр бүсчилсэн хурлыг зохион байгуулж давхардсан тоогоор 1082 хүүхэд, тэдний эцэг эхчүүдэд сэтгэл зүйн болон асаргаа сувилгааны чиглэлээр зөвлөгөөг өгч ажиллаж байна. Дээрх хүүхдүүдээс 786 хүүхдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, 511 хүүхдийн байнгын асаргаанд сунгалт хийн, 77 хүүхдийг шинээр асаргаанд оруулж, 8 хүүхдийг “Тэмүүжингийн андууд” цэцэрлэгт хамруулан ажилласан. Нийт 526 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. Үүнээс 197 иргэн /13 хөгжлийн бэрхшээлтэй/, 329 хүүхэд /8 хөгжлийн бэрхшээлтэй/ байна.						
ГУРАВ. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ 3.1. Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, шинэ технологи нэвтрүүлнэ.						
134	3.1.1. Баянхошуу дэд төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, 30-р хорооны Хилчин хотхоны дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж, авто замын ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТГХШХ, ТНААХ	100.0
Баянхошуу дэд төвд 1000 м3 багтаамжтай усан сангийн ажил 10 хувь, өргөлтийн насос станцын ажил 60 хувь, ус дамжуулах шугам хоолойн угсралт, суурилуулалтын ажил 100 хувь, 4.9 км урттай үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажил 100 хувь, төвийн дулааны эх үүсвэртэй холбох 11и магистраль шугамын өргөтгөлийн барилга угсралтын ажил 68 хувь, бизнес инкубатор болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга угсралтын ажил 60 хувьтай байна. 240 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон. 14 метр өргөнтэй 5.7 км авто замын ажлын гүйцэтгэгчээр Хятад, Германы хамтарсан компани шалгарсан. Ажил 2019 онд эхлэхээр бэлтгэл хангагдаж байна.						
135		30 дугаар хорооны Хилчин хотхоны дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх хөрөнгийн эх үүсвэрийг судлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	ҮБ
2014 онд “Монгол дайван” ХХК ажлыг гүйцэтгэж байгаад дутуу хийж зогсоосон. Улсын Их Хурлын өргөдлийн байнгын хороогоор 2017 оны 11 дүгээр сард иргэдийн оролцоотой хэлэлцүүлэг хийж тендер зарлан дутуу ажлыг хийж гүйцэтгэх шийдвэр гарч Барилга хот байгуулалтын яаманд ажлын хэсэг байгуулагдсан ба хөрөнгийн асуудал тодорхойгүй байна.						
136	3.1.2. Орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар дээрхи, доорхи автомашины давхар зогсоол барина	Орон сууцны хороолол дунд газар дээрх болон доорх автомашины зогсоол барих санал санаачилгыг дэмжин ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	ҮБ
Орон сууцны хороолол дунд газар дээрх болон доорх автомашины зогсоол барих санал ирээгүй болно.						
137		Авто зогсоол байгуулах, зогсоолыг хатуу хучилттай болгох /14, 17, 29 дүгээр хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 25.0 сая төгрөгөөр 29 дүгээр хорооны 22А байрны дэргэд 14 авто машины зогсоолыг “Тэнгэрийн шугам” ХХК, 17 дугаар хорооны 34 дүгээр байрны урд, 14 дүгээр хорооны 13 дугаар байрны баруун талд авто зогсоолыг “Гэрэгэ Констракшн” ХХК тус тус хийж гүйцэтгэсэн.						

138	3.1.3. Замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор авто замуудыг шинээр барих, авто замын өргөтгөл хийх ажлыг зохион байгуулах, зам засварын ажлын чанарыг сайжруулна.	34 дүгээр байрны арын замаас Үйлдвэрчний эвлэлийн гудамж руу Москва хорооллын араар холбох 1.0 км авто замын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	Замын ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	100.0	
139		1 дүгээр хорооллын арын замаас Москва хорооллын араар Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбосон 1.2 км авто замын ажлыг "МАЗ" ХХК гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	Хорооллын доторх зам, тохижилт /24 дүгээр хороо, Баруун салаа/ хийх	Замын ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	70.0
140		Улсын төсвийн 3.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 7 м өргөнтэй 2 эгнээ 3.5 км авто замын ажил төлөвлөгдсөн. "Эх голомтын илч" ХХК гүйцэтгэгчээр шалгарч 2.8 км замын суурийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Газар чөлөөлөлт удаашралтай байгаа тул түр зогссон. Он дамжин хийгдэхээр болсон. "Мон-Ази" ХХК-нд авто замын трассын зургийг өөрчлөхөд шаардагдах 10.0 сая төгрөгийг дүүргийн төсвийн хөрөнгөөс гарган шийдвэрлэсэн.	Баян булгийн 2 дугаар гудамжнаас Мандал овооны 3 дугаар гудамж хүртэлх хатуу хучилттай 1.5 км /26 дугаар хороо/ авто замыг ашиглалтад оруулах	Замын ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	40.0
141		Зураг, төсөв хийлгэх зөвлөх үйлчилгээг зохион байгуулах үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын 2018 оны А/09 дүгээр захирамжаар байгуулж, дүүргийн Засаг даргын 2018 оны А/13 дугаар захирамжаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Ажлын даалгавар батлагдсан. Сонгон шалгаруулалтаар "Оч наран" ХХК шалгарч гэрээ байгуулсан. 77 айл замын трасст орсноос 35 айлыг нүүлгэн шилжүүлсэн. Газар чөлөөлөлтийн ажил үргэлжилж байна.	Халуун усны байрнаас Их наран, Буяны зам хүртэлх хатуу хучилттай авто зам 1.2 км /3, 26 дугаар хороо/ барьж ашиглалтад оруулах	Замын ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	40.0
142		Зураг, төсөв хийлгэх зөвлөх үйлчилгээг зохион байгуулах үнэлгээний хороог дүүргийн Засаг даргын 2018 оны А/09 дүгээр захирамжаар байгуулж, дүүргийн Засаг даргын 2018 А/13 дугаар захирамжаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Ажлын даалгавар батлагдсан. Сонгон шалгаруулалтын тендер зарлаж "Монгол зам групп" ХХК шалгарч зөвлөмжийг НХОГ азарт хүргүүлсэн. Он дамжин хийгдэхээр болсон.	Ханын материал орчмын орон сууцны хорооллын доторх хатуу хучилттай авто замын засварын ажлыг гүйцэтгэх /6 дугаар хороо/	Зам засварын ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	40.0
		10 дугаар сарын 17-ны өдөр гүйцэтгэгч сонгон шалгаруулах нээлттэй тендер зарласан. 11 дүгээр сарын 19-ны өдөр нээсэн. "Ринг роуд" ХХК шалгарч гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн.					

143		Толгойт-Орбит чиглэлийн авто замын уулзвараас Орбит-Баянголын уулзвар хүртэлх авто замын их засварын ажлыг гүйцэтгэх	Зам засварын ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	100.0
		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 1.1 км авто замд нөхөөс хийх буюу зорчих хэсгийн урсгал засварын ажлыг "Тотал Инж" ХХК 500.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.				
144		Шинээр зам барих боломжит трассын судалгааг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ Газрын алба	100.0
		Шинээр зам барих боломжит 19 байршлын трассын судалгааг гарган нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулахаар нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлсэн.				
145		Авто замын өргөтгөлийн ажил хийх /16 дугаар хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Нийслэлийн төсвийн хөрөнгө 25.0 сая төгрөгөөр 16 дугаар хороо 27 дугаар байрны 1-ээс 6 дугаар орц хүртэлх 100 метр урттай 3 метрийн өргөнтэй замын өргөтгөлийн ажлыг "Хянгар констракшн" ХХК хийж гүйцэтгэсэн.				
146		Гэр хорооллын шороон замыг засаж сайжруулах /6, 7, 9, 24, 25 дугаар хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар "Төгс үржих" ХХК 5 хорооны 27 гудамжны 14110 м2 талбайн шороон замыг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд зорчиход хүндрэлтэй болсон 21 гэр хорооны авто зам, зогсоолуудын 38843 м2 зам талбайд 442 машин шороо асгаж, автогрейдэрээр тэгшилж индүүдэн, 6 байршилд 51 метр үерийн ус зайлуулах хоолойг шинээр суурилуулах ажлыг орон нутгийн төсвийн 49.9 сая төгрөгөөр, 5, 7 дугаар хорооны 9 гудамжны шороо асгаж, тэгшлэх ажлыг дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 38.4 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.				
147	3.1.4. Зуслангийн бүсийн авто замын нөхцлийг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.	Сайжруулах шаардлагатай авто замын судалгаа тооцоог гаргах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Шаардлагатай тооцоо судалгааг гаргаж холбогдох газруудад хүргүүлснээр 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баруун салааны эцсийн буудлаас Бумбатын рашаан хүртэлх зуслангийн бүсийн авто замыг 1.9 тэрбум, Зүүн салааны эцсийн буудлаас Богинын ам, Ухнын амны уулзвар хүртэлх зуслангийн бүсийн авто замыг 1.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийхээр тусгагдсан.				
148	3.1.5. Хувиараа таксины үйлчилгээ эрхэлдэг иргэдийн үйл ажиллагааг дэмжин, Баянхошууны тойрог, Толгойтын эцсийн буудал, 1-	Боломжит байршлуудыг тогтоож зөвшөөрөгдсөн цэгт таксины зогсоол байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		8 дугаар хорооны нутаг дэвсгэр 117 дугаар цэцэрлэгийн дэргэд дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр таксины зогсоолыг байгуулж ашиглалтад оруулсан. 2 дугаар хорооны				

	р хорооллын арын дэнж зэрэг байршлуудад таксины зогсоол бий болгоно.	Толгойтын эцэсд дүүргийн ИТХ-ын төлөөлөгч Б.Гантуяагийн санаачилга, хөрөнгөөр 3.5 сая төгрөгийн өртөгөөр 12 машины багтаамжтай таксины зогсоол барьсан.				
149	3.1.6. Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл болон зогсоолын тоог нэмэгдүүлэх санал боловсруулан хэрэгжүүлж, хяналт тавина	Хүн амын суурьшлыг харгалзан нийтийн тээврийн үйлчилгээний зарим чиглэлд шинэ чиглэл нээх, автобусны тоог нэмэгдүүлэх саналыг холбогдох газарт хүргэн шийдвэрлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		24,32 дугаар хороодын иргэдээс гарсан саналын дагуу нэмэлт шинэ чиглэл нээх саналыг нийслэлийн Нийтийн тээврийн газарт уламжилснаар Саппоро-Эмээлт, Баруун салаа – Баянхошуу – Хөтөл-Халдвартын эмнэлэг гэсэн 2 шинэ чиглэлийг нээсэн.				
150		Автобусны буудлын тохижилт хийх /5, 25 дугаар хороо/	Автобусны буудал, тоо	2	ТНААХ	100.0
		Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Ганцаг” ХХК 2, 5, 25 дугаар хороодын нутаг дэвсгэрт 8 автобусны буудлыг 63.0 сая төгрөгөөр, 1,3 дугаар хороодын нутаг дэвсгэрт Японы “Жи Си Дако” ХХК өөрийн хөрөнгө 60.0 сая төгрөгөөр 5 байршилд автобусны буудал тохижуулах ажлыг хийсэн.				
151	3.1.7. Инженерийн байгууламжийн шугам сүлжээний чанар ашиглалтын түвшинг тогтоож, насжилтын хугацаа дууссан шугам сүлжээг шинэчлэн хяналт тавьж ажиллана.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэн солих ажлыг үргэлжлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Улаанбаатар хотын дулааны төв шугамд хийгдэх нягтын шахалт, засварын ажил болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлууд батлагдсан графикийн дагуу 2018 оны 5 дугаар сарын 15-наас 08 дугаар сарын 18-ны хооронд хийгдсэн. Тус ажлын хүрээнд Баруун түгээх, Хэрэглэгчдэд үйлчлэх 15, 16 төвүүд 40 багц ажлыг 240.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.				
152	3.1.8. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Сууц өмчлөгчдийн холбоотой хамтран орон сууцыг дулаалах ажлыг эхлүүлэх	Угсармал орон сууцны барилгын дулааны алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	ҮБ
		Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2018 оны 6 сард дулаалга хийх ажлын ТЭЗҮ /дээвэр, дотор инженерийн шугам, фасад, цонх солих г.м/ зураг, төслийн үнэлгээг “Гандирас орд” ХХК-иар хийлгэж батлуулсан. Нийслэлийн хэмжээнд угсармал орон сууцны дулаалгыг хийхэд 6-7 тэрбум төгрөг шаардлагатай урьдчилсан тооцоог гаргаж улсын төсөвт тусгуулахаар УБХЗАА-наас нийслэлээс сонгогдсон УИХ-ын гишүүдэд саналаа хүргүүлсэн байна. Хөрөнгийн асуудал шийдэгдвэл дүүрэг бүрт ээлж дараатайгаар нэгдсэн журмаар хийгдэж эхэлнэ.				
153	3.1.9. Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг дэс дараатай шинэчлэнэ	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулан дахин төлөвлөж барилгажуулах ажлыг үе шаттай	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТГХШХ, МХХ, ТНААХ	40.0

		хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдийн дунд сургалт зохион байгуулах				
		20 дугаар хороо "Хүнс трейд 48" байр нь нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2017 оны 02-01/03 дугаар дүгнэлтээр ашиглалтыг хориглох тухай шийдвэр гарсан. Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас сууц өмчлөгчдийн 80-аас дээш хувь нь дахин төлөвлөлтөд оруулахыг дэмжсэн тохиолдолд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих үйл ажиллагаанд хамрагдах боломжтой гэсний дагуу иргэдээс санал хураахад 80 хувьд хүрээгүй байна. Дүгнэлтийг холбогдох бичиг баримтын хамт УБХЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэст хүргүүлсэн. Хуучин цэргийн хотхоны 1-10 дугаар дан байруудад нийслэлийн Мэргэжлийн хяналтын ахлах байцаагчийн шийдвэр гаргуулж, дахин төлөвлөлтөд хамруулж тендер зарлагдсан боловч санал ирээгүй хаагдсан. Нефтийн 1, 2, 3-ын 27 дугаар байрууд ашиглалтын шаардлага хангахгүй дүгнэлт гарч дахин төлөвлөлтөд хамруулахаар ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна.				
154		19 дүгээр хорооны 3-48 айлын орон сууцны суурин дээр баригдаж байгаа барилгын В, С блокыг ашиглалтад оруулах	Ажлын гүйцэтгэл, хувь	100	ТНААХ	70.0
		Орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт хийгдэж "Си Эйч Си" ХХК шалгарч нийслэлийн төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар оны өмнө ашиглалтад хүлээлгэн өгөхөөр ажил хэвийн явагдаж байна. Гэрээт ажлын гүйцэтгэл 70.0 хувьтай байна.				
155	3.1.10. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлэн, шинэ арга хэлбэрүүдийг дэмжин ажиллана.	Гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлэн, шинэ арга хэлбэрүүдийг дэмжин холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдийн дунд сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТГХШХ	ҮБ
		Дүүргийн нутаг дэвсгэрт нийт 8 хорооны 189.5 га талбайд гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлж эхлүүлсэн. "Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл"-н хүрээнд төсөл хэрэгжүүлэгч ААН-үүд 2, 5, 6, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 137 айлын газар бүрэн чөлөөлж 8.5 га талбайд 940 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлэхээр иргэдтэй гэрээ байгуулсан. Дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд нийт 750 айлын орон сууц ашиглалтад орсон. 137 газраа бүрэн чөлөөлсөн иргэдээс 58 нь орон сууцанд орсон. Нийслэлийн Засаг даргын А/566, А/569, А/570 дугаар захирамжаар 20 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч "Хас харш" ХХК, 28 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч "Тоб групп" ХХК, 30 дугаар хороонд төсөл хэрэгжүүлэгч "Монгол дайван" ХХК тус тус төсөл хэрэгжүүлэгчийн эрх нь цуцлагдсан. 2018 онд дахин төлөвлөлтийн ажилд ахиц гараагүй байна.				

3.2. Амьдралын ая тухтай байдлыг бүрдүүлнэ.						
156	3.2.1. Гэрэл цахилгаангүй айл өрхүүдийг цахилгаанаар бүрэн хангах, хүчдэл сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг хэрэгжүүлэх Улсын төсвийн хөрөнгөөр гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах 102 багц ажлыг 9 компани гүйцэтгэж байна. 10000 гаруй өрхийн хүчдэл сайжруулах 50 дэд станцыг шинээр барьж, 28 дэд станцын өргөтгөлийн ажил хийгдсэн. 11, 21, 22, 23, 25, 26, 30, 31, 32 дугаар хороодын 18 гудамжны цахилгаангүй айл өрхийг цахилгаанд холбох 5 дэд станцыг барих ажил үргэлжилж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
157	3.2.2. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж нэгдсэн удирдлагын системд бүрэн холбохын зэрэгцээ хаягжуулалтыг сайжруулж, томоохон гудамж, нийтийн эзэмшлийн талбайд тохижилт хийх	Гэр хорооллын гудамжуудад гэрэлтүүлэг тавих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж алсын удирдлагын “Тулга” системд бүрэн холбох Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 21, 29, 32 дугаар хороодын нутаг дэвсгэрт 85.1 сая төгрөгийн хөрөнгөөр 44 ширхэг, дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4, 7, 17, 18, 26, 27, 29 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 89.0 сая төгрөгийн хөрөнгөөр 58 ширхэг гэрэлтүүлгийг тус тус хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Шинээр ашиглалтад оруулсан бүх гэрэлтүүлэг алсын удирдлагын Тулга системд бүрэн холбогдсон.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
158		Гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагуудын үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог сайжруулах Гэрэлтүүлгийн ашиглагч байгууллагуудын сонгон шалгаруулалтыг хийж “Их хотын гэрэл” ХХК 4 дүгээр сарын 1-нээс, “Цацрах хангай” ХХК 5 дугаар сарын 25-ны өдрөөс дүүргийн Засаг дарга, Улаанбаатар хотын Ерөнхий менежер, Ашиглагч байгууллага гэсэн гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Асалтын мэдээг 7 хоног бүр гудамж тус бүрээр нэгтгэн авч байгаа ба нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг 99.3 хувь, гэр хорооллын дундах гэрэлтүүлэг 99.0-99.3 хувь, орон сууцны дундах гэрэлтүүлэг 99.2-99.7 хувийн дундаж асалттай байна. Гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан байгууллагуудын засвар үйлчилгээний ажилд дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ өдөр тутамд хяналт тавьж баталгаажуулсны дараа санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
159		Засаг даргын Тамгын газрын өмнөх талбайг иж бүрнээр тохижуулах Нийслэлийн 2018 оны төсөвт тусгуулах тухай саналыг Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/2875 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хөрөнгийн асуудал шийдвэрлэх боломжгүй хариу өгсөн. Засаг даргын Тамгын газрын өмнөх талбайг иж бүрнээр тохижуулах 490.0 сая төгрөгийн зураг, төсөв хийгдсэн.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	ҮБ
160		Цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай байгуулах /7, 24, 25 дугаар хороод/	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	ТНААХ	40.0

	Улсын төсвийн 600.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7, 24, 25 дугаар хороодод Цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Төрөлх мөрөн” ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр шалгарч гэрээ байгуулагдсан. Он дамжин хийгдэхээр болсон.				
161	Гүнжийн нуурын орчныг сэргээн засварлах /8 дугаар хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	ТНААХ	100.0
	Гүнжийн нуур орчмын замыг хусаж, тэгшлэх ажлыг нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 17.8 сая төгрөгөөр “Эм Ар Ди Эс” ХХК хийж гүйцэтгэсэн.				
162	Явган хүний зам, гүүр, шат шинээр хийх засварлах /1, 9, 10, 22, 24, 25, 29, 30 дугаар хороо/	Байршил, тоо	8	ТНААХ	70.0
	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 10.0 сая төгрөгөөр 1 дүгээр хороонд явган хүний зам шинээр барих ажлыг “Эвсэг” иргэдийн бүлэг хийж гүйцэтгэсэн. 9, 10, 25, 30 дугаар хороодод явган хүний гүүр шинээр хийх, засварлах ажлын гүйцэтгэгчээр “Нарны үүсгэл” ХХК шалгарсан. Он дамжин хэрэгжихээр болсон. 22 дугаар хороонд явган хүний гүүр шинээр хийх ажлыг “Баян могод” ХХК хийж гүйцэтгэхээр шалгарсан ба 3 байршилд явган хүний гүүр хийж гүйцэтгэхээс 1 байршлын ажил бүрэн дууссан. 2 байршлын ажил он дамжин хийгдэнэ. 24 дүгээр хороонд явган хүний шат хийх ажлыг “Хангал хайрхан хүүхдүүд” ХХК 5.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.				
163	Тоглоомын талбай байгуулах, засварлах /7, 12, 24, 28 дугаар хороо/	Тоглоомын талбай, тоо	4	ТНААХ	100.0
	7 дугаар хороонд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны А/55 дугаар тогтоолоор “Гэр хорооллын гудамж, замын нөхцөлийг сайжруулах ажил” болгон өөрчилж, “Мөнх харш” ХХК 20.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. 12 дугаар хороонд хүүхдийн тоглоомын талбайн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг “Баянтэрэм гайхамшиг” ХХК 9.9 сая төгрөгөөр, 24 дүгээр хорооны хүүхдийн тоглоомын талбай засварлах ажлыг “Аргалант арвис групп” ХХК 5.0 сая төгрөгөөр, 28 дугаар хорооны Сансарын 4-11 дүгээр гудамжинд нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 29.0 сая төгрөгөөр “Сагсай өргөө” ХХК хүүхдийн тоглоомын талбай /сагсан бөмбөгийн талбай/ байгуулах ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн.				
164	Хөлбөмбөгийн талбай байгуулах, засварлах /13, 14, 15 дугаар хороо/	Хөлбөмбөгийн талбай, тоо	3	ТНААХ	100.0
	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 13 дугаар хорооны цогцолбор байрны урд талбайд 20.0 сая төгрөгөөр “Агар дүнз” ХХК хөл бөмбөгийн талбайг шинэчлэн засварласан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 14 дүгээр хороонд мини бейсболын талбай байгуулах ажлыг “Манлайлал” иргэдийн бүлэг 15.0 сая төгрөгөөр, 15 дугаар хороонд мини хөлбөмбөгийн талбай засварлах ажлыг “Гэрэлт ирээдүй” иргэдийн бүлэг 13.8 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.				
165	Нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийх /13 дугаар хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0

		Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13 дугаар хорооны 8, 9 дүгээр байрны нийтийн эзэмшлийн талбайд "Хянгар констракшн" ХХК 180 м2 явган хүний замын ажлыг 15.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.				
166	3.2.3. Гэр хорооллын айл өрхүүдийн ундны ус түгээх байруудыг нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулна.	Инженерийн хийцтэй гүний худаг 1, 22 дугаар хороонд, зөөврийн болон гүний худаг /2, 7, 22, 24, 25, 32 дугаар хороо/ барьж ашиглалтад авах	Ашиглалтад оруулах худаг, усан сан, тоо	16	ТНААХ	40.0
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/180 дугаар захирамжаар 1, 2, 3, 7, 22, 23, 24, 25, 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй гүний худаг, ус түгээх байрны зориулалтаар дүүргийн Засаг даргын Тамгын газрын нэр дээр газар эзэмших эрх олгогдон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Он дамжин хийгдэнэ.				
167	3.2.4. Дүүргийн хэмжээнд үерийн бүсийн хамгаалалтын барилга байгууламжийг барина.	Нарангийн голын үерийн хамгаалалтын 2 дугаар ээлжийн далангийн ажлыг гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгаар "Төрөлх мөрөн" ХХК, "Цомбон тоосго" ХХК-иудын түншлэл Нарангийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн II ээлжийн 11.8 км далангийн ажлыг гүйцэтгэж эхэлсэн. Газар шорооны ажил дууссан хэсгүүдэд хавтан угсралтын ажил хийгдсэн. Газар чөлөөлөлтийн ажил удаашралтай байгаа тул түр зогсож он дамжин хийгдэхээр болсон.				
168	3.2.5. Сууц өмчлөгчдийн холбоотой хамтран "Тохилог орц" хөтөлбөрийг хэрэгжүүлж, Сууц өмчлөгчдийн холбоодыг цахим мэдээллийн сантай болгоно.	Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэг шалгалт явуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монголын Сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлтэй хамтран байгуулсан. Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 82 СӨХ-доос Монгол улсын СӨХ-ны гишүүнчлэлтэй 44 СӨХ-дын үйл ажиллагаанд түвшин тогтоох үзлэг явуулсан ба шалгалтад хамрагдсан СӨХ-дын 72.0 хувь нь бүрэн хангалттай үнэлгээ авсан байна.				
169		Сууц өмчлөгчдийн холбоодын мэдээллийг цахим санд хамруулах ажлыг эхлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	40.0
		УБХЗАА-наас СӨХ-дын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх ажил хийгдэж байгаатай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 82 СӨХ-дын шаардлагатай судалгааны материалыг УБХЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээллийн сан үүсгэх ажлын явц 50.0 хувьтай байна.				
170		Сууц өмчлөгчдийн холбоодод "Тохилог орц" хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
		СӨХ-д өөрийн хөрөнгөөр дээврийн хэсэгчилсэн засвар 32.9 сая, заагийн засвар 5.5 сая, орцны их засвар 123.7 сая, сантехникийн засвар 55.5 сая, цахилгааны засвар 12.8 сая, тохижилт 21.4 сая, мод бут сөөг 2.4 сая, фасадны засвар 5.5 сая төгрөг, нийт 259.9 сая төгрөгийн засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.				

171	3.2.6. Орон сууцны барилгуудын дээврийн засвар болон цахилгаан шатуудын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.	Орон сууцны барилгуудын дээврийн засвар, цахилгаан шатуудын шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 12 дугаар хорооны 2 дугаар байрны дээврийн засварыг 61.2 сая төгрөгөөр “Грэйт майнинг” ХХК, 16 дугаар хорооны 25 дугаар байрны дээврийн засварыг 86.4 сая төгрөгөөр “СДММ” ХХК, 19 дүгээр хорооны 7а, 8б, 10-58 дугаар байруудын 1056 м2 дээврийн засварыг 121.4 сая төгрөгөөр "Дулаан хайрхан" ХХК, 13 дугаар хорооны 11 байрны 720 м2 дээврийн засварыг 35.7 сая төгрөгөөр “СТНАА” ХХК, 27 дугаар хорооны 35а,б байрнуудын 944 м2 дээврийн засварыг 26.9 сая төгрөгөөр “Хануй хангай” ХХК, 22 дугаар хорооны 36 дугаар байрны 750 м2 талбайн дээврийн засварыг 37.8 сая төгрөгөөр “Бэсүд констрашн” ХХК, 6 дугаар хорооны 58а байрны 800 м2 дээврийн засварыг 51.6 сая төгрөгөөр тус тус засварласан. Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 18 дугаар хорооны 6, 16 дугаар байрнуудын 1792 м2 дээврийн засварыг 71.5 сая төгрөгөөр “Баян Д” ХХК хийж гүйцэтгэснээр нийт 12 орон сууцны 8090 м2 талбайн дээврийн засварын ажлыг 492.6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
172	3.2.7. Гэр хорооллын утааг багасгах шинэлэг арга хэлбэрүүдийг авч хэрэгжүүлнэ.	Гэр хорооллын айл өрхүүдэд дулаан баригч технологийг нэвтрүүлэх Монгол гэрийн дулаалгын бүтээгдэхүүнийг турших, сурталчлах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2018 оны А/69 дүгээр захирамжаар байгуулсан. Тус ажлын хүрээнд 7, 24 дүгээр хороодын амьжиргааны түвшнээс доогуур орлоготой, нэн ядуу 2 өрхийг сонгон бүрэн дулаалга хийн, цахилгаан халаагуур суурилуулан туршилтын ажлыг эхлүүлсэн. “Утааны эсрэг аав ээжүүд” ТББ гэр хорооллын 23 хорооны иргэдэд гэр, байшингаа дулаалж дулааны алдагдлыг бууруулах сургалтыг зохион байгуулж 1200 гаруй иргэнийг хамруулсан.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
173		Төр болон хувийн хэвшлийн халаалтын зуухыг төвлөрсөн дулаанд холбох, тоосонцор бууруулах тоног төхөөрөмж суурилуулах ажлыг үргэлжлүүлэх Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 8 уурын зуухыг буулгаж, төрийн өмчит 6 байгууллага, хувийн хэвшлийн 2 нийт 8 ААНБ төвлөрсөн дулаанд холбогдсон. 31 дүгээр хорооны Дунд нарангийн 6, 7 дугаар гудамжны айл өрхүүдийг бие даасан эх үүсвэр бүхий халаалтын шугам сүлжээнд холбох зураг төслийн ажил хийгдэж эхэлсэн боловч цахилгаанаар халаахад сард гарах төлбөр 500.0-700.0 мянган төгрөг болж өндөр гарсан тул түр зогссон. Тус ажлын хүрээнд тоосонцор бууруулах тоног төхөөрөмж суулгах шаардлагатай аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зөвлөгөө өгөн, гарын авлага тараасан. Магадлан итгэмжлэлийн ажлаар сорилын цэг, тоосонцор бууруулах тоног төхөөрөмж суурилуулсан байдлыг шалгах ажил үргэлжилж байна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
174		Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах Улс, орон нутаг, олон улсын байгууллагын хөрөнгөөр 9 сургууль, 26 цэцэрлэгт 249, Өрхийн эмнэлгийн төвүүдэд 31 ширхэг, Эрүүл мэндийн төвд 5 ширхэг, Хүүхдийн нэгдсэн эмнэлэгт 59 ширхэг нийт 344 агаар	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0

		цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан. "Утааны эсрэг ээж аавууд" ТББ-аас 8 хорооны жирэмсэн 60 эмэгтэйд сургалт зохион байгуулж нэг өвлийн турш хэрэглэх маскыг олгосон. Дүүргийн нэгдсэн эмнэлэгт нийслэлийн төсвийн 60.0 сая төгрөгөөр дотоод агаарын чанарыг сайжруулах агаар цэвэршүүлэгч суурилуулах ажлыг "Эко Айр Фарм" ХХК хийж гүйцэтгэсэн.				
175		Гэр хорооллын айл өрхийн түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр түлшний хэрэглээг нэмэгдүүлэх замаар агаарын чанарыг сайжруулах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/530 захирамжаар агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг гэр хорооллын 23 хороонд 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн явуулж байна. Түүхий нүүрсний хэрэглээг бууруулж, сайжруулсан түлшээр хангах зорилгоор дүүргийн Засаг дарга, "МСРТ" ХХК-ий ерөнхий захиралтай "Хамтын ажиллагааны гэрээ" байгуулан сайжруулсан шахмал түлш, самрын ястай хольсон брикетийг худалдаалах цэгүүдийг 1, 2, 3, 4, 6, 7, 8, 20 дугаар хороодын 12 байршилд байгуулсан. "МСРТ" ХХК нь 100 кВт-аас дээш хүчин чадалтай томоохон уурын зуухуудад тохирсон түлшийг үйлдвэрлэхээр туршилтын ажлыг явуулж байна. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг түүхий нүүрс хэрэглүүлэхгүй байх зорилгоор "Тохижилт, цэвэрлэгээний гэрээ"-нд стандартын зуух, сайжруулсан түлш, цахилгаанаар халдаг байх шаардлагатай гэсэн заалтыг тусгасан.				
176		Түргэн үйлчилгээний цэг, дугуй засвар, харуулын байр, автомашины засвар угаалгын үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн дулааны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ХХҮХ МХХ	100.0
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/277 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт авто засвар, авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн дулааны эх үүсвэрт хяналт, шалгалт хийж 182 зөрчил илрүүлж /илэрч байгаа зөрчлийн 90 хувь нь бүрэн шаталттай зуух хэрэглээгүй, нүүрс түлэхгүй бүсэд түүхий нүүрс түлж байсан зэрэг зөрчлүүд илэрсэн/ 58 зөрчлийг арилгуулж, 1 иргэнд 0.7 сая төгрөг, 1 аж ахуйн нэгжид 1.4 сая төгрөг, 1 албан тушаалтанд 0.5 сая төгрөг нийт 2.6 сая төгрөгийн торгууль ногдуулж, 2 иргэн, 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох тухай улсын байцаагчийн акт үйлдэж, 15 аж ахуйн нэгж, 6 иргэнд зөрчлийг арилгах тухай улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.				
177	3.2.8. Гэр хорооллын хөрс, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор жорлон, муу усны цооногийг соруулж, ариутгах шинэ менежментийг хэрэгжүүлнэ.	Толгойтод шинээр ариутгах татуургын коллектор барьж ашиглалтад оруулах	Шугамын урт, км	4.6	ТНААХ	100.0
		Нийслэлийн хөрөнгө оруулалтаар "Бумб-Од" ХХК ариутгах татуургын 1235м Ф400/900мм шугам угсралтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад оруулсан.				
178		Нийтийн бие засах газар барьж ашиглалтад оруулах /5 дугаар хороо/	Ашиглалтад орох байгууламж, тоо	1	ТНААХ	100.0
		Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн 70.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "ЦТУ" ХХК гүйцэтгэсэн.				

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ

179	4.1. Орон сууц, гэр хорооллын сул шороон хөрс бүхий талбайд ногоон байгууламж, хатуу хучилттай болгож хуурайшилтаас үүсэх тоосжилтыг бууруулна.	Ургамлын бүрхэвчгүй эвдрэлтэй налуу газар, даланг эко хавтангаар бүрж, сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлэн, хатуу хучилт хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Дүүргийн төсвийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр 1060м2 талбайн сул шороон хөрс бүхий нийтийн эзэмшлийн талбайд шинээр зүлэгжүүлэлт хийсэн. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр 13 дугаар хорооны 8, 9 дүгээр байрны нийтийн эзэмшлийн талбайн 180 м2 сул шороон хөрсийг “Алтайн цаст” ХХК хатуу хучилттай болгон тохижуулсан. 14, 15, 16 дугаар хороодын нутаг дэвсгэрийн 1500м2 талбайн хөрсийг хуулж хар шороогоор хучиж, зүлэгжүүлэлт хийсэн.				
180	4.2. Олон нийтийн оролцоонд тулгуурласан “Манай гудамж” төсөл хэрэгжүүлнэ.	“Манай гудамж” төслийн уралдаан зарлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
		Хороодын иргэдийн оролцоо, хөрөнгөөр 1 дүгээр хорооны Толгойтын 102, 103 дугаар гудамж, 2 дугаар хорооны Орбитын 51-65 дугаар гудамж, 4 дүгээр хорооны Их нарангийн 10, 11 дүгээр гудамж, 6 дугаар хорооны Тоосгоны 4, 14, 17, 24, 24а дугаар гудамж, 9 дүгээр хорооны Баруунбаян уулын 1, 2, 3, 6, 7 дугаар гудамж, 10 дугаар хорооны Зүүнбаян уулын 9, 11, 13, 16а, 16б, 17, 18, 22, 23, 24, 30, 32 дугаар гудамж, 26 дугаар хорооны Мандал-Овооны 7 дугаар гудамжуудыг жишиг гудамж болгон тохижуулах ажил хийгдсэн. Дүүргийн төсвийн 7.6 сая төгрөгөөр 2, 3, 5, 6, 10, 13, 15, 31 дүгээр хороодын нутаг дэвсгэрийн тохижилтод дэмжлэг үзүүлсэн.				
181		Хашаа гудамжаа үлгэр жишээ тохижуулсан иргэдийг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		“Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд нийслэлийн хэмжээнд шилдэг өрх шалгаруулах уралдаанд дүүргийн 10 дугаар хорооны иргэн Ц.Цогт-очир дэд байр эзэлж, мөнгөн шагнал өргөмжлөл, гадаадад аялах эрхийн бичгээр шагнуулсан. Мөн аянд идэвхтэй оролцож, хашаа гудамжаа үлгэр жишээ тохижуулсан 15 өрхөд 5 нэр төрлийн 150 ширхэг жимсний болон гоёлын бут, сөөгөөр урамшуулсан. TV-5, SBN, Эх орон, NTV зэрэг телевизүүдээр 5, 6, 10, 24, 25, 32 дугаар хороодын жишиг тохижилттой 8 айл өрхийг сурталчилсан. SHD.mn цахим сайтаар 15 удаагийн сурталчилгаа хийсэн.				
182	4.3. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газруудын орчны бүсийн хилийн заагийг тогтоож ашиглалтын хяналтыг өндөржүүлнэ.	Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын ашиглалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ МХХ	100.0
		Орон нутгийн тусгай хамгаалалтын бүс буюу Баянхошуу хайрханы өвөрт зөвшөөрөлгүй буусан 48 айлыг нүүлгэн бүх нийтийн мод тарих өдрөөр 250 ширхэг улиас мод тарьсан. "Найрамдал" шаврын ордод ашигт малтмал ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 5 аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлсэн. "Усан цэнэгт цахилгаан станц" төслийн нэгж зөвшөөрөлгүй олборлолт явуулж байсанд хяналт шалгалт явуулж, үйл ажиллагааг бүрэн зогсоосон.				

183	4.4. “Ургамлын харшилгүй хороо, гудамж” хөдөлгөөн өрнүүлэн хөл газрын ургамлыг устган ургамлын тоосонцорын дэгдэлтийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн үр дүнд хүргэнэ.	Ургамлын гаралтай харшлын өвчнийг үүсгэгч хөл газрын ургамлыг устгах, тоосонцорын дэгдэлтийг бууруулах бүх нийтийн аяныг зарлан үр дүнг тооцох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Дүүргийн Засаг даргын 2018 оны А/333 дугаар захирамжийн дагуу ургамлын харшлаас урьдчилан сэргийлэх зорилготой "Шарилжгүй Улаанбаатар-3" аяныг 6 дугаар сараас 8 дугаар сар хүртэл зохион байгуулж иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд эзэмшил болон ашиглалтад байгаа орчны 50 м хүртэлх, гэр хороололд амьдардаг айл өрх хашаа, нийтийн эзэмшлийн гудамжинд ургасан лууль, шарилж, бусад хөл газрын ургамлыг устгаж, аяны хугацаанд 2.5 сая м2 талбайд шарилж цэвэрлэгээний ажил хийж 197951 тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэн зайлуулсан.						
184	4.5. Азийн хөгжлийн сан болон бусад төсөл арга хэмжээний тусламжтайгаар хог хаягдлын менежментийг сайжруулах ажлыг зохион байгуулна.	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд оюутан сурагчдыг хамруулан хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр явуулах сургалт сурталчилгааны ажлыг өргөжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 2100 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудын 4120 иргэдэд нийслэлийн ИТХТ-ийн 63, 61 дүгээр тогтоол, Монгол улсын Зөрчлийн тухай хуулиудаар, Ерөнхий боловсролын дунд сургуулийн 620 сурагчдад хог хаягдлыг ангилан ялгах болон Хог хаягдлын шинэчилсэн хууль, Тохижилт хог хаягдлын олон нийтийн байцаагч нарт Монгол улсын Эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын Зөрчлийн тухай хууль, Монгол улсын Байгаль орчны тухай хуулиудаар сургалт зохион байгуулан 840 гаруй гарын авлагаар хангасан.						
185	Хог хаягдлын менежментийг сайжруулах нийслэлийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Хог хаягдлын менежментийг сайжруулах нийслэлийн дэд хөтөлбөрийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт 2018-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гарган батлуулан 7 зорилтын хүрээнд 23 ажлыг хийж хэрэгжүүлэхээр тусгасан. Тус ажлын хүрээнд 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 24 айл өрхийн хог хаягдлыг ангилан ялгах туршилтын ажлыг Азийн хөгжлийн сан, УБХЗАА-тай хамтран хэрэгжүүлсэн. Зуны улиралд өдөрт дунджаар 1 иргэнээс 0.4 кг хог хаягдал гарахаар тооцоо хийгдсэн. Цаашид 2019 оны 1-р улирлаас ААНБ-уудын хог хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагаанд шилжихээр бэлтгэл ажил хангагдсан.						
186	Хог хаягдал үүсдэг болон үүсч болзошгүй газруудыг хяналтад авч камержуулах, иргэдийн бүлэг ажиллуулах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Хог хаягдал үүссэн цэгүүдэд 69 хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлэг ажиллуулан нийслэлийн төсвөөс 171.1 сая төгрөг зарцуулсан. 2018 оны жилийн эцсийн байдлаар хог хаягдлыг тээвэрлэгч байгууллагуудтай хамтран үүсмэл болон хур хог хаягдлын цэгийг устгах ажлыг зохион байгуулж 139 үүсмэл, 1 хур нийт 140 хогийн цэгийг цэвэрлэж бүрэн устгасан. Гэр хороодын хогийн цэг үүсдэг 10 байршилд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 7.5 сая төгрөгөөр камержуулалт хийсэн.						

187		Хот тохижилтын тусгай зориулалтын техник тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж хүчин чадлыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	40.0
Хот тохижилтын тусгай тоног төхөөрөмж, хог тээврийн 47 авто машинуудын ашиглалтын урсгал засварт сар бүр тогтмол засвар үйлчилгээ, тос тосолгоог хийж 127.4 сая төгрөг зарцуулсан. 2019 онд Хог тээврийн байгууллагуудын парк шинэчлэл хийхэд шаардлагатай 1.6 тэрбум төгрөгийг нийслэлийн 2019 оны төсөвт суулгуулах саналаа нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдөд 2018 оны 01/2896 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.						
188	4.6. “Эко ногоон гудамж” төсөл хэрэгжүүлнэ.	Орон сууц, гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд бичил цэцэрлэг байгуулан ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Иргэдийн гаргасан санаачилга, өрнүүлсэн хөдөлгөөн, хандиваар 13 дугаар хороонд 62.9 сая төгрөгийн өртгөөр 800 м2 талбай бүхий бичил цэцэрлэг, 14 дүгээр хороонд нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 60.0 сая төгрөгөөр 2256 м2 талбай бүхий цэцэрлэгт хүрээлэнг ашиглалтад хүлээлгэн өгсөн.						
189		Номын сантай цэцэрлэгт хүрээлэн байгуулах /14, 15 дугаар хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/816 дугаар “Газар эзэмшүүлэх эрх олгох тухай” захирамжаар 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт тохижилт ногоон байгууламж бүхий номын сангийн зориулалттай 0.45 га газрын зөвшөөрөл олгогдсон. Тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах ажлыг “Гоби травел” ХХК хийж гүйцэтгэсэн. Номын сан барих ажлыг “Изо хаус” ХХК ондоо багтаан хийж гүйцэтгэнэ.						
190		Мод тарьж ногоон байгууламж бий болгосон ААНБ, иргэдийг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
Өөрсдийн хөрөнгөөр мод үржүүлгийн газар бий болгосон 6 ААНБ-аас 25.0 сая төгрөгийн мод, суулгац худалдан авч нийтийн эзэмшлийн зам талбайд тарих ажил хийсэн. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас мод тарьж ногоон байгууламж бий болгосон 15 өрхөд гоёлын болон жимс жимсгэний мод, бут сөөгийг урамшуулал болгон олгосон.						
191		Дүүрэгт мод үржүүлгийн газруудын тоог нэмэгдүүлж, инкубатор төв байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
26 дугаар хорооны Улаанчулуутын хогийн цэгийн зам дагуу ойн зурвас бий болгох зорилгоор 800 ширхэг чацаргана, 400 ширхэг улиас мод тарьж, усалгаа, арчилгаа хамгаалалтыг “ТЦҮ” ОНӨААТҮГ хариуцан ажиллаж байна. 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Бүгд Найрамдах Солонгос улсын ТББ “Инчеоны төгөл ой” цэцэрлэгт хүрээлэн байгуулан 2000 ширхэг улиас мод тарьсан. Дүүргийн ногоон байгууламжийн үрсэлгээ, тарьц, суулгацыг хангах зорилгоор инкубатор төв байгуулахаар аж ахуйн нэгж байгууллагуудтай судалгааны ажил хийж байна.						

192	4.7. Дүүргийн ногоон бүсээс мод бэлтгэн түлшинд хэрэглэх хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож, ойн цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж, гэр хороололд “Хямд түлээ” төсөл хэрэгжүүлнэ.	Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсооход иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
193		Холбогдох мэргэжлийн байгууллага, хороодтой хамтран ой цэвэрлэх ажлын хүрээнд “хямд түлээ” төсөл хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	40.0
194	4.8. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль бус олборлолтыг таслан зогсоож техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Дүүргийн нутаг дэвсгэр дэх түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-ын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд саналаа тусгуулж, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
195		Эрсдлээр дунд, их үнэлэгдсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжүүдийг 2.23 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-ны дагуу үнэлж үүссэн сөрөг нөлөөллийг бууруулахаар эрх зүйн бичиг баримт гарган ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	МХХ	40.0

		Найрамдал шаврын ордод үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа 4 аж ахуй нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт явуулж эрсдлийг үнэлэн нийт 2.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч зөрчлийг арилгуулсан.				
196	4.9. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтанд тавих хяналтыг сайжруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт тавьж, эвдэрсэн газрын судалгааг гаргаж, нөхөн сэргээлтийг хийлгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	100.0
		Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас дүүргийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж 5 ААНБ-д 2.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 4.4 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн ажил хийлгүүлсэн.				
197		Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТНААХ	70.0
		33 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 3.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Нийт 16 аж ахуйн нэгж байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө ирүүлснээс 9 нь батлагдаж 7 аж ахуйн нэгжийн төлөвлөгөөг хянах шатандаа байна.				

ТАВ. ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ

Дүүргийн төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулан чанар хүртээмжийг нэмэгдүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана.

198	5.1. Дүүргийн Засаг даргын Тамгын газарт ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ.	Засаг даргын Тамгын газарт ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж, удирдлагын чанарын стандартыг хэрэгжүүлсэн байгууллагын “Батламж сертификат”-ыг авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	70.0
		Дүүргийн Засаг даргын 2017 оны “Стандарт нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/72 дугаар захирамжийн хүрээнд “ISO MONGOLIA” ХХК-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, гэрээ байгуулан, чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016 стандартыг дүүргийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжүүллээ. Төслийн удирдах баг ажилтан, албан хаагчдад MNS ISO:9001:2016 стандартын сургалтуудыг дүүргийн Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харъяа байгууллагуудын удирдлагууд, стандартыг хэрэгжилтийг зохицуулах багт тус тус зохион байгуулж, “Батламж сертификат” авахаар бэлтгэл ажлыг хангасан.				

199	5.2. Дүүргийн захиргааны байгууллагуудад ажиллах төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулах тогтолцоо шударга, нээлттэй байж, мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баримтлан, шаардлага хангасан иргэдээр төрийн албыг бүрдүүлж, чадварлаг төрийн албыг төлөвшүүлнэ.	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх сургалтад хамруулах Төрийн албан хаагчийн 2018 оны сургалтын төлөвлөгөөг 3 бүлэг 22 заалттайгаар боловсруулж батлуулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 8 удаа сургалт зохион байгуулсан. Мэргэжлийн болон мэргэшүүлэх урт хугацааны сургалтад 11 албан хаагч, Төрийн албаны зөвлөл, салбарын яамд, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, бусад байгууллагуудын зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 376 албан хаагчийг хамрууллаа. Засаг даргын Тамгын газрын албан хаагч нарт Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн “Төрийн албан хаагчийн ёс зүй, зөрчил”, “Захиргааны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, хяналтын тогтолцооны зарим асуудал” сэдвээр 4 удаа сургалт зохион байгуулсан. Хороодын албан хаагч нарт “Төрийн албан хаагчийн манлайлал”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, зөрчил”, “2017 оны Засгийн газрын 89 дүгээр тогтоолын бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгүүд дүгнэх аргачлал, төлөвлөлт, тайлагналтад анхаарах асуудлууд болон хяналт-шинжилгээ, үнэлгээ”, “Захиргааны ерөнхий хууль”, сэдвээр 4 удаа сургалт зохион байгуулсан. Удирдлагын академийн нэг сарын хугацаатай зайны сургалтад 4 албан хаагч хамрагдаж төгссөн.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
200		Засаг даргын Тамгын газраас 2017-2020 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцэж батлуулсан. Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам, Тамгын газрын төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн дагуу 5-аас дээш жил тогтвор сууршилтай ажиллаж байгаа хорооны 5 албан хаагчдад тус бүрт 5.0 сая төгрөг буюу нийтдээ 25.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгож нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд шинээр гэр бүл болох, шинэ хүүхэдтэй болох ар гэрийн гачигдал зэргээр нийт 46 албан хаагчдад 34.8 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж тус тус олгосон. 2018 оны 11 дүгээр сарын байдлаар 325 албан хаагчдад 325.4 сая төгрөгийн хоол, унааны зардлыг олгосон.	Хамрагдах албан хаагчид, тоо	25	ТЗУХ	100.0
201		Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2018 ажлын төлөвлөгөөг 5 бүлэг 13 заалттайгаар боловсруулж батлуулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн www.shd.mn цахим хуудсанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг байршуулж, хэрэгжилтийг хангаж	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100.0	ТЗУХ	100.0

		ажиллалаа. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллагуудын 39 албан хаагчдын 2017 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлгийг авч, хуулийн хугацаанд нь 100.0 хувь цахимаар баталгаажуулсан. Авлигатай тэмцэх газраас баталсан удирдамжийн хүрээнд хяналт, шалгалт хийх 12 байгууллага, албан тушаалтнуудын болон бусад холбогдох 6 төрлийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан 16 удаагийн сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 77 албан хаагчийг хамруулсан. 2018 онд шинээр ажилд орсон 10 удирдах ажилтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар авч баталгаажууллаа. Их хэмжээний өөрчлөлт орсон 2 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг бүрдүүлж баталгаажуулсан. “Азийн хөгжлийн сан”-тай хамтран Тамгын газар, хороодын 140 албан хаагчдад “Авилгын эсрэг” сургалт зохион байгууллаа. Засаг даргын Тамгын газрын болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын дарга, эрхлэгч нарт Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулсан.				
202		Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах чиглэлээр дүүргийн ИТХ-тай хамтран “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийг байгуулан ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Тамгын газар, хороодын 140 албан хаагчдад “Авилгын эсрэг” сэдэвт сургалт зохион байгууллаа. Дүүргийн ИТХ-тай хамтран “Иргэдийн хяналтын зөвлөл”-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Авлигатай тэмцэх газар, дүүргийн ИТХ гэрээ байгуулан ажиллаж байна. Иргэдийн хяналтын зөвлөлийн 2 гишүүний ажилласан хугацааны урамшууллыг ИТХ-аас олгож байна.				
203	5.3. Бүх шатны нутгийн захиргааны байгууллагууд тогтмол хугацаанд иргэдэд ажлаа тайлагнадаг, сонсдог “Дүүргийн нээлттэй засаглал” өдөрлөгийг хийж хэвшүүлнэ.	Нутгийн захиргааны байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг улирал бүр зохион байгуулж хэвшүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		“Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг улирал бүр зохион байгуулах ажлын хүрээнд Газрын албатай хамтран газар өмчлөлийг эрчимжүүлэх 2 сарын аяныг 1-2 дугаар сард зохион байгуулан ажиллалаа. 2018 оны байдлаар нийслэлийн Засаг даргын 3 удаагийн захирамжаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх чиглэлээр 1081 иргэнд 54.05 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн ба хуулинд зааснаас илүү талбай эзэмшиж буй 19 иргэнд 258 м2 газрыг үнээр нь өмчлүүллээ. Амралтын өдрүүдэд ажиллаж 757 иргэдийн асуудлыг шийдвэрлэсэн. “Газрын харилцаа” нээлттэй хэлэлцүүлгийг Соёмбо кино театрт 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 23, 29, 30, 31 дүгээр хороодын 120 гаруй иргэдийн дунд амжилттай зохион байгууллаа. 7, 8, 9, 10, 11, 24, 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт 3 дугаар хэлэлцүүлгийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хороо хуваах асуудлаар явууллаа. Үүнд нийт 400 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд оролцож оновчтой саналуудыг хүлээн авч ажилласан. Газрын албанаас 2018 онд нийт 120 гаруй мэдээлэл нийтэлж, дээрх уулзалт хэлэлцүүлгүүдээр 22169 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Дүүргийн гадна талбайд Нийгмийн халамж хөдөлмөрийн хэлтэс,				

		<p>Бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын албадууд хамтран “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж хэлтсүүд өөрсдийн чиг үүргийн дагуу үйлчилгээгээ сурталчилан таниуллаа. “Өглөөний гудамж” арга хэмжээнд дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, тасгууд бүрэн хамрагдаж 2 удаагийн арга хэмжээгээр 640 орчим иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Мөн “Газрын тухай” хуулийн өөрчлөлтийг сурталчлах газраа бусдад худалдах, эрх шилжүүлэх үйлдэл дээр татвартай болсонтой холбогдуулан нэг цонхны үйлчилгээнд татварын орлогын байцаагч ажиллаж эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд нийт 2515 иргэн аж ахуйн нэгжид хуулийн зөвлөгөө мэдээллийг өгч 718.8 сая төгрөгийн татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг иргэдэд хүргэх, тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн авах, уламжлан шийдвэрлүүлэх, байгууллагуудын анхан шатны нэгж, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдыг ажлын байранд сургаж, архив албан хэрэг хөтлөлтийн арга зүйгээр хангах, төрөөс үзүүлэх бүртгэл, халамж, нийгмийн даатгал, архив, газрын албаны үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор нийслэлийн Архивын газартай хамтран 14 дүгээр хорооны Иргэний танхимд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулав. Уг өдөрлөг, сургалтад 8 сургууль, цэцэрлэгийн архив албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагч, 32 хорооны зохион байгуулагч оролцож, 725 иргэн архив, халамж, нийгмийн даатгалын чиглэлээр хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэв.</p>				
204	5.4 Бүртгэлийн мэдээллийн санг төгөлдөршүүлнэ.	Хороодод иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Нэмэгдүүлэх үйлчилгээ, тоо	2	БХэлтэс	100.0
		<p>Хороодод иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээнүүдээс зөвлөгөө мэдээллийг бүрэн өгч ажиллаж байна. ТҮЦ машинаас 22 нэр төрлийн лавлагааг цахим сүлжээгээр иргэнд шууд хүргэж ажилладаг болсон. Дүүргийн нэг цонхны үйлчилгээний төвөөс 54655 иргэнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр төрийн үйлчилгээг хүргэсэн. Алслагдсан хороодод төрийн үйлчилгээг ойртуулан нэмэгдүүлэх зорилгоор 19, 21, 32, 24 дүгээр хороодод нийт 550 иргэнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлээр зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Хууль шинэчлэгдсэн холбогдуулан нэг цонхны үйлчилгээний төвд байсан мэдээллийн самбаруудыг хуульд нийцүүлэн шинэчилсэн. 11 дүгээр хороо онлайн сүлжээнд холбогдож иргэний үнэмлэхийн бүртгэл, төрөлт, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болсны бүртгэлүүдийг тус тус бүртгэж байна. 11 дүгээр хорооны улсын бүртгэгч гэр бүлийн байдлын 250 бүртгэл бүртгэсэн байна.</p>				
205		“Нэг хаяг-нэг иргэн” аян зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	БХэлтэс	100.0
		<p>Иргэний улсын бүртгэлийн тухай хууль шинэчлэн батлагдаж 2018 оны 11 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийн дагуу иргэний 10 төрлийн бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэж эхлээд байна. Үүнд: төрсний, гэрлэсний, гэрлэлт дуусгавар болсны, гэрлэлт сэргээсний, иргэний байнгын оршин суугаа хаягийн, эцэг /эх/ тогтоосны, нас барсны, иргэний үнэмлэхийн, биеийн давхцахгүй өгөгдлийн, үндэсний энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтын нийт 10 төрлийн бүртгэл хийж байна. Дээрх бүртгэлүүдээс хөдөө орон нутгийн харьяалалтай 36 иргэн, иргэний үнэмлэхээ гаргуулж үйлчлүүлсэн.</p>				

206	5.5. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцон хяналт тавих	Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцон хяналт тавих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
	тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцох, хяналт тавих тогтолцоог бий болгож, иргэдийн өргөдөл, гомдлыг хуульд заасан бүхий л хэлбэрээр шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлж, ил тод нээлттэй шийдвэрлэнэ.	Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх зорилгоор иргэд хүлээн авах цагийн хуваарийг батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллалаа. Дүүргийн Засаг дарга, удирдлагууд нийт 85 иргэний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох мэргэжилтнүүдийг байлцуулан тухай бүрт нь судалж үзэн шийдвэрлэж, шаардлагатай бичгээр хандсан өргөдөл, хүсэлтийг өргөдөл гомдлын нэгдсэн программд бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэдэд холбогдох хариуг өгч ажилласан. Нийт уулзсан 85 иргэний 42.3% нь буюу 36 иргэн газар эзэмших, ашиглах хүсэлт, газрын маргаан шийдвэрлүүлэхээр, 15.2% буюу 13 иргэн орон гэр хүссэн, 27.0% буюу 23 иргэн эмчилгээний зардал, сургалтын төлбөр, буцалтгүй тусламж хүссэн, 15.2% нь буюу 13 иргэн ажилд орох хүсэлт гаргасан байна. Дүүргийн Засаг дарга иргэд, сонгогчидтой уулзалт зохион байгуулж, давхардсан тоогоор 186 иргэний санал хүсэлтийг хүлээн авч судалж байна. Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийн дагуу зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг нь хангуулан ажиллаж байна. Нийт 30 хорооны 3250 иргэнтэй уулзаж санал хүсэлтийг сонсож ажиллалаа.				
207		Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай хүлээн авч, үйл ажиллагааг эрчимжүүлэн ил тод, нээлттэй шийдвэрлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг баримтлан иргэд, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллалаа. Дүүргийн www.smartcity.mn өргөдөл, гомдлын нэгдсэн программд 966 өргөдөл гомдол, санал, хүсэлт бүртгэгдэж, холбогдох хэлтэс, албадад шилжүүлэн, шийдвэрлэсэн- 950 шийдвэрлэх шатандаа-16 өргөдөл, гомдол байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг дүүргийн www.shd.mn цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулж, иргэд олон нийтэд ил тод, нээлттэй ажиллаж байна. Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлттэй холбоотой мэдээллийг сар бүр гаргаж, удирдлагуудад танилцуулан ажиллалаа. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэлт 6 хоног 11 цаг 24 минут, Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн индексийн үзүүлэлтийн дундаж үнэлгээ 0.83 буюу “В” үнэлгээтэй байна. Дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн едос нэгдсэн сүлжээгээр нийт 33775 албан бичиг ирсэнээс Засаг даргын Тамгын газарт 5023 албан бичиг ирж, 4863 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 8 бичиг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн байна. 135 албан бичиг судалж, шийдвэрлэх шатандаа байна.				
208		Тус дүүргээс Улсын Их Хуралд болон нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сонгогдсон гишүүд, төлөөлөгчидтэй	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	70.0

		хамтран ажиллах ажлын хэсгийг байгуулж, уялдаа холбоог сайжруулах				
		Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар өөрийн сонгогдсон тойргийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтад 1864 иргэн оролцож, 178 санал хүсэлт гаргасныг холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлүүлэв. Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал өөрийн сонгогдсон тойргийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, нийт 1725 иргэн оролцож, 127 санал хүсэлт ирүүлснийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж ажиллалаа. Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар өөрийн сонгогдсон тойргийн иргэдтэй уулзалт хийж хэрэгжүүлж буй ажлаа танилцуулан, Засгийн газраас явуулж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч иргэдийн санал хүсэлтийг сонсож, хариу өгч ажилласан. Уулзалтад 1463 иргэн оролцож, 97 санал хүсэлт гаргасан байна. Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагва болон нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид иргэд, сонгогчидтой уулзах уулзалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж 1879 иргэн оролцож, 257 санал хүсэлт ирүүлснийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.				
209	5.6. Иргэдэд хүргэх төрийн анхан шатны үйлчилгээг шуурхай хүргэх боломж, нөхцөл хангасан хорооны цогцолбор байртай болгох, алслагдсан хороодын хэсгүүдийн байр барих ажлыг үргэлжлүүлнэ.	6,16 дугаар хороодод "Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн цогцолбор байр" барих бэлтгэл ажлыг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	70.0
		Дүүргийн 16 дугаар хорооны хороо, Өрхийн Эрүүл Мэндийн төв, Цагдаагийн цогцолбор байр барих саналыг 2019 оны хөрөнгө оруулалтын саналд тусгасан. Цогцолбор байрыг 113 дугаар цэцэрлэгийн зүүн талд барихаар төлөвлөж, 471 м.кв газрын гэрчилгээ гаргуулсан.				
210	Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн ам, өрхийн тоог харгалзан, хэсгийн ахлагчийн орон тоог нэмэх асуудлыг боловсруулан шийдвэрлэх, нийгмийн асуудлыг анхааран ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 30/24 дүгээр тогтоолын дагуу сул орон тооны ажлын байрны сонгон шалгаруулалтыг 6 удаа зохион байгуулж, нийт 55 иргэн оролцсоноос шалгалтад тэнцсэн 33 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллалаа. Уг тогтоолын дагуу гэр хороололд 200-250, байшин хороололд 250-300 өрх тутамд 1 хэсгийн ахлагч ажиллана гэж заасныг үндэслэн тус дүүргийн хороодод нийт 62 хэсгийн ахлагчийн сул орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж 115 иргэн хүсэлт ирүүллээ. Сонгон шалгаруулалтыг Засаг даргын Тамгын газрын даргын баталсан хуваарийн дагуу 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 62 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээг байгуулав.				
211		31 дүгээр хорооны цогцолбор байрны засвар хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Дүүргийн Засаг даргын тамгын газрын төсвийн хөрөнгөөр 31 дүгээр хорооны цогцолбор байрны суурийн засварын ажлыг "Топ тоур" ХХК 55.7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.				

212	Хорооны цогцолбор байрыг төвийн дулааны шугамд холбох /12 дугаар хороо/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	40.0
	12 дугаар хорооны цогцолбор байрны дулааны шугамыг төвийн шугамд холбох ажлын хүрээнд техникийн нөхцөлийг УБДС ТӨХК-иар гүйцэтгүүлж, техникийн нөхцлийн дагуу дулаанд холбох төсөвт өртөг 60.0 сая төгрөг байхаар гарсан. Төсөвт өртөг өндөр байгаа тул дакон зуухаар халааж байна.				
213	Иргэний танхимын засвар, тохижилт, тоног төхөөрөмж нийлүүлэх /11, 12, 21, 24 дүгээр хороо/	Хороо, тоо	4	ТЗУХ	100.0
	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 23, 24 дүгээр хороодын иргэний танхимын завсарын ажлыг “Зэндмэнэ тулга” ХХК 12.8 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэлээ. Дүүргийн хөрөнгө оруулалтаар 24 дүгээр хорооны Иргэний танхимын тохижилтын ажлыг “Хан мюзик” ХХК 5.0 сая төгрөг, 25 дугаар хорооны иргэний танхимын тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 4.9 сая төгрөг, 11 дүгээр хорооны Иргэний танхимын засвар, тохижилтын ажлыг “Хоёр хангай” ХХК 30.0 сая төгрөг, 12 дугаар хорооны иргэний танхимын засвар үйлчилгээг “Инж итгэл” ХХК 4.9 сая төгрөг, 21 дүгээр хорооны Иргэний танхимын тоног төхөөрөмж худалдан авах ажлыг “Би Си Ти” ХХК 10.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.				
214	Хорооны байрны гадна, дотор тохижилт, тоног төхөөрөмж нийлүүлэх /7, 15, 23, 24 дүгээр хороо/	Хороо, тоо	4	ТЗУХ	100.0
	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 23 дугаар хорооны цогцолбор байрны гадна тохижилтын ажлыг "Хоймор хорооны залуус" иргэдийн бүлэг 18.7 сая, 24 дүгээр хорооны цогцолбор байрны цэвэр бохир усны шугам засварлах ажлыг "Аргалант арвис групп" ХХК 5.0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. 7 дугаар хорооны цогцолбор байрны тохижилтын ажлыг ОНХС-ийн 10.0 сая төгрөгөөр хийх байсан ч өөр эх үүсвэрээр хийгдэх болсон тул өөрчлөх саналыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны А/55 дугаар тогтоолоор гэр хорооллын гудамж, замын нөхцөлийг сайжруулах ажил болгон өөрчилж "Мөнх харш" ХХК 13.9 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.				
215	Хорооны цогцолбор байрны сантехникийн засвар хийх /17, 24 дүгээр хороо/	Хороо, тоо	2	ТЗУХ	100.0
	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17 дугаар хорооны цогцолбор байрны сантехникийн засварын ажлыг “БТРБ” ХХК 5.0 сая төгрөгөөр, 24 дүгээр хорооны байрны цэвэр бохир усны шугам засварлах ажлыг “Аргалант арвис групп” ХХК 5.0 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.				
216	Шаардлагатай хороодын байрны засвар, тохижилтыг дүүргийн Орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0

		Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8 дугаар хорооны чийрэгжүүлэлтийн танхимын тоног төхөөрөмж худалдан авах ажлыг “Си Эйч констракшн” ХХК 7.9 сая төгрөгөөр, 13, 16, 24 дүгээр хорооны нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, авто машины зогсоол тохижуулах, автомашины зогсоол, хороо, ӨЭМТ-ийн гадна тохижилтын ажлыг “Хянгар констракшн” ХХК 43.5 сая төгрөгөөр, 21 дүгээр хороонд иргэний танхимын тоног төхөөрөмж худалдах авах ажлыг “Би Си Ти” ХХК 9.9 сая төгрөгөөр, 25 дугаар хорооны иргэний танхимын тоног төхөөрөмж худалдан авах ажлыг “БСБ электроникс” ХХК 4.9 сая төгрөгөөр, 26 дугаар хорооны чийрэгжүүлэлтийн танхимын тохижилтын ажлыг “Жаргалын хэлхээ” ХХК 9.9 сая төгрөгөөр, 28 дугаар хорооны чийрэгжүүлэлтийн танхимын засвар үйлчилгээ, тохижилтын ажлыг “Нутгийн их үйлс” ХХК 17.9 сая төгрөгөөр, 30 дугаар хорооны гадна тохижилтын ажлыг “ЭМНГ” ХХК 11.5 сая төгрөгөөр, 32 дугаар хорооны цогцолбор байр, иргэний танхимын бохирын шугам засварлах ажлыг “СБГС” ХХК 11.5 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.				
217	5.7. Нутгийн удирдлагын төв байрыг барьж, төрийн бүх үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэн, иргэдэд хүргэх ая тухтай орчныг бүрдүүлж үйлчилгээний чанарыг сайжруулна.	Нутгийн удирдлагын ордон барих хөрөнгийн асуудлаар олон улсын байгууллага, хувийн хэвшилд хандах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Нутгийн удирдлагын ордон барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад уламжилснаар 2019 оны нийслэлийн төсөвт 2.5 тэрбум төгрөг туссан.				
218	5.8. Дүүргийн нэг цэгийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлж, нэг цэгийн үйлчилгээний төвийн тоог нэмэгдүүлнэ.	Дүүргийн нэг цонхны үйлчилгээний төвд төрийн байгууллагуудын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Газрыг бусдад худалдах, эрх шилжүүлэх үйлдэл татвартай болсонтой холбогдуулан нэг цонхны үйлчилгээнд Татварын хэлтсээс татварын орлогын байцаагч 3 дугаар сарын 1-нээс ажиллаж эхэлсэн. Нийт 2515 иргэн аж ахуйн нэгжид хуулийн зөвлөгөө мэдээллийг өгч, 4 дүгээр сараас Иргэний бүртгэлийн гадаад паспортын бүртгэл дүүргүүдэд шилжсэнтэй холбогдуулан хүлээн авах 2 цонх, гадаад паспортын олголт 1 цонх, Татварын хэлтэс 1 цонх, төрийн архивын 1 цонх нийт 5 цонхыг төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд зориулан гаргаж үйлчилгээгээ хэвийн тогтвортой явуулж байна. Тайлангийн хугацаанд гадаад паспорт хүлээн авах, олгох үйлчилгээгээр нийт 15610 иргэнд, төрийн архивын үйлчилгээгээр 145 иргэнд лавлагаа мэдээлэл олгож үйлчилсэн байна.				
219	5.9. Хороодын хүн амын ачааллыг тэнцвэржүүлэх, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг сайжруулах зорилгоор 10000-с дээш хүн амтай хороодыг хуваах асуудлыг шийдвэрлэнэ.	Шинээр байгуулагдах хороодын цогцолбор байрны газрын байршлыг тогтоож, гэрчилгээ олгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		“10000-с дээш хүн амтай хороодыг хуваах асуудлыг шийдвэрлэх”, “1, 2, 6, 7, 22, 23, 24, 25, 26, 31 дүгээр хороодыг хуваах” саналыг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, дээд шатны байгууллагуудад уламжилж, шинээр байгуулагдах хороодын цогцолбор байрны газрын байршлыг тогтоож, газрын захирамж гэрчилгээг гаргуулсан. Дүүргийн эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл, газрын байршил болон бусад хүчин зүйлсүүдийг харгалзан				

		үзэж, шинээр өөрчлөн зохион байгуулах 2 дүүрэг буюу “Зүүн дүүрэг”-т 22, “Баруун дүүрэг”-т 22 нийт 44 хороо байгуулах тооцоо, судалгааг хийлээ. Хүн амын төвлөрөл, цаашид хүн амын суурьшил нэмэгдэх боломж зэргийг харгалзан найман хороог 2, хоёр хороог 3 хувааж, шинээр байгуулагдах “Зүүн дүүрэг”-т 5, “Баруун дүүрэг”-т 7 нийт 12 хороо байгуулах саналыг боловсруулсан. Сонгинохайрхан дүүргийг өөрчлөн зохион байгуулахтай холбоотой тооцоо, судалгааг УИХ-ын гишүүд, нийслэлийн ИТХ-ын Төлөөлөгчдөд хүргүүлж холбогдох саналыг авч тусган, Тамгын газрын даргын 2018 оны 01/1720 тоот албан бичгээр дүүргийн ИТХ-д өргөн барьсан.				
220	5.10. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулж, “Олон нийтийн цагдаа”, “Оюутан цагдаа” арга хэмжээг үргэлжлүүлж, камержуулах ажлыг эрчимжүүлнэ.	Төрийн байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хууль, эрх зүйн актуудаар сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ, Цагдаагийн хэлтсүүд	100.0
		Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр нээлттэй хаалганы өдөрлөгийг давхардсан тоогоор 8 удаа, сургалт, сурталчилгааны ажлыг 16 удаа үүнээс төрийн байгууллага албан тушаалтанд 4, аж ахуйн нэгж байгууллагад 6, холбогдох байгууллагуудтай хамтран иргэдэд 6 удаа 12250 иргэнийг хамруулан зохион байгуулж 6000 ширхэг брошур, 2500 ширхэг гарын авлагыг бэлтгэн тараасан. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, хороодын албан хаагч нарыг хамруулан хөтөлбөрийг танилцуулах, хэрэгжүүлэх арга замын талаар сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. 32 хорооны иргэдэд Үндэсний хөтөлбөр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах, үнэ төлбөргүй хуулийн зөвлөгөө өгөх аяныг 7 хоногийн хугацаатай зохион байгуулж ажилласан. Хууль, эрх зүйн актуудын шинэчилсэн найруулгын төслүүдээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан 3 хууль, 3 журмын төслүүдээр 6 удаа 554 хүнд хэлэлцүүлэг зохион байгуулан иргэдээс гарсан саналуудыг нэгтгэн төслийн багт хүргүүлсэн.				
221		Төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагч, ажилтныг нийтийн эргүүлд татан оролцуулах, иргэдийг урамшилт эргүүлээр ажиллуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ, Цагдаагийн хэлтсүүд	100.0
		Дүүргийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог хангах чиглэлээр нэгдсэн арга хэмжээг 2 удаа, эргүүл хяналт шалгалтын ажлыг 3 удаа холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 248 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөрчилтэй байсан 57 байгууллагад цагдаагийн байгууллагаас албан мэдэгдэл хүргүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, боловсрол, эрүүл мэндийн салбарын 115 албан хаагчдыг 5 өдөр 30 хорооны нутаг дэвсгэрт 84 чиглэлд гудамж талбайд нийтийн хэв журам хамгаалах эргүүлд гарган ажиллуулж, Сар шинэ нэгдсэн арга хэмжээний хүрээнд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 650.0 мянган төгрөгийг эргүүлийн үйл ажиллагаанд зарцуулсан. “Хэв журмын урамшилт эргүүл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр идэвхтэй иргэдийг ажиллуулахаар хороо бүрээс санал авч 55 иргэнийг хэсгийн байцаагч, хороо цагдаа нарын удирдлагад ажиллуулж цагдаагийн алба хаагч, аж ахуйн				

	<p>нэгж байгууллагын албан хаагчидтай хамт нэгдсэн эргүүлд долоо хоног бүрийн Даваа, Пүрэв, Бямба гаригуудад ажиллуулж байна. Урамшилт эргүүлээр ажиллаж байгаа 167 иргэдэд сургалтыг 2 удаа зохион байгуулж, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тасгийн фэйсбүүк хуудас, вэб сайтад байршуулж үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажилласан. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 441 аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулан 7 хоног бүрийн Лхагва гаригт гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газар, цэгүүдэд хяналт тавин хороо хариуцсан хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтнуудтай хамтран иргэдийн нийтийн эргүүлд гарган ажиллуулсан.</p>				
222	<p>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оюутан залуусыг татан оролцуулж хамтран ажиллах, олон нийтийн цагдаагийн ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн материалыг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>ТЗУХ, Цагдаагийн хэлтсүүд</p>	<p>100.0</p>
	<p>Олон нийтийн цагдаагийн эрх зүйн орчныг сайжруулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 37 ажилтанд “Зөрчлийн тухай хууль”, “Таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам”, “Олон нийтийн цагдаагийн дүрэм, түүнд тавигдах шаардлага, гэрээний загвар” зэрэг сэдвүүдээр цагдаагийн хэлтсүүдтэй хамтран сургалт, хэлэлцүүлгийн ажлыг зохион байгуулж ажилтнуудаас гарсан саналыг нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлсэн. Олон нийтийн цагдаа арга хэмжээний хүрээнд сонгон шалгаруулалтад тэнцсэн 5 иргэний материалыг хүлээн авч судлан нийслэлийн Цагдаагийн газарт санал хүргүүлэн цагдаагийн 2, 3 дугаар хэлтэст гэрээ байгуулан ажиллуулж байна. Оюутан цагдаа арга хэмжээний хүрээнд “Хууль сахиулахын их сургууль”, “Мандах бүртгэл”, “Чингис Соосэ” зэрэг их, дээд сургуулиудтай хамтран гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдэж байгаа 22 хорооны нутаг дэвсгэрт 96 чиглэлд 680 оюутан залуусыг гудамж талбайд нийтийн хэв журам хамгаалах эргүүлд гаргах ажлыг 2 удаа цагдаагийн хэлтсүүдтэй хамтран зохион байгуулж ажиллалаа.</p>				
223	<p>Цагдаагийн 3 дугаар хэлтсийн барилгын өргөтгөлийг ашиглалтад оруулах</p>	<p>Барилгын ажлын гүйцэтгэл, хувь</p>	<p>100</p>	<p>ТЗУХ, Цагдаагийн 3 дугаар хэлтэс</p>	<p>100.0</p>
	<p>Цагдаагийн 3 дугаар хэлтсийн барилгын өргөтгөлийг 1.2 тэрбум төгрөгийн өртөгтэйгээр барьж дуусган 2018 оны 02 дугаар сарын 04-ний өдөр улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад орсон.</p>				
224	<p>Цагдаагийн 2 дугаар хэлтсийн барилгын өргөтгөлийг эхлүүлэх</p>	<p>Барилгын ажлын гүйцэтгэл, хувь</p>	<p>50</p>	<p>ТЗУХ, Цагдаагийн 2 дугаар хэлтэс</p>	<p>100.0</p>
	<p>Нийслэлийн Худалдан авах ажиллагааны албаны тендер сонгон шалгаруулалтаар “Хөлөг-Од”, “Жи Лемит” зэрэг ХХК барилгын гүйцэтгэгчээр шалгарч цагдаагийн 2 дугаар хэлтсийн 3 давхар болон үүдний өргөтгөлийн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>				

225		Нийтийн эзэмшлийн гудамж талбайд камержуулалтын ажил хийх /1, 3, 4, 6, 7, 9, 10, 18, 19, 21, 22, 23, 26, 27, 28, 29, 31 дүгээр хороо/	Хороо, тоо	17	ТЗУХ	100.0
Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13 хорооны нутаг дэвсгэрийн 138 цэгт 237.2 сая төгрөгийн үнэ бүхий 138 камер, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 35.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж 9, 25 дугаар хороодын нутаг дэвсгэрт 9 цэгт 18 ширхэг камерыг шинээр нэмж суурилуулсан. “Камержуулалт-2” болзолт уралдааны хүрээнд хороодын Засаг дарга, Иргэдийн нийтийн хурлын дарга, аж ахуй нэгж байгууллагын захирал, ажилтан, хэсгийн ахлагч, иргэдийн төлөөллийг хороо тус бүрийн иргэний танхимд давхардсан тоогоор 21 удаагийн уулзалтыг зохион байгуулж уралдааны хүрээнд ирүүлсэн удирдамж, зөвлөмж, зэргийг танилцуулж, 50 ширхэг зурагт хуудсыг тарааж идэвх санаачилгатай оролцох талаар сурталчилан ажилласан. Тус арга хэмжээний хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудаас 205.5 сая төгрөгөөр нийтийн эзэмшлийн гудамж талбайд 196 цэгт 225 хяналтын камерыг суурилуулсан.						
226	5.11. Замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, автын осол, түүнээс учрах хохирлыг бууруулна.	Зам тээврийн осол хэргүүд гарч байгаа замуудад явган зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласан хайс, хашлага, хурд сааруулагч нэмж байрлуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ, Замын цагдаагийн хэлтэс	100.0
Дүүргийн хэмжээнд 65, 107, 122 дугаар сургуулийн бүсэд замын хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээг хийлгэж, стандартын дагуу сургууль орчмын бүсэд шинээр нийт 28 тэмдгийг байршуулсан. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд замын хөдөлгөөний зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр “Энхжин” худалдааны төвийн урд байрлах эгнээ тусгаарласан 56 ширхэг хайсыг байрлуулсан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор дүүргийн 7 дугаар хорооны нутаг хилчин хотхоны урд замд 40 м туузан хайс, Баянхошууны тойргийн уулзварт 30 м хайсыг хийлгэж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажилласан. Дүүргийн Засаг даргын санаачилгаар “One community” төслийн хүрээнд “Жи Си Ай” Монгол төрийн бус байгууллагын хөрөнгө оруулалтаар 104 дүгээр сургуулийн бүсэд хүүхдэд ээлтэй гарцыг 5.3 сая төгрөгөөр хийж тохижуулсан. Москвагийн гудамжинд эгнээгээр явах хөдөлгөөний чиглэл гэх өндрийн тэмдэг 8 ширхэгийг хийлгэж, Улаанбаатар зам засвар арчлалтын ОНӨААТҮГ-аар 32 дугаар хороо, баруун аймгийн уулзварт 5 ширхэг тэмдэг, Моносын уулзварт 2 ширхэг тэмдгүүдийг байрлуулж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажилласан.						
227		Зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, тэмцээн зохион байгуулах, санамж сэрэмжлүүлгийн материал тараах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ, Замын цагдаагийн хэлтэс	100.0
Бага насны хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 6 сургуулийн 250 гаруй сургагч, 100 гаруй эцэг эхчүүдэд, 3 цэцэрлэгийн 60 гаруй хүүхэд 50 гаруй эцэг эхчүүдэд, 12 аж ахуйн нэгж, байгууллагын 215 ажилтан албан хаагч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдал, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд хэрхэн аюулгүй						

		зөв оролцуулах талаар сургалт мэдээлэл хийлээ. Дүүргийн Засаг даргын 2018 оны А/203, А/542 дугаар захирамжуудаар “Замын хөдөлгөөний цагаан толгой”, “Ногоон гэрэл-цагаан шугам 2018” зэрэг уралдаан, тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулиудын дунд уламжлал болгон зохион байгуулан 18 сургуулийн 3-5 дугаар ангийн 216 хүүхэд багачууд оролцсон. Сургуулийн орчимд зам тээврийн хэрэг, осол гарсан 7 сургуулийн захиргаанд осол, хэрэг гарсан шалтгаан нөхцөлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах талаар Замын цагдаагийн хэлтсээс албан мэдэгдэл хүргүүлж үр дүнг тооцож ажилласан. Орон сууцны хороолол дотор бага насны хүүхэд зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Содон”, “Хилчин хотхон”, “Залуус” “Москва”, “Орчлон” зэрэг орон сууцны хорооллын сууц өмчлөгчдийн холбоодод хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлсэн сэрэмжлүүлэг бүхий самбар, анхааруулах тэмдэг байрлуулах, хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдлыг бүрдүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах талаар албан мэдэгдэл хүргүүлж хамтран ажиллаж байна.				
228	5.12. Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавин иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.	Цэргийн бүртгэл, хугацаат цэргийн албанд татах, халах, цэргийн гэрээт алба, цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх ажлыг хуулийн дагуу зохион байгуулж, цэргийн насны залуучуудын эрүүлжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Цэргийн штаб, ЭМТ	100.0
		Дүүргийн Засаг даргын 2018 оны А/184, А/458 дугаар захирамжийн дагуу 2018 оны нэг, хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанаас халагдаж ирсэн дайчдыг 2018 оны 05 дугаар сарын 01, 02, 10 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд, хугацаат цэргийн албанд иргэдийг элсүүлэх ажлыг 2018 оны 5 дугаар сарын 04-06, 10 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулж, нийслэлийн Засаг даргаас өгөгдсөн тоон даалгаврыг биелүүлж ажилласан. 2018 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар цэргийн зарлан дуудах мэдэгдэл хүлээн авч цэрэг татлагын байранд ирээгүй ирээдийн нэрийн жагсаалтыг гарган, мэдэгдэх хуудсаар дуудан, холбогдох хуулиудыг тайлбарлан 112 иргэнд 18.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч орон нутгийн төсөвт төвлөрүүлэв. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдийн нэрийг дүүргийн Засаг даргын 2018 оны А/267, А/465 дугаар захирамжуудаар баталгаажуулж, 350 иргэнээр 223.1 сая төгрөгийн мөнгөн төлбөр төлүүлж, нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна. Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5 дахь хэсгийг үндэслэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас чөлөөлөх болзол хангасан 200 иргэний холбогдох материалыг бүрдүүлэн хүлээн авч, мөнгөн төлбөрөөс чөлөөлсөн. “Оюутан цэрэг сургалт”-ын журмыг дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг их дээд сургуулиудад сурталчлах, элсүүлэх ажлыг зохион байгуулж, 21 эрэгтэй оюутан цэргийн ерөнхий бэлтгэл, эрүүл мэндийн үзлэгийг ханган, цэргийн тусгай бэлтгэл сургалтад хамрагдаж байна.				
229		Дайчилгааны бэлэн байдлын бэлтгэлжилтийг дээшлүүлж, албан тушаалтан, дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтыг чанартай зохион байгуулж, мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Цэргийн штаб	100.0

	<p>Дүүргийн Засаг даргын захирамжаар дайчилгаа удирдах бүлгийн гишүүд, орон нутгийн цэргийн отрядын удирдах бүрэлдэхүүнийг шинэчлэн томилгоожуулж, баталгаажуулав. Дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалтад хамрагдах цэргийн үүрэгтний нэрийн жагсаалтыг гарган, хороодоор дамжуулан дайчлах хуудас тараан дуудаж, холбогдох хууль тогтоомжийг тайлбарлан гэрээ байгуулсан. Дайчилгааны бэлтгэл нөөц, цэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн бага “Автын техникийн засварчин”, “Ариун цэврийн зааварлагч” мэргэжил олгох сургалтыг Зэвсэгт хүчний 011, 027 дугаар ангиудын байрлалд зохион байгуулав. Оногдуулан данслагдсан бэлтгэл офицер, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг тодотгож, анги командуудад нь нөхөн хангалт хийсэн. Бэлтгэл офицер, цэргийн үүрэгтнүүдэд явуулсан тодотголын дагуу улаан, цэнхэр, ногоон дайчлах хуудсыг бичиж, бэлэн байдлыг хангав. Нийслэлээс өгөгдсөн зарлан мэдээллийн дохиогоор 2018 оны 03 дугаар сарын 30, 06 дугаар сарын 18, 11 дүгээр сарын 16-нд, дотоодын зарлан мэдээллийн дохиогоор 2018 оны 02 дугаар сарын 08, 03 дугаар сарын 30, 08 дугаар сарын 21-нд тус тус ажиллаж, дүүргийн дайчилгаа удирдах бүлэг, хороод, цугларах, шилжүүлэх байруудад зарлан мэдээлэл явуулан, үүрэг гүйцэтгэлт, бэлэн байдлыг шалган, зарлан мэдээллийн дохиогоор ажилласан тэмдэглэлийг табель маягтаар нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргэсэн.</p>				
230	<p>Батлан хамгаалах хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, иргэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх ажлыг зохион байгуулж, батлан хамгаалах төрийн үйлчилгээг үзүүлэх</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>Цэргийн штаб, НХХ</p>	<p>100.0</p>
<p>Батлан хамгаалах багц хуулиудыг сурталчлах, 18-50 насны эрэгтэйчүүдийн цэргийн үүргийн биелэлтийг шалган туслах ажлыг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуй нэгж, байгууллагад зохион байгуулж явуулсан. Энэхүү шалган туслах ажлаар нийт 333 цэргийн үүрэгтэн хамрагдан үүнээс цэргийн бүртгэлд хамрагдаагүй 16, цэргийн үүрэгтний үнэмлэхгүй 12, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 36 иргэнийг тогтоон илэрсэн зөрчлийг арилган батлан хамгаалах хууль тогтоомжийг байгууллагын удирдлага, цэргийн үүрэгтнүүдэд тайлбарлан таниулах, гарын авлага тараах ажлыг зохион байгуулав. Мөнгөн төлбөр тогтоогдсон 9 иргэн 1.6 сая төгрөгийг нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлээд байна. Соёлын төв өргөөнд зохион байгуулагдсан Батлан хамгаалах хууль, тогтоомж сурталчлах өдөрлөгийн арга хэмжээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын үйл ажиллагаа, Батлан хамгаалахын багц хуулиудыг сурталчилсан хулдаасан хэвлэл, зурагт слайд-10 ширхэг, батлан хамгаалах хууль тогтоомжийн танилцуулга нугалбар-250 ширхэгийг тус тус шинээр хэвлүүлэн бэлтгэж оролцов. Их засаг олон улсын их сургуулийн Чингис соосэ цогцолбор сургуулийн оюутнуудад Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас “Бид эх орны хүү” сэдэвт уулзалт арга хэмжээг зохион байгууллаа. Хорооны хэсгийн ахлагч нарын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж 260 гаруй хэсгийн ахлагч хамрагдсан. Монгол Улсын “Дайчилгааны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/74 дүгээр захирамжийн дагуу дүүргийн хорооны Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг зохион байгууллаа. Сургалтад хорооны Засаг дарга нар бүрэн хамрагдаж, мэдлэг дадлагаа дээшлүүлэв.</p>					

	<p>Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/62 дугаар тушаал, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2018 оны А/09 дүгээр тушаалын дагуу Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнүүдэд цэргийн анхан шатны мэдлэг, дадлага олгох сургалт зохион байгуулагдсан. Сургалтад 7 цэргийн үүрэгтэн хамрагдаж, цэргийн анхан шатны мэдлэг дадлага эзэмшив. Цэргийн дүйцүүлэх албан хаагчдад цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл шатны сургалтыг дүүргийн Засаг даргын Сургалт зохион байгуулах тухай 2018 оны А/255 дугаар захирамжийн дагуу шаардагдах зардлыг баталгаажуулан, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын даргын 2018 оны 09 дүгээр тушаалаар томилогдсон бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн байрлалд зохион байгуулав. Тус сургалтад 8 дүйцүүлэх алба хаагчдыг холбогдох бичиг баримтыг бэлтгэн хамруулан оролцуулав. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 79, 80 дугаар тогтоол, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 58 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2018 оны А/819 дүгээр захирамжийг үндэслэн цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Сургалтад 16 цэргийн дүйцүүлэх алба хаагч иргэд оролцож, мэдлэг, дадлага эзэмшив.</p>				
231	<p>Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, төрийн нууцыг хамгаалах журмыг хэрэгжүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийг журмын дагуу хөтлөх, нөхөн бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтыг хариуцан зохион байгуулах</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>Цэргийн штаб</p>	<p>100.0</p>
<p>Онц чухал маш нууц, маш нууц, нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт гарган Нууцын баталгаа гаргуулах тухай Тамгын газрын даргын 2018 оны а/02 дугаар тушаалаар Цэргийн штабын дарга, офицерууд, дүүргийн дайчилгаа удирдах бүлэг, 32 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт холбогдох хуулийн заалт, Монгол улсын ерөнхийлөгчийн 213 зарлигаар батлагдсан Төрийн нууцыг хамгаалах журмын 3.1.2 дахь заалт, Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журмын 1.12, 1.14, 1.15, 2.5.4, 6.12 дахь хэсгүүд болон заалт, нууц баримт бичиг хариуцагчийн мөрдөх журам, хориглох зүйл, хүлээх үүргийг танилцуулан зааварчилгаа өгч хүн нэг бүрээр баталгаа гаргуулсан. Монгол улсын “Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.2.12-д заасны дагуу 2018 оны нууц бичиг, хэрэг, данс бүртгэлийн ангиллыг 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлуулсан байна. Цэргийн штабын нууц баримт бичгийн 2017 оны ангиллыг хааж, дараа оны ангилалд шилжүүлсэн. Цэргийн штабын нууцад 2017 оны дайчилгааны болон нууц баримт бичиг хэрэг, данс бүртгэлийн ангиллын дагуу 18 хавтаст хэрэг, 12 данс бүртгэл хөтлөгдөж байна. Нууц компьютерийн операторын бүртгэлээр 36, явсан нууц баримт бичгийн бүртгэлээр хугацаат мэдээ судалгаа, халагдсан цэргийн үүрэгтний судалгаа, цэргийн бүртгэл, цэрэг татлагын мэдээ судалгаа зэрэг 36 баримт бичиг бүртгэгдэж, ирсэн нууц баримт бичгийн бүртгэлээр ном шилжүүлэх тухай акт, ээлжит цэрэг татлагын тоон даалгавар, халагдсан цэргийн үүрэгтний бүртгэл, судалгаа, зэрэг 28 баримт бичиг, тараах дансаар 89 нууц баримт бичиг тарааж хүлээн авсан албан тушаалтнаар гарын үсэг зуруулан баталгаажуулж ажиллалаа. 2018</p>					

		оны 06 сарын 05-ны байдлаар 139 баримт бичгийг стандартын дагуу боловсруулан бүртгэж холбогдох газар хэлтэст баримт бичиг дугтуйг тараах дансаар нийт 159 баримт бичгийг тарааж хүргүүлсэн байна. Ирсэн бичгийн бүртгэлээр ирсэн баримт бичиг 62, тогтоол, тушаал, захирамжийн бүртгэлээр 90 тогтоол, тушаал, захирамж цахим ирсэн бичгийн бүртгэлээр /Edoc/ программаар 12 баримт бичиг, өргөдөл гомдлын бүртгэлээр 65 иргэний орон нутгийн чөлөө, цэргийн албанаас чөлөөлүүлэх, ээлжит цэрэг татлагаас түр чөлөөлүүлэх зэрэг өргөдлийг хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан шийдвэрлүүлсэн.				
232	5.13. Байгалийн болон гэнэтийн гамшиг, ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах, нөхөн сэргээх чадавхийг нэмэгдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллана.	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ОБХ	100.0
		Тус дүүргийн нутаг дэвсгэрт болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, хүрээлэн байгаа орчныг хамгаалах урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын томилгоот бүрэлдэхүүнийг сургах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт Гамшгаас хамгаалах дадлага сургууль бэлэн байдлын үзлэгийг 2018 оны 10 дугаар сарын 05-06-ны хооронд зохион байгуулж давхардсан тоогоор 4585 хүн хамрагдаж 93.2 хувьтай буюу дүүрэн хангалттай гэсэн үнэлгээгээр дүгнэгдсэн. Дүүргийн Засаг даргын 24 захирамжаар 167.8 сая төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулан гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажилласан.				
233		Гүний худаг засварлах /Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр анги/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ОБХ	ҮБ
		Тус хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 29 дүгээр ангийн гүний худгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Улсын төсөвт суулгахаар 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10.6/28 тоот албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна.				
234	5.14. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ухаалаг технологийг нэвтрүүлэн ажиллана.	Дүүргийн ЗДТГ, хороодод дотоод mail мессенжер нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгууд болон 32 хороодод албаны и-мэйл хаяг болох “outlook” программыг нэвтрүүлэх ажлыг 2018 оны 1 сараас эхлэн ЗДТГ болон хороод гэсэн хоёр хэсэгт хуваан хуваарь гарган төрийн албан хаагчдад 14 хоногийн хугацаанд “outlook” и-мэйл программыг нэвтрүүлэх тохиргоог хийж өгсөн. “Outlook” программын ашиглалтын талаар ЗДТГ-ын болон хороодын төрийн албан хаагч нарт сургалт хийж, заавар зөвлөгөө өгч ажилласан. Нийслэлийн Мэдээлэл технологийн газартай хамтран Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дотоод удирдлагын “UB ERP” систем рүү шилжүүлэх ажлыг 2018 оны 10 дугаар сарын 1 ны өдрөөс эхлэн “EDOC” систем дэхь төрийн албан хаагчдын мэдээллийг “UB ERP” системтэй холбон Төрийн албан хаагчдын мэдээллийг татан оруулж шинээр бүртгэн ажилласан. Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгууд болон 32 хороодын албан хаагчид, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, сургууль, цэцэрлэгүүдийг хамруулан 3 удаагийн сургалтыг зохион байгуулан “UB ERP” системийг нэвтрүүлэн ажиллаж байна.				

235		<p>Дүүргийн шилэн кабелиг засварлан шинэчлэх, шинэ дэвшилтэт технологи болох "IPPBX" буюу дотуур холбоо нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын шилэн кабелийн аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж гарсан гэмтлийг хурдан шуурхай олж тогтоон, цаг алдалгүй засварлан хэвийн ажиллагаанд оруулж ажилласан. Дараах хороодод засвар үйлчилгээ хийлээ. Үүнд:</p> <p>1 дүгээр хорооны шилэн кабель 5 дугаар хорооны 48 корын шилэн кабелийн ажил 7 дугаар хорооны 48 корын шилэн кабелийн ажил 22 дугаар хорооны шилэн кабелийг 2 удаа 24 дугаар хорооны шилэн кабелийг 2 удаа 23 дугаар хорооны шилэн кабелийн ажил 25 дугаар хорооны шилэн кабелийн ажил 31 дугаар хорооны шилэн кабелийн ажил</p> <p>Агаарын шилэн кабель ашигладаг хороодын шилэн кабелийн шугамын зураглалыг гаргаж баталгаажуулан ажилласан.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
236		<p>Дүүргийн ЗДТГ-ын мэдээлэл хадгалах, нөөцлөх сервер тоног төхөөрөмжүүдийг өргөтгөж сайжруулах</p> <p>Хадгалах, нөөцлөх тоног төхөөрөмжийн талаар холбогдох судалгааг хийж удирдлагуудад танилцуулсан. "EDOC" систем дэх төрийн албан хаагчдын мэдээллийг "UB ERP" системтэй холбон Төрийн албан хаагчдын мэдээллийг татан оруулж мэдээлэл хадгалах, нөөцлөх сервер тоног төхөөрөмжүүдтэй холбож өргөтгөл хийсэн.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
237		<p>Засаг даргын Тамгын газар, хороодод хадгалагдаж байгаа цаасан баримтыг цахим, тоон хэлбэрт шилжүүлэх, архивын баримтын хадгалалтын нөхцөлийг сайжруулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх</p> <p>1992-2015 оны дүүргийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал нийт 13520 хуудас цаасан суурьтай баримтыг цахим, тоон хэлбэрт оруулсан. Хороодод захирамжлалын баримт бичгийг archive программд оруулах ажил хэвийн явагдаж байна. Дүүргийн архивын хадгаламжийн сангийн зай талбай, нөхцөлийг сайжруулах зорилгоор Спорт цогцолборт 24м² өрөөг архивын зориулалтаар засварлан тохижуулж, 6 ширхэг нягтруулсан тавиур шүүгээ байршуулсан. Засаг даргын Тамгын газрын байрнаас 1500 хадгаламжийн нэгж баримтыг шинэ байранд нүүлгэн шилжүүлсэн.</p>	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0

238		Албан хэрэг хөтлөлт, архивын нэгдсэн системийн нэвтрүүлэлтийг эрчимжүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн нэвтрүүлэлтийг эрчимжүүлэх зорилгоор Засаг даргын Тамгын газар, хороодын түвшинд шаардлагатай байгаа компьютер, техник хэрэгслийн судалгааг Аж ахуйн тасагтай хамтран гаргасан. Судалгааг үндэслэн төрийн албан хаагчдын ажлын хэрэгцээнд i5 үзүүлэлттэй иж бүрэн компьютер 22, i7 үзүүлэлттэй иж бүрэн компьютер 2, өндөр хурдны скайнер 1, notebook 5-ыг худалдан авахад Засаг даргын Тамгын газраас 41.0 сая төгрөг зарцуулсан байна. Үүний үр дүнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем /edoc/-ийн нэвтрүүлэлт эрчимжсэн. Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа программуудыг нэгтгэн боловсронгуй болгосон ERP программыг дүүргийн хэмжээнд нэвтрүүлж байна.				
239		21 дүгээр хороонд төрийн архивын Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Архивын нэг цонхны үйлчилгээний бэлтгэл ажлын хүрээнд Жаргалант тосгоны Захирагчийн ажлын албанаас иж бүрэн компьютер, 3 үйлдэлт хувилагч шинээр худалдан авч, архивчийн ажиллах нөхцөл, цалинд 10.0 сая төгрөг зарцуулсан байна. 21 дүгээр хороо, Жаргалант тосгоны архивт хадгалагдаж байсан 1974 оноос хойших цаасан суурьтай баримтыг цэгцэлж, цахим, тоон хэлбэрт шилжүүлсэн. 21 дүгээр хороо, Жаргалант тосгонд төрийн архивын нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх нээлтийн арга хэмжээ 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр болж иргэдэд төрийн архивын 21 төрлийн лавлагаа мэдээллээр хөнгөн шуурхай үйлчилж байна.				
240	5.15. Дүүргийн Засаг даргын дэргэд “Хэвлэл мэдээллийн төв” байгуулж, иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран дүүргийн төр, захиргааны байгууллагуудаас зохион байгуулсан үйл ажиллагааны мэдээллийг иргэд, олон нийтэд шуурхай хүргэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
		Дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан ажлыг TB5, TB8, SBN, ETV, NTV, Eagle tv, Star tv, UBS tv, VTV, HD Mongol, MNB зэрэг телевизээр сурталчилж 200 гаруй мэдээллийг бэлтгэсэн. Дүүргийн хэмжээнд зохион байгуулагдсан ажлыг тогтмол Shuurhai.mn, bolod.mn, mongolcomment.mn, fact.mn, ontsloh.mn, chuham.mn, ingo.mn, tusgaar.mn, tur.mn, gurvanzuv.mn зэрэг 30 цахим сайтуудад сурталчилж 450 гаруй мэдээллийг нийтэлсэн. Дүүргийн цахим сайт shd.mn сайтад тогтмол мэдээлэл оруулж байна. 2018 онд сонин сэтгүүл болон телевизийн ярилцлагад нийт 20 гаруй удаа орсон байна. Үүнд: 01.09-нд VTV-Цэргийн штаб 05.04-нд SBN TV-Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэс 10.23-нд Үндэсний шуудан сонин-Малтай иргэдийн газар хүссэн өргөдлийн талаарх сурвалжлага 11.14-нд Үндэсний шуудан сонин-Дүүрэг хуваах тухай Засаг даргын ярилцлага 10.17-нд Үндэсний шуудан сонин-Дүүрэг хуваах тухай Засаг даргын ярилцлага 11.07-нд SBN TV-Дүүргийн нөхцөл байдлын талаар Засаг даргын ярилцлага 11.06-нд Засгийн газрын мэдээ сонин-Засаг даргын ярилцлага гэх мэт.				

241		Харилцаа, хамтын ажиллагаатай улс, орнуудын хотуудтай аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ болон бусад чиглэлээр санамж бичиг болон хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	ТЗУХ	100.0
<p>1. Засаг даргаар ахлуулсан төлөөлөгчид Япон улсын Изүнокүни хотод албан айлчлал хийж, Токио хотод олон улсын Оиска байгууллагатай уулзах уулзалтыг зохион байгууллаа.</p> <p>2. БНСУ-ын Тэ-Ан хоттой ажилтан бэлтгэх санамж бичгийн дагуу тус хотын Гадаад харилцааны хэлтсийн дарга дүүрэгт айлчилж орлогч дарга О.Ганбаатартай албан уулзалт хийж дүүргийн 60 иргэн ажлын байраар хангагдсан.</p> <p>3. 2018 оны 07-р сарын 23-25-нд Япон улсын Күмамото хотын “Asia Frontier” байгууллагын ерөнхийлөгч Ишихара Ясунари, Flag waving ХХК-ийн захирал Курихара Салли, Ази Фарреим ХХК-ийн мэргэжилтэн Ogasawara Teiichi нар дүүрэгт айлчилж, дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчид болон гарааны бизнес эрхлэгч залуучуудтай уулзан бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг Япон улс руу нийлүүлэх ажлын талаар ярилцаж Жамц давс, Хонины тосон саван, Самрын ясан дэр, Халгайн бүтээгдэхүүнүүд дээр хамтран ажиллахаар тохиролцсон.</p> <p>4. 2018 оны 07 дугаар сарын 27-ноос 08 дугаар сарын 01-ний өдрүүдэд Япон улсын Изүнокүни хотын захирагч Оно Тошико тэргүүтэй төлөөлөгчид дүүрэгт айлчилж, сурагч солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар санал солилцон, 2019 оны 1 дүгээр улиралд Сонгинохайрхан дүүргийн сурагчид Изүнокүни хотод зочлох, эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмж болон түргэний машины тусламжийн талаар судалгаа хийхээр боллоо. Мөн энэ хугацаанд сурагч солилцооны хөтөлбөрийн дагуу Изүнокүни хотын 20 сурагчийг Олон Улсын Хүүхдийн Найрамдал төвд хүлээн авч амраалаа.</p> <p>5. 2018 оны 08 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Хайлаар дүүргийн гадаадтай нөхөрсгөөр харилцах албаны дарга Боу Лин тэргүүтэй төлөөлөгчид дүүрэгт албан айлчлал хийлээ.</p> <p>6. 2018 оны 09 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд БНХАУ-ын Хөлөнбуйр хотын Хайлаар дүүргийн Засаг дарга Ян Гүе Хун тэргүүтэй төлөөлөгчид дүүрэгт айлчилж, 2 дүүргийн хооронд байгуулсан нөхөрсөг хот хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа ажлуудаа эрчимжүүлж, зөвхөн олон улсын үзэсгэлэн худалдаа, бүх салбарт хамтран ажиллахыг талууд дэмжиж гэрээнд гарын үсэг зурлаа.</p> <p>7. 2018 оны 09-р сарын 03-07-ны өдрүүдэд БНХАУ-ын Хөлөнбуйр хотын Хайлаар дүүрэгт жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг БНХАУ, ОХУ, Монгол 3 улсын үндэсний үйлдвэрлэлийн үзэсгэлэн яармагт Засаг даргын орлогч Д.Ундармаагаар ахлуулсан 30 төлөөлөгч оролцож дүүргийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн эрхлэгчдийн холбооны 23 аж ахуй нэгж үндэсний үйлдвэрлэлээ сурталчлан бараа бүтээгдэхүүнээ борлууллаа. Мөн албаны төлөөлөгчид үзэсгэлэн худалдаа, эдийн засгийн форумд оролцохоос гадна Хайлаар дүүргийн Монгол бага болон дунд сургуультай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурлаа.</p> <p>8. 2018 оны 09 дүгээр сарын 03-наас 12-ны хооронд БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан Ядуурлаас бууруулах сургалтад хууль зүйн тасгийн мэргэжилтэн Б.Сэдэд, ТГХШХ-ийн мэргэжилтэн Г.Галбадрах нар оролцсон.</p> <p>9. Турк улсаас Монгол улсад суугаа элчин сайдтай уулзалт зохион байгуулсан. Мөн Турк улсын элчин сайдын яамнаас дүүргийн зорилтот бүлгийн 200 иргэнд цахилгаан халаагуурын тусламж үзүүлж цаашид хамтран ажиллахаар болсон.</p>						

		<p>10. Австрали улсын Swarco компанийн төлөөлөгчидтэй хамтран дүүрэгт хийгдэх гэрэлтүүлгийн ажлын судалгааг гаргасан.</p> <p>11. Япон улсын элчин сайд дүүрэгт айлчилж Өвсний үндэс хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээнд гарын үсэг зурсан.</p> <p>12. БНСУ-ын Сараанбат ТББ-аар дамжуулан WECA байгууллага дүүрэгт сургууль цэцэрлэг барих боломжийг судалж Засаг даргатай уулзалт зохион байгууллаа.</p> <p>13. Япон улсын Оиска байгууллагын тэргүүн Тошихиро Накано дүүрэгт айлчилж Засаг даргатай уулзан, дүүргийн Онцгой байдлын хэлтэст галын авто машин гардуулсан.</p> <p>ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хотын Хайлаар дүүрэгтэй 2019 онд хамтран ажиллах санал боловсруулсан.</p> <p>14. УИХ-ын гишүүн Х.Нямбаатар, Засаг дарга Ж.Сандагсүрэн, Боловсролын хэлтсийн дарга А.Дүүдээ, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Д.Батцэцэг болон Ерөнхий боловсролын сургуулиудын төлөөллүүд 2018 оны 10 дугаар сард Тайвань улсыг зорьж тэтгэлгээр суралцаж байгаа оюутнуудын амьдрах орчин нөхцөл байдалтай танилцаж цаашид тэтгэлгээр суралцах оюутнуудын тоог нэмэгдүүлэх, 2019 онд боловсролын чиглэлээр хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэн, энэ хүрээнд хийгдэж байсан ажлуудаа эрчимжүүлэн ажиллахаар боллоо.</p> <p>15. УИХ-ын гишүүн Х.Нямбаатар болон Засаг даргаар ахлуулсан баг ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн ажил мэргэжлийн цогцолбор сургуультай танилцан, туршлага судалж 2019 онд хамтарч ажиллахаар боллоо.</p> <p>16. Олон улсын боловсрол хөгжил сантай хамтран ажиллах гэрээ байгуулж, дүүргийн төрийн өмчийн 19, төрийн бус өмчийн 8 сургуулийн төгсөх ангийн сурагчдын дунд ерөнхий мэдлэгийн шалгалт явуулж нийт 25 сургуулийн 800 гаруй сурагч хамрагдсанаас мэдлэгээрээ тэргүүлсэн 150 хүүхэд БНХАУ-ын Их дээд сургуулиудад 30-100 хувийн тэтгэлгээр суралцах эрхээ авсан. Дүүргийн 65 дугаар сургуулийн сурагч Л.Багабанди тэргүүн байранд шалгарч 100 хувийн тэтгэлэг авч, 2 дугаар шатны шалгалтад тэнцсэн 20 сурагч 70 хувийн тэтгэлэг авсан бол бусад нь 30 хувийн тэтгэлгийн эзэн боллоо.</p> <p>17. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарын санаачилгаар 4 дэх жилдээ зохион байгуулагдаж байгаа “Дэлхийд өрсөлдөх Сонгинохайрханчууд” англи хэлний олимпиадад 690 орчим сурагч оролцож эхний 3 байрт орсон сурагчид Сингапурт суралцах тэтгэлгийн эзэн боллоо.</p>
--	--	---

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА А.БАТСАЙХАН

НЭГТГЭСЭН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Ө.НОРОВДЭМИД